



АЛЬ БОЛОХ ЭРТ ШАТНААС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ

**ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ХЭМ ХЭМЖЭЭ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ**

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

НАА 67
ДАА 340
Н-749

АЛЬ БОЛОХ ЭРТ ШАТНААС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ

**ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭ ЭРҮҮГИЙН
ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ**

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ БАГ:

Судалгааны багийн ахлагч: Н.Норовсамбуу, LL.M

Судлаачид: М.Цэнд-Очир, LL.M, Ж.Содномдаржаа, Өмгөөлөгч

Энэхүү судалгааг ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэн нийтлэв.

© Н.Норовсамбуу, М.Цэнд-Очир, Ж.Содномдаржаа, 2009 он

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-99978-803-8-3

АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	6
ХҮСНЭГТ, БҮДҮҮВЧ, ГРАФИКИЙН ТАЙЛБАР.....	6
УДИРТГАЛ.....	7
НЭГДҮГТЭЭР БҮЛЭГ. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА БОЛОН АЛЬ БОЛОХ ЭРТ ШАТНААС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТ.....	9
1.1 Хууль зүйн туслалцаа авах эрх, түүний олон улсын стандарт.....	9
1.2 Хууль зүйн туслалцаа авах эрхийг хэдий үеэс эдлэх боломжтой тухай.....	25
1.3.Хууль зүйн туслалцаа авах эрхээ эдэлсэн эсэхийг баримтжуулах.....	36
1.4.Бүлгийн дүгнэлт	44
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ БОЛОН АЛЬ БОЛОХ ЭРТ ШАТНААС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ ТУСГАГДСАН НЬ: ЗААВАЛ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ.....	47
2.1.Монгол Улсын хууль зүйн туслалцаа авах эрхийн зохицуулалт	47
2.3.Хууль зүйн туслалцаа авах эрхийн баталгаа	69
2.4.Бүлгийн дүгнэлт.....	74

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ.....	79
3.1. Нэгдсэн дүгнэлт	79
3.2. Бодлогын зөвлөмж.....	82
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	88
ХАВСРАЛТ-1. ЭХХША-д өмгөөлөгч, шүүгч, прокурор, мөрдөгчдийн оролцоо.....	91
ХАВСРАЛТ-2. Социологийн судалгааны үр дүн	113

ТАЛАРХАЛ

Сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж буй эрх зүйн шинэчлэлд судлаач бидний санал бодлыг тусгах боломжийг олгож, энэхүү судалгааг гүйцэтгэх, эрх зүйн судалгаа шинжилгээ тогтмол хийж өөрсдийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн Нээлттэй Нийгэм Форумын хамт олонд гүнээ талархаж буйгаа илэрхийлье.

Түүнчлэн, уг судалгааг гүйцэтгэхэд хамтарч ажилласан болон судалгаанд хамрагдсан нийт байгууллага, хувь хүмүүст туйлын ихээр талархаж буйгаа энд тэмдэглэе.

Судалгааны баг, 2019 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГ	Засгийн газар
МХХ	Монголын хуульчдын холбоо
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТЧЯҮХЗТХ	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль
ХЭЗБтХ	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭБШтХ	Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль

ХҮСНЭГТ, БҮДҮҮВЧ, ГРАФИКИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1	Хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан олон улсын баримт бичгийн зохицуулалт
Хүснэгт 2	Хууль зүйн туслалцаа авах эрхийг зайлшгүй эдлэх субъект
Хүснэгт 3	Япон Улсын туршлага
Хүснэгт 4	Заавал өмгөөлөгч оролцуулах тохиолдол
Хүснэгт 5	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн томилогдсон өмгөөлөгч оролцуулах тохиолдол
Хүснэгт 6	МХХ-ноос өмгөөлөгч томилон оролцуулсан тохиолдол
Хүснэгт 7	Төлбөрийн чадваргүй иргэнд тооцох үндэслэл
Хүснэгт 8	Хууль зүйн туслалцаа авах боломжит эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шат
Хүснэгт 9	Өмгөөлөгчийн эрх
Бүдүүвч 1	Хууль зүйн туслалцаа авах эрхийн агуулга
График 1	ХЭҮК-ийн судалгаа
График 2	ХЭҮК-ийн судалгаа

УДИРТГАЛ

Манай улс сүүлийн жилүүдэд Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг тус тус шинэчлэн орчин үеийн эрх зүйн чиг хандлагыг тусган хөгжүүлж байгаа билээ. Энэхүү судалгааны судлагдахуун болсон хууль зүйн туслалцаа авах эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар хүн бүрт зайлшгүй эдлүүлэх үүргийг төр хүлээдэг. Гэхдээ уг үндсэн эрхийг бодит амьдралд хэрэгжүүлэх, эдлүүлэх үндсэн хөрс бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ) байдаг. Иймээс ЭХХШТХ болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (ЭБШТХ)-ийн зохицуулалтуудыг олон улсын эрх зүйн баримт бичиг, жишиг зохицуулалтуудтай харьцуулах байдлаар уг судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүний дотор хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломж бүрдсэн эсэх, мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах боломж, бололцоог хэрхэн хангасан гэдэгт ач холбогдол өгч судалсан болно. Учир нь эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн дараа дараагийн эрхээ эдлэх, хамгаалах суурь нөхцөл болдог.

Ийнхүү эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах талаар нарийвчлан судлах болсон шалтгаан нь эрүүгийн хэрэгт холбогдсон болоод ямар нэгэн байдлаар оролцогч болж байсан иргэд, мөн өмгөөлөгчдийн дунд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль зүйн туслалцаа авах эрхээ хангалттай хэмжээнд эдэлж чадахгүй байна гэсэн яриа гаргах болсонтой холбоотой. Үүнээс болоод иргэд хохирох явдал элбэг тохиолддог гэсэн ам дамжсан яриа, хардалт, таамаглал байдаг. Энэ нь зөвхөн хардалт, таамаг төдий зүйл ч биш гэдгийг олон улсын хүний эрхийн байгууллагуудаас гаргасан судалгаа, тайлан мэдээнд хангалттай олон дурдагдсан нь бий. Хамгийн сүүлийн үеийн эх сурвалж гэвэл Хүний эрхийг комиссоос жил бүр гаргадаг хүний эрхийн 2016 оны тайланд эрүү шүүлт тулгах, хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэхгүй байх зэрэг зөрчил нийтлэг байгаа нь цагдан хоригдож

буй иргэдийн дунд явуулсан судалгааны үр дүнгээс илэрхий болсон.

Тиймээс бодит байдалд хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх, тэр дундаа эрт шатнаас эдлүүлэх нь дутагдалтай байгаа нөхцөлд 2017 оны шинэ ЭХХШтХ-д аль болох эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрхэн зохицуулсан болохыг судалж тодорхой дүгнэлт, зөвлөмж гаргах зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна. Хэдийгээр өмнөх эрүүгийн процессын хуулиудаас дэвшилттэй зохицуулалтууд тусгагдсан, илүү хүний эрхэд суурилсан, хүний эрхийг эдлүүлэх, хамгаалах, сэргээхэд чиглэсэн хэмээн хууль санаачлагч, төсөл боловсруулагчдын зүгээс удаа дараа мэдэгдэж байгаа ч хууль хэрэгжсэнээс эхлээд хууль тогтоогч, судалгааны болон хэрэгжүүлэгч байгууллагуудын зүгээс өөрчлөх, шинэчлэх асуудлыг хурцаар хөндөх болоод байна.

Иймд олон улсын эрх зүйн хэм хэмжээ болоод жишиг баримт бичгүүдэд эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах боломжийг хэрхэн бүрдүүлэх талаар судалж, түүнийгээ Монгол Улсын шинэ ЭХХШтХ-ийн зохицуулалтай харьцуулан судалж дүгнэн, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлаар бодлогын зөвлөмж боловсруулав.

-НЭГДҮГЭЭР БҮЛЭГ-

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА БОЛОН АЛЬ БОЛОХ ЭРТ ШАТНААС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

1.1 ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ, ТҮҮНИЙ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

2012 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх зарчим, удирдамжийг (United Nations Principles and Guidelines on Access to Legal Aid in Criminal Justice Systems)” (цаашид НҮБ-ын удирдамж гэх) батлан гаргасан. Тус баримт бичгийн хоёр дахь зарчимд “Хууль зүйн туслалцаа үзүүлэх явдлыг өөрийн үүрэг, хариуцлага гэж үзэх ёстой бөгөөд үүний тулд чанартай (credible), тогтвортой (sustainable), үр нөлөөтэй (effective), хүртээмжтэй (accessible) цогц хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог хууль, тогтоомж батлах замаар бий болгох ёстой” гэж тусгасан. НҮБ-ын гишүүн улс орнууд иргэдийнхээ эрхийг хамгаалах тогтолцоог бий болгохдоо дээр дурдсан чанартай, тогтвортой, хүртээмжтэй зэрэг шинжийг хангасан цогц хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгох үүрэгтэй.

Монгол Улс нь НҮБ-ын гишүүний хувьд, мөн Үндсэн хуульдаа ч иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээхээр тунхагласан. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрхэн тусгасан талаар тоймлон авч үзье.

Хүснэгт 1. Хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан олон улсын баримт бичгийн зохицуулалт

№	Баримт бичиг	Агуулга
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал Universal Declaration of Human Rights	§11.1. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.
2	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт ¹ International Covenant on Civil and Political Rights	§14.3. Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараах наад захын баталгаагаар хангагдах эрхтэй: (b) өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгөө харилцах ² ; (d) хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд биечлэн оролцох, өөрийгөө өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх (legal assistance); өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг (the interests of justice) шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх ³ ;

үргэлжлэл ►

- ¹ Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пактын уг зохицуулалт нь Европын хүний эрхийн конвенц (6-р зүйл 3 (с)), Америкийн хүний эрхийн конвенц (8-р зүйл 2 дахь хэсэг), Арабын хүний эрхийн харт (16-р зүйл), Африкийн хүний эрхийн харт (7-р зүйл 1 (с)) гэсэн бүсийн хүний эрхийг хамгаалах баримт бичгүүдэд мөн тусгалаа олжээ.
- ² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт:14.3(b) To have adequate time and facilities for the preparation of his defence and to communicate with counsel of his own choosing.
- ³ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт:14.3(d) To be tried in his presence, and to defend himself in person or through legal assistance of his own choosing; to be informed, if he does not have legal assistance, of this right; and to have legal assistance assigned to him, in any case where the interests of justice so require, and without payment by him in any such case if he does not have sufficient means to pay for it.

3	Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд ⁴	<p>§1. Хүн бүр өөрийн эрхийг хамгаалахын тулд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд тусламж авахаар ямар ч хуульчид хандах эрхтэй.</p>
	Basic Principles on the Role of Lawyers	<p>§2. Төрөөс өөрийн газар нутаг, шүүх эрх мэдэлд хамаарч буй бүх хүнд аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр ижил хүртээмж, үр нөлөөтэй байдлаар хуульчийн туслалцаа авах үр дүнтэй процедур (efficient procedures) болон хариуцлагатай механизмууд (responsive mechanisms)-ыг бий болгох ёстой.</p>
		<p>§3. Төрөөс ядуу болон бусад шаардлага байгаа эсхүл нийгмийн эрсдэлд өртөмтгий бүлэгт (disadvantaged persons) хамаарах хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ хангалттай хөрөнгө болон бусад нөөц баялгаар хангах үүрэгтэй. Мэргэжлийн хуульчдын холбоо нь үүнд зохион байгуулалт болон үйлчилгээ, арга, хэрэгсэл болон бусад нөөц баялгаар хангах замаар хамтран ажиллана.</p>
		<p>§4. Төр болон мэргэжлийн хуульчдын холбоо нь олон нийтэд тэдний хуульд заасан эрх, үүрэг болон үндсэн эрхийг эрхийг хамгаалахад хуульчийн гүйцэтгэх үүрэг ролийн ач холбогдлын тухай мэдээлэх хөтөлбөрийг дэмжинэ. Ядуу болон бусад нийгмийн эрсдэлд өртөмтгий бүлэгт тэднийг эрхээ эдлэхэд нь туслах, хаана хуульчдын туслалцаа хэрэгтэй байгаад онцгой анхаарал хандуулах шаардлагатай.</p>
		<p>§13. Хуульч нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулах замаар тодорхой үүрэг, хариуцлага хүлээхийн зэрэгцээ өөрийн үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах, үндэсний төдийгүй олон улсын эрх зүйгээр тогтоосон хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хуульчийн мэргэжлийн ёс зүйн дагуу хараат бусаар, өөрийн итгэл үнэмшлийн дагуу үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.</p>

⁴ Куба Улсын Гавана хотноо 1990 оны 8-р сарын 27-ноос 9-р сарын 7-ны өдрүүдэд хуралдсан “Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх” НҮБ-ын VIII их хурлаас баталсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн гурав дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн зохицуулсны дагуу Монгол Улсын хуулийн нэгэн адил үйлчлэх хэм хэмжээ юм. Дээр дурдсан олон улсын баримт бичигт заасан агуулгаас хууль зүйн туслалцаа авах эрхийг төрөөс хангах талаас нь дараах хоёр агуулгаар ялган авч үзэж болох юм. Үүнд:

Нэгд, тухайн гэмт хэрэгт холбогдсон этгээд өөрөө хууль зүйн туслалцаа авах эрхээ бие даан эдлэх боломжтой нөхцөлд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломж нөхцөлийг бүрдүүлж өгөх.


Хоёрт, тухайн гэмт хэрэгт холбогдсон этгээдийн эдийн засаг, санхүү, нийгмийн байдал, хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан төрөөс зайлшгүй хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, эдлүүлэх тогтолцоог бүрдүүлэх үүрэг хүлээх тохиолдол байдаг. Учир нь хууль, эрх зүйн хангалттай мэдлэггүй, мөн санхүүгийн чадамжгүй, сэтгэц мэдрэл бусад байдлаар бусад этгээдээс дутмаг, мөн хүнд ял шийтгэл эдэлж болзошгүй этгээдэд төрөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх тогтолцоог бүрдүүлж өгөхгүй бол тухайн этгээд эрхээ эдлэх бодит боломжгүйн улмаас хохирох эрсдэлтэй.

Мөн нэр томьёоны үүднээс авч үзвэл “хууль зүйн туслалцаа авах (legal aid⁵)” гэж гэрч, хохирогч болон гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, сэжиглэгдэж, хоригдож, баривчлагдаж, саатуулагдаж буй этгээд төлбөрийн чадваргүй эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ашиг сонирхлын (the interests of justice) үүднээс шаардлагатай байгаа бол үнэ төлбөргүйгээр тухай этгээдэд хууль

⁵ the term “legal aid” includes legal advice, assistance and representation for persons detained, arrested or imprisoned, suspected or accused of, or charged with a criminal offence and for victims and witnesses in the criminal justice process that is provided at no cost for those without sufficient means or when the interests of justice so require. / UN Principles and Guidelines on Access to Legal Aid in Criminal Justice Systems,.Annex- 8/

зүйн зөвлөгөө⁶, өмгөөлөх⁷, төлөөлөхийг⁸ ойлгохоор тусгасан. Харин “Legal assistance” гэж гэмт хэрэгт холбогдсон этгээд өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх тухай юм.

Бүдүүвч 1. Хууль зүйн туслалцаа авах эрхийн агуулга



Эндээс авч үзвэл “legal aid” буюу хууль зүйн туслалцаа авах тухай ойлголт нь илүү өргөн хүрээтэй бөгөөд төрийн оролцоотойгоор хэрэгжих нь харагдаж байна.

⁶ Хууль зүйн зөвлөгөө /Legal advice/ нь зөвлөгөө авагчийн нөхцөл байдалд ямар хууль хэрэглэгдэх, зохистой ямар үйлдэл хийж болох талаарх зөвлөгөөг хэлнэ.

⁷ Туслалцаа үзүүлэх /Assistance/ нь хийж болох зохистой үйлдлийг хийхэд гэмт хэрэгт холбогдсон этгээдэд туслах, эсвэл түүний өмнөөс хийх тухай юм.

⁸ Төлөөлөх /Representation/ нь шүүх, прокурор, бусад этгээдийн өмнө зөвлөгөө авсан этгээдийн өмнөөс тэднийг хамгаалахыг хэлнэ.

1.1.1. Хууль зүйн туслалцаа авагчийн эрх

2017 онд НҮБ-ын Мансууруулах бодис ба гэмт хэрэгтэй тэмцэх газраас “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт үеэс хууль зүйн туслалцаа үзүүлэх загвар хууль, түүний тайлбар”⁹-ыг гаргажээ. Тус загвар хуулийн 12-р зүйлийн 1 дэх хэсэгт хууль зүйн туслалцаа авагч дараах эрхтэй байхаар зааж өгсөн. Үүнд:

- Хууль зүйн туслалцаа авахдаа ялгаварлан гадуурхагдахгүй байх;
- Хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх хүсэлт гаргасан боловч хязгаарласан, татгалзсан, хойшлуулж удаашруулсан тохиолдолд зохих хамгаалалт, эрх сэргээхийг шаардах эрх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л шатанд үр дүнтэй хууль зүйн туслалцааг нэн даруй (яг цагт нь) авах эрх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л шатанд аливаа мөрдөн шалгах албан тушаалтанд мэдүүлэг өгөх үедээ хууль зүйн туслалцаа үзүүлэгч (өмгөөлөгч)-тэйгээ хамт байх эрх;
- Өөрийн эрх, нэр төрөө хууль зүйн туслалцаа үзүүлэгчээр хамгаалуулж, туслуулах эрх;
- Хууль зүйн туслалцаа үзүүлэгчтэй итгэлтэйгээр харилцах, зөвлөлдөх боломжоор хангагдах;
- Хууль зүйн туслалцаа авсны зардлыг шүүхийн зардлаас хасуулах эрх.

⁹ United Nations Office on Drugs and Crime (2017) Model Law on Legal Aid in Criminal Justice Systems with Commentaries

1.1.2. Хууль зүйн туслалцааг заавал эдлүүлэх тохиолдол, харьцуулсан судалгаа (ХБНГУ, Япон Улсын жишээн дээр)

НҮБ-ын удирдамжид хууль зүйн туслалцаа авах эрх, түүнийг зайлшгүй эдлэх субъектүүдийн жагсаалтыг гаргасан байдаг (Хүснэгт 2-ыг харна уу).

Хүснэгт 2. Хууль зүйн туслалцаа авах эрхийг зайлшгүй эдлэх субъект

№	СУБЪЕКТ	ЗААЛТ
1	Цаазаар авах ял эсвэл хорих ялаар шийтгэгдэх боломжтой хэргийн субъект	“Төрөөс цаазаар авах ял эсвэл хорих ялаар шийтгэх боломжтой гэмт хэрэгт холбогдон хоригдсон, баривчлагдсан, сэжиглэгдсэн, шалгагдаж буй этгээдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг нь эдлүүлнэ” ¹⁰
2	Хэрэг хянан шийдвэрлэх ашиг сонирхлын үүднээс хууль зүйн туслалцаа авах шаардлагатай этгээд (the interests of justice so require)	“Төлбөрийн чадварыг үл харгалзан хэрэг хянан шийдвэрлэх ашиг сонирхлын үүднээс тухайлбал, хүнд ял оноох магадлалтай эсвэл хэрэг нарийн төвөгтэй, яаралтай бол хууль зүйн туслалцаагаар хангуулна” ¹¹ .
3	Насанд хүрээгүй этгээд	“Насанд хүрээгүй этгээдэд насанд хүрсэн этгээдэд олгох нөхцөлтэй ижил юм уу, эсвэл илүү хөнгөн нөхцөлөөр хууль зүйн туслалцаа үзүүлнэ” ¹²
4	Төлбөрийн чадваргүй болоод эмзэг бүлгийн хүмүүс	“Өмгөөлөгч авах төлбөрийн чадваргүй, эсвэл эмзэг хүмүүсийг хууль зүйн туслалцаагаар хангах арга хэмжээ авах нь мөрдөгч, прокурор, шүүгчийн үүрэг байна” ¹³ .

¹⁰ НҮБ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх зарчим, удирдамж”, А/67/458, пара. 20.

¹¹ Мөн тэнд, пара. 21.

¹² Мөн тэнд, пара. 22.

¹³ Мөн тэнд, пара. 23.

**Хууль зүйн туслалцааг заавал эдлүүлэх тохиолдол, хэрхэн процессын хуульд туссан талаарх харьцуулсан судалгаа:
ХБНГУ, Япон Улс**

ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон этгээд аль үе шатнаас хууль зүйн туслалцаа авах талаар тодорхой тусгаж өгчээ. Тус хуулийн 137-р зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэгт шалгагдаж буй этгээд нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авч болно” гэж заасан байна.

Мөн тус хуулийн 140-р зүйлийн 1 дэх хэсэгт дараах байдлаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгч оролцуулах тохиолдлыг зааж өгчээ. Үүнд:

- Орон нутгийн шүүх эсвэл давж заалдах шүүх шийдвэрлэх хэрэг бол;
- Хорих ялаар шийтгэх гэмт хэрэгт холбогдсон бол;
- Тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хориглох ял оноохоор бол;
- 112, 112а-р зүйлийн дагуу цагдан хорьсон, 126а, 257а.6 дахь хэсэгт заасны дагуу албадан эмнэлгийн байгууллагад хоригдсон бол;
- Шүүхийн шийдвэрээр 3 сарын турш албадан эмчлүүлсэн, эсвэл шүүх хуралдаан болохоос өмнө 2 долоо хоногийн өмнө шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх байгууллагаас чөлөөлөгдөөгүй бол;
- 81-р зүйлд заасны дагуу сэтгэцийн нөхцөл байдлаас нь шалтгаалан албадан эмчилж байгаа бол;
- Урьдчилан сэргийлэх зорилгоор цагдан хорьсон бол;
- Өмнөх өмгөөлөгчийг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахыг хориглосон шийдвэр гарсан бол тус тус өмгөөлөгч оролцуулахаар хуульчилжээ.

Үүний дараагаар тус хуулийн 141-р зүйлийн 1 дэх хэсэгт “140-р зүйлд заасан тохиолдолд гэмт хэрэгт шалгагдаж буй этгээд өмгөөлөгчгүй байгаа бол түүнд даруй өмгөөлөгч томилно” гэж мөн хуульчилжээ. Эндээс авч үзэхэд ХБНГУ-д бүхий л үе шатанд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй ба өмгөөлөгч зайлшгүй оролцуулах тохиолдлыг маш өргөн хүрээнд хуульчилсан байна. Хуульд заасан тохиолдолд өмгөөлөгчгүй байвал даруй өмгөөлөгч томилон, өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг нь эдлүүлдэг ажээ.

Япон Улсын тогтолцоонд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцаа авах эрхийг дараах байдлаар зохицуулсан байна. Ер нь Япон Улсад “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түүх бол өмгөөлүүлэх эрхийг баталгаажуулах түүх”¹⁴ гэж үзэгддэг байна.

Хүснэгт 3. Япон Улсын туршлага

№	Эрх зүйн эх сурвалж	Агуулга
1	Үндсэн хууль	<p>§34.1 Хэнд ч шалтгаан үндэслэлийг тэр даруй мэдэгдээгүй бөгөөд тэр даруй өмгөөлөгч авах эрхийг нь эдлүүлээгүй бол баривчилж эсвэл цагдан хорьж болохгүй.</p> <p>§37.3 Гэмт хэрэгт яллагдагч ямар ч тохиолдолд мэргэжлийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхтэй. Яллагдагч өөрөө өмгөөлөгч хөлслөн авч чадахгүй бол улсаас өмгөөлөгчийг томилно.</p>
2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	<p>§30.1 Яллагдагч, сэжигтэн нь аль ч үед өмгөөлөгч сонгон авах эрхтэй.</p> <p>§30.2 Яллагдагч, сэжигтний хууль ёсны төлөөлөгч, туслагч, эхнэр, нөхөр, шууд холбоотой төрөл, садан болон ах, дүү нь тусдаа өмгөөлөгч сонгон авч болно.</p> <p>§31.1 Өмгөөлөх этгээдийг өмгөөлөгчдийн дундаас сонгон авна.</p>

үргэлжлэл ►

¹⁴ 刑事訴訟の歴史は、弁護権拡大の歴史である。

§31.2 Хялбаршуулсан шүүх, эсвэл орон нутгийн шүүхэд шүүхийн зөвшөөрлөөр өмгөөлөгч бус этгээдийг өмгөөлөгчөөр сонгон авч болно. Гэхдээ орон нутгийн шүүхэд өөр өмгөөлөгчдийн дундаас сонгон авсан өмгөөлөгч байгаа тохиолдолд л өмгөөлөгч бус этгээдийг өмгөөлөгчөөр оролцуулж болно.

§312.1 Өмгөөлөгч сонгон авах гэж буй сэжигтэн, ялагдагч нь өмгөөлөгчдийн холбоонд хандан өмгөөлөгчийг сонгон авах хүсэлтээ гаргана.

§312.2 Өмгөөлөгчдийн холбоо нь өмнөх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд нэн даруй өмгөөлөгчдийн дундаас өмгөөлөгчийн хувиар оролцохыг хүссэн этгээдийг санал болгоно.

§312.3 Өмгөөлөгчдийн холбоо нь өмнөх хэсэгт зааснаар өмгөөлөгч болохыг хүссэн этгээд байхгүй бол тухайн хүсэлт гаргасан этгээдэд нэн даруй энэ тухай мэдэгдэх үүрэгтэй. Өмнөх хэсгийн заалтын дагуу санал болгосон өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгч сонгон авах хүсэлтээс татгалзсан бол нэгэн адил байна.

Үндсэн хуулийн 37-р зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар яллагдагч ямар ч үед өмгөөлөгч авах эрхтэй. Яллагдагч (被告人) нь эрүүгийн хэрэг үүсгэсний дараа тус хэрэгт хариуцагчаар татагдсан этгээд юм. Сэжигтний хувьд Үндсэн хуулийн 34-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүн бие махбодын эрх чөлөөгөө хязгаарлуулсан буюу баривчлагдсан, эсвэл цагдан хоригдсон тохиолдолд л өмгөөлөгч авах эрх нээгдэхээр хуульчилжээ. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 30-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар сэжигтэн нь аль ч үед өмгөөлөгч сонгон авах эрхтэй. Үндсэн хуулийн 34-р зүйлийн 1 дэх заалттай харьцуулахад ЭХХШТХ-ийн уг заалт сэжигтэн нь эрүүгийн хэрэг үүсгэсэн эсэх, бие махбодын эрх чөлөөгөө хязгаарлуулсан эсэхээс үл хамааран өмгөөлөгч сонгон авах эрхтэй болсноор уг эрхийг улам өргөжүүлсэн юм. Сэжигтэн (被疑者) гэж гэмт хэрэгт сэрдэгдэн, эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө мөрдөн шалгах байгууллагаар шалгагдаж буй этгээдийг хэлдэг.

Япон Улсын Үндсэн хуулийн 37-р зүйлийн 3 дахь хэсэгт “Яллагдагч өөрөө өмгөөлөгч хөлслөн авч чадахгүй бол улсаас өмгөөлөгчийг томилно” гэж зааснаар Үндсэн хуулийн түвшинд

улсаас яллагдагчид л өмгөөлөгч томилон өгөхөөр хуульчилжээ. Томилогдсон өмгөөлөгчийг улсаас сонгосон өмгөөлөгч (国選弁護人) гэж нэрлэдэг. Харин сэжигтэн нь төлбөрийн чадваргүй болон бусад шалтгааны улмаас өмгөөлөгч сонгон авах боломжгүй тохиолдолд улсаас өмгөөлөгч олгох талаар эрх зүйн үндэслэл байхгүй байсан хэдий ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт үе шатнаас хууль зүйн туслалцаа авах хэрэгцээ шаардлагын улмаас 2004 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн нэмэлт өөрчлөлтөөр баривчлагдсан, цагдан хоригдсон сэжигтэн нь төлбөрийн чадваргүй болон бусад шалтгааны улмаас өмгөөлөгч сонгон аваагүй бол улсаас өмгөөлөгч томилон өгөх эрх зүйн зохицуулалт бий болгожээ.

Яллагдагчийн томилогдсон өмгөөлөгч (被告人国選弁護)

Яллагдагч хариуцагчаар татагдсан хэрэг нь зайлшгүй өмгөөлөгч оролцуулах ёстой хэрэг (必要的弁護事件), сайн дураар өмгөөлөгч оролцуулах хэрэг (任意的弁護事件) эсэхээс хамаараад журам нь өөр юм.

Заавал өмгөөлөгч оролцуулах шаардлагатай хэрэг (必要的弁護事件)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 289-р зүйлийн 1 дэх хэсэгт “Цаазаар авах, хугацаагүй эсвэл 3 жилээс дээш хугацаагаар хорих, эсвэл гянданд хорих ялтай хэрэг хянан шийдвэрлэх тохиолдолд өмгөөлөгч байхгүй бол хэргийг хэлэлцэж болохгүй” гэж хуульчилсан. Тус зүйлийн 2 дахь хэсэгт уг тохиолдолд өмгөөлөгч шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй, оролцоогүй эсвэл өмгөөлөгч байхгүй бол шүүх өөрийн санаачилгаараа өмгөөлөгч томилно, тус зүйлийн 3 дахь хэсэгт өмгөөлөгч хүрэлцэн ирэхгүй байж болзошгүй байгаа бол шүүх өөрийн санаачилгаараа өмгөөлөгч томилно гэж тус тус хуульчилжээ. Эндээс зайлшгүй өмгөөлөгч оролцуулах ёстой хэрэгт цаазаар авах, хугацаагүй эсвэл 3 жилээс дээш хугацаагаар хорих ялтай хэрэг хамаарахаар байна. Уг төрлийн хэрэгт шалгагдаж буй яллагдагч өөрөө өмгөөлөгч сонгон аваагүй л бол өмгөөлөгч сонгон авах хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран төрөөс өмгөөлөгч томилогдоно.

Сайн дураар өмгөөлөгч оролцуулах хэрэг (任意的弁護事件)

Нөгөө талаас, сайн дураар өмгөөлөгч оролцуулах хэрэгт яллагдагч улсаас өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргахдаа өөрийн төлбөрийн чадварын мэдүүлэг (資力申告書) гаргана. Төлбөрийн чадвар нь Засгийн газраас тогтоосон стандарт хэмжээнд хүрэхгүй бол тухайн өмгөөлөгч томилуулах хүсэлтээ гаргаж болно.

§36.1 Яллагдагч нь төлбөрийн чадваргүй болон бусад шалтгааны улмаас өмгөөлөгч сонгон авах боломжгүй бол шүүх нь түүний хүсэлтээр ялагдагчид өмгөөлөгч томилно. Гэхдээ хариуцагчаас өөр этгээд сонгон авсан өмгөөлөгч байгаа бол энэ нь хамаарахгүй.

§362.1 Энэ хуульд заасан өмгөөлөгч шаардлагатайгаас бусад тохиолдолд яллагдагч нь өмнөх зүйлийн хүсэлтийг гаргахдаа төлбөрийн чадварын тухай мэдүүлэг (тухайн этгээдэд байгаа бэлэн мөнгө, хадгаламж болон бусад Засгийн газрын захирамжид заасан эдгээртэй дүйцэх хөрөнгийн нийлбэр хэмжээгээр төлбөрийн чадварыг тодорхойлно.) гаргана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Харин төлбөрийн чадвар нь Засгийн газраас тогтоосон стандарт хэмжээг давж байвал эхлээд өмгөөлөгчдийн холбоонд өмгөөлөгч сонгон авах хүсэлт гаргана. Өмгөөлөгчдийн холбоонд тухайн хэрэгт өмгөөлөгч болохыг хүссэн этгээд байхгүй, өмгөөлөгчийн холбооноос санал болгосон өмгөөлөгч нь өмгөөлөхөөс татгалзсан бол яллагдагч улсаас өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргаж болно.

§363.1 Энэ хуульд заасан өмгөөлөгч шаардлагатайгаас бусад тохиолдолд төлбөрийн чадвар нь стандарт хэмжээ (дундаж амьжиргааны шаардлагатай зардлыг тооцон, ердийн өмгөөлөгчийн хөлс болон зардлыг төлөхөд хангалттай гэж засгийн газрын захирамжаар тогтоосон хэмжээг хэлнэ.)-ээс их байгаа яллагдагч нь 36-р зүйлд заасан хүсэлтийг гаргахдаа урьдчилан тухайн хүсэлтийг гаргах шүүх оршин байх газрыг харьяалах орон нутгийн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрийн дотор байрлах өмгөөлөгчдийн холбоонд 312-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг гаргана.

§363.2 Өмнөх хэсгийн заалтын дагуу 312-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авсан өмгөөлөгчийн холбоо нь 312-р зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэн бол өмнөх хэсгийн орон нутгийн шүүх, эсвэл тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж буй шүүхэд энэ тухай мэдэгдэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Хуульд заасан онцгой тохиолдол

Түүнчлэн яллагдагч насанд хүрээгүй бол, яллагдагч нь 70-аас дээш настай гэх мэт тусгайлан хамгаалалт шаардлагатай этгээдэд бол шүүх өөрийн санаачилгаараа өмгөөлөгч томилно.

Сэжигтний томилогдсон өмгөөлөгч (被疑者国選弁護)

§37.1 Яллагдагчид өмгөөлөгч байхгүй бол шүүх нь санаачилгаараа өмгөөлөгч томилж болно.

§37.1.1 Яллагдагч насанд хүрээгүй бол:

§37.1.2 Яллагдагч нь 70 насанд хүрсэн бол;

§37.1.3 Яллагдагч нь дүлий, хэлгүй этгээд бол;

§37.1.4 Яллагдагч нь оюун ухааны хомсдолтой этгээд болох нь эргэлзээгүй бол;

§37.1.5 Бусад шаардлагатай гэж үзсэн тохиолдолд

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Уг тогтолцоо 2004 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн нэмэлт өөрчлөлтөөр орж ирсэн бөгөөд хэрэг үүсгэхээс өмнөх мөрдөн шалгах шатанд сэжигтэнд бодитоор хууль зүйн туслалцаа авах эрхээр хангагдах боломжийг бий болгосон тогтолцоо юм. Хуулиар тогтоосон ял нь цаазаар авах, хугацаагүй болон гурваас дээш жилээр хорих, эсвэл гянданд хорих ялтай хэрэгт сэжигтнийг цагдан хорих шийдвэр гарсан тохиолдолд сэжигтэн ядуу болон бусад шалтгааны улмаас хувиараа өмгөөлөгч сонгон авах боломжгүй бол шүүгчид хандан улсаас өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргаж болно.

§37².1 Цаазаар авах, бүх насаар нь болон 3 жилээс дээш хорих ял, гянданд хорих ялтай хэрэгт яллагдагчид цагдан хорих шийдвэр гарсан тохиолдолд ялагдагч ядуу болон бусад шалтгааны улмаас өмгөөлөгч сонгон аваагүй бол шүүх нь түүний хүсэлтээр ялагдагчид өмгөөлөгч томилно. Гэхдээ яллагдагчаас өөр этгээд өмгөөлөгч сонгон авсан байгаа тохиолдолд, эсвэл яллагдагч суллагдсан бол энэ нь хамаарахгүй.

§37².2 Өмнөх хэсэгт заасан хүсэлтийг уг хэсэгт заасан хэрэгт цагдан хорих санал ирүүлсэн сэжигтэнд мөн адил байна.

§37^{3.1} Өмнөх зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт гаргахдаа төлбөрийн чадварын мэдүүлэг гаргана.

§37^{3.2} Төлбөрийн чадвар нь стандарт хэмжээнээс их байгаа сэжигтэн нь өмнөх зүйлийн 1 дэх хэсгийн шаардлага гаргахдаа урьдчилан цагдан хорих шаардлага хүлээн авсан шүүгчийн харьяалагддаг шүүхийн оршин байгаа газрын харьяалах орон нутгийн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт байх өмгөөлөгчдийн холбоонд 312-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг гаргана.

§37^{3.3} Өмнөх хэсгийн заалтын дагуу 312-р зүйлийн 1 дэх хэсгийн өргөдлийг хүлээн авсан өмгөөлөгчдийн холбоо нь 312-р зүйлийн 3 дахь хэсгийн заалтад заасан мэдэгдэл гаргасан бол өмнөх хэсгийн орон нутгийн шүүхэд энэ тухай мэдэгдэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Баривчлагдсан үеэс бус цагдан хоригдох шийдвэр гарсан үеэс хуульд заасан нөхцөлийг хангавал улсаас өмгөөлөгч томилуулах эрх сэжигтэнд олгогджээ. Сэжигтнийг баривчлах хугацаа 72 цаг байна. Улсын өмгөөлөгч томилох үеийг баривчилсан үеэс тогтоогоогүй нь уг хугацааны дотор улсаас өмгөөлөгч томилох ажиллагааг явуулахад хүндрэлтэй гэж үзсэн байна. Түүнчлэн сэжигтний хүсэлт шаардлагагүйгээр шүүгч улсаас өмгөөлөгч томилох тохиолдлыг мөн хуульчилж өгчээ.

§374.1 Шүүгч нь 372 –р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгт сэжигтнийг цагдан хорих шийдвэр гарсан бөгөөд өмгөөлөгч байхгүй тохиолдолд сэтгэцийн дутагдал болон бусад шалтгааны улмаас өмгөөлөгч шаардлагатай эсэх талаар шийдвэр гаргах боломжгүй гэсэн эргэлзээ байгаа сэжигтэнд шаардлагатай гэж үзвэл санаачилгаараа өмгөөлөгч томилж болно. Гэхдээ сэжигтэн суллагдсан бол энэ заалт хамаарахгүй.

§375.1 Шүүгч нь цаазаар авах эсвэл бүх насаар нь хорих болон гянданд хорих гэмт хэрэгт 372 –р зүйлийн 1 дэх хэсэг болон өмнөх зүйлийн дагуу өмгөөлөгч томилох тохиолдол, эсвэл томилогдсон тохиолдолд онцгой шаардлагатай гэж үзвэл санаачилгаараа дахин өмгөөлөгч нэгийг томилж болно. Гэхдээ сэжигтэн суллагдсан тохиолдолд энэ нь хамаарахгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Улсаас өмгөөлөгч томилох тогтолцоог хэрэгжүүлэх байгууллага, өмгөөлөгч томилох журам

Улсаас өмгөөлөгч томилох эрхийг хэрэгжүүлдэг байгууллага нь шүүх мөн боловч 2006 онд “Японы хууль зүйн туслалцааны төв

(日本司法支援センター)” байгуулагдсанаар шүүх зөвхөн өмгөөлөгчийг томилох болон чөлөөлөх чиг үүргийг гүйцэтгэх болж бусад чиг үүрэг, менежментийг тус төв хэрэгжүүлэх болсон. Тус төв 2004 оны Хууль зүйн туслалцааны ерөнхий хууль (総合法律支援法 - Comprehensive Legal Support Act)-д үндэслэн байгуулагдсан.

Шүүх, даргалагч шүүгч болон бусад шүүгч нь улсаас өмгөөлөгч томилохоор бол Хууль зүйн туслалцааны төвд хандан улсаас томилогдсон өмгөөлөгчөөр ажиллах этгээдийг нэр дэвшүүлэн мэдэгдэх тухай хүсэлт явуулна. Тус төв нь уг хүсэлтийг хүлээн авсан бол даруй улсаас томилогдсон өмгөөлөгчөөр ажиллахаар гэрээ байгуулсан өмгөөлөгч нарын дундаас нэр дэвшүүлж, шүүхэд мэдэгдэнэ. Тус төв улсаас томилогдсон өмгөөлөгчийг томилж, ажил үүргийг гүйцэтгүүлнэ.

§38.1 Шүүх, даргалагч шүүгч болон бусад шүүгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, эсвэл насанд хүрээгүй этгээдийн хуулийн заалтын дагуу улсаас өмгөөлөгч томилохоор бол туслалцааны төвд хандан улсаас томилогдох өмгөөлөгчид нэр дэвшигчийн нэрийг зааж мэдэгдэх хүсэлт гаргана.

§38.2 Туслалцааны төв нь өмнөх хэсгийн заалтын дагуу хүсэлт гаргасан бол даруй улсаас томилогдохоор гэрээ байгуулсан өмгөөлөгч нарын дундаас улсаас томилогдох өмгөөлөгчийн нэрийг зааж шүүх, даргалагч шүүгч болон бусад шүүгчид мэдэгдэнэ.

§38.3 Туслалцааны төв нь гэрээ байгуулсан өмгөөлөгчдийн дундаас улсаас томилогдох өмгөөлөгчийн чиг үүргийг гүйцэтгүүлнэ.

Хууль зүйн туслалцааны ерөнхий хууль

Тус төв болон улсаас томилогдох өмгөөлөгчийн хоорондын харилцааны хувьд өмгөөллийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах шаардлагатай ба үүнийг дараах байдлаар зохицуулжээ.

§12.1 Энэ хуулийг хэрэглэхэд өмгөөлөгч болон холбогдох хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн онцлог шинжийг байнга харгалзан үзнэ.

§33.1 Гэрээт өмгөөлөгчийг тус төвөөс 30-р зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсэгт заасан ажил үүргээ гүйцэтгэхдээ бие даан үйл ажиллагаа явуулна.

Хууль зүйн туслалцааны ерөнхий хууль

Ийнхүү төвийг өмгөөлөгчдийн бие даасан үйл ажиллагаанд оролцохыг хориглодог байна.

Томилогдсон өмгөөлөгчийн хөлс: Өмгөөлөгчийн хөлсийг дараах байдлаар зохицуулжээ.

§38.1 Энэ хуульд заасны дагуу шүүх, шүүх хуралдаан даргалагч, шүүгч нь өмгөөлөгч томилохдоо өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн дундаас томилно.

§38.2 Өмнөх хэсгийн заалтын дагуу томилогдсон өмгөөлөгч нь унаа, байр, хоолны зардал болон хөлсөө шаардаж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын тухай хууль (刑事訴訟費用等に関する法律 - Act on Costs of Criminal Procedure)

§21.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 38-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан өмгөөлөгчид олгох унаа, хоол, байрны зардал болон өмгөөллийн хөлс нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд хамаарна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Улсаас томилогдсон өмгөөлөгчийн хөлс бусад зардал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхөн төлүүлэх зардалд хамаарч буй тул шүүхээс сэжигтэн, яллагдагчийг гэм буруутайд тооцвол нөхцөл байдлаас хамаарч сэжигтэн, яллагдагчаар нөхөн төлүүлдэг байна. Шүүхээс сэжигтэн, яллагдагчийг гэм буруугүйд тооцвол өмгөөлөгчийн хөлс бусад зардлыг нөхөн төлүүлдэггүй. Мөн хорих ял оногдуулсан, орлого нь амьжиргаагаа залгуулахад хүрэлцэхгүй, мөнгөгүй байгаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлс төлөхөөс чөлөөлдөг байна. Харин Хууль зүйн туслалцааны төвийн гэрээт өмгөөлөгч улсаас томилогдсон өмгөөлөгчөөр томилогдсон тохиолдолд хэрэг тус бүр дээр тусдаа зардал тооцоолохгүй бөгөөд тогтсон журмын дагуу тооцохоор хуульчилжээ.

§39.1 Улсаас томилогдох гэрээт өмгөөлөгч нь өмгөөлөгчөөр томилогдсон бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 38-р зүйлийн 2 дахь хэсгийн заалт үйлчлэхгүй.

§39.2 Өмнөх хэсэгт заасан тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын хуулийн 2-р зүйлд заасан зардлаас гадна, дараах заалтад дурдсан этгээд улсаас томилогдсон өмгөөлөгч бол тухайн улсаас томилогдсон өмгөөлөгчид хамаарах тухайн дугаар бүрт заасан зардал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал болно.

§39.2.1 Хөлс болон зардал нь хэрэгт бүрт заасан гэрээ байгуулсан улсаас томилогдох гэрээт өмгөөлөгч – тухайн хөлс болон зардал

§39.2.2 Өмнөх дугаарт заасан улсаас томилогдох гэрээт өмгөөлөгчөөс гадна улсаас томилогдох гэрээт өмгөөлөгч – Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 38-р зүйлийн 2 дахь хэсгийн заалтын жишээгээр шүүхээс хэмжээг нь тогтоосон унаа, байр, хоолны зардал болон хөлс

§39.3. Өмнөх хэсгийн 2 дахь дугаарт дурдсан улсаас томилогдох гэрээт өмгөөлөгч нь улсаас томилогдох өмгөөлөгчөөр томилогдсон тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хариуцуулах шийдвэрт зардлын хэмжээг тодорхой заагаагүй бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 88-р зүйлийг үл харгалзан шийдвэр гүйцэтгэлийг удирдаж буй прокурорын хүсэлтээр шүүх тухайн хэмжээг тогтооно. Энэ тохиолдолд уг хэмжээтэй холбогдох ажиллагааны тухай шаардлагатай асуудлыг Дээд шүүхийн дүрмээр тогтооно.

Хууль зүйн туслалцааны ерөнхий хууль

1.2 ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ХЭДИЙ ҮЕЭС ЭДЛЭХ БОЛОМЖТОЙ ТУХАЙ

Эрт үеэс хууль зүйн туслалцаагаар хангуулах (Early access to legal aid) гэдэгт тухайн этгээд гэмт хэрэгт холбогдож сэжиглэгдсэн, баривчлагдсан, хоригдсон, гэмт хэрэгт шалгагдсан үеэс эхлэн хууль зүйн туслалцаа авахыг ойлгодог байна¹⁵. Сэжиглэгдсэн (suspected) гэх ойлголтыг НҮБ-ын удирдамжид яг тодорхой заагаагүй боловч мэдүүлэг авахаас өмнө буюу мөрдөн шалгагдаж буй гэдгээ мэдсэн үеэс, эсвэл аливаа дарамт шахалт, сүрдүүлэгт өртөх боломжтой үеэс “өмнө” хууль зүйн туслалцаа авах эрхээр хангагдсан байх (the right to legal aid of suspects arises before questioning) шаардлагатай¹⁶ хэмээн тусгасан байдаг.

¹⁵ НҮБ-ын Мансууруулах бодис ба гэмт хэрэгтэй тэмцэх газраас (UNODC) “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрх: Бодлого боловсруулагч, практик ажиллагсдын гарын авлага” 10 дахь тал.

¹⁶ НҮБ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх зарчим, чиглэл” пара. 10.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үе шат болох баривчлагдсан, хоригдсон эхний цаг, өдрөөс гэмт хэрэгт холбогдсон баривчлагдсан, хоригдсон этгээдэд хамгаалалт шаардлагатай маш чухал үе байдаг.¹⁷ Энэ үе шатанд эрүүдэн шүүгдэх болон бусад хэлбэрээр дарамтлуулах, авлига, хахууль нэхэгдэх, албадлагад өртөн гэмт хэрэг хүлээх, хууль бусаар хоригдох эрсдэл өндөртэй байдаг.¹⁸ Эрүүгийн хэрэгт холбогдсон энгийн иргэд эрх зүйн хангалттай боловсролгүй, мөн мэдээлэл, мэдлэггүйгээсээ болоод өөрийгөө хамгаалах, зөвтгөх, нөхцөл байдлыг зөвөөр тайлбарлах чадваргүй байх талтай. Зөвхөн ойлголт, мэдлэг, туршлага дутагдалтайгаас гадна санхүүгийн хувьд ч чадамжгүй байх магадлал өндөртэй байдаг. Түүнчлэн сэтгэл зүйн талаасаа баривчлагдах, хоригдох үед гэмт хэрэгт холбогдсон этгээд айх, сандрах, хууль зүйн туслалцаа авах бэлтгэлгүй зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг. Эдгээр шалтгааны улмаас хууль зүйн туслалцааг зайлшгүй үзүүлэх шаардлага урган гарах бөгөөд уг эрхийг баттай эдлүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Нөгөө талаас, хууль зүйн туслалцааг яг хэрэгцээтэй байгаа үед үзүүлэх нь шударгаар шүүлгэх эрх, хууль дээдлэх ёсны баталгаа болдог байна.¹⁹ Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон гэмт хэрэгт холбогдсон этгээдээс гарч буй зардлыг бууруулах ач холбогдолтой. Иймд эрт үеэс хууль туслалцаа авах эрх (right to early access to legal aid)-ийг өмгөөлүүлэх эрх (the right to legal advice and assistance) болон улсаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх (the right to legal aid that is funded by the State)-ээс ялган авч үзэх шаардлагатай. Учир нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үе шатанд улсаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх үүссэн эсэхийг шалгахад цаг хугацаа алдах тул ямар нэгэн шалгуур тавилгүйгээр буюу төлбөрийн чадварыг харгалзалгүйгээр эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах нь дээр дурдсан эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач

¹⁷ НҮБ-ын Мансууруулах бодис ба гэмт хэрэгтэй тэмцэх газраас (UNODC) “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрх: Бодлого боловсруулагч, практик ажиллагсдын гарын авлага” 1 дэх тал

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ Ed Cape, *Improving Pretrial Justice: The Roles of Lawyers and Paralegals* (New York: Open Society Foundations, 2012)

холбогдолтой байдаг. Гол нь эдгээр эрхийг яг аль үеэс эхлэн эдлэх талаар тодорхой хуульчлах шаардлагатай байдаг.²⁰

1.2.1. Хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах

НҮБ-ын удирдамжийн 8 дахь зарчимд “Мэдүүлэг авахаас өмнө (prior to any questioning), эсвэл эрх чөлөөг нь хязгаарлах (at the time of deprivation of liberty) үед хэрэгт холбогдсон этгээдэд хууль зүйн туслалцаа авах болон бусад процессын эрх ялангуяа хууль зүйн туслалцаа авах эрхээс сайн дураар татгалзсаны үр дагаврын талаар танилцуулсан байхыг төрөөс баталгаажуулах шаардлагатай”²¹ гэж заажээ. Түүнчлэн хууль зүйн туслалцаа авах эрхийн талаарх мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх, үүнийг үнэ төлбөргүй олж авах боломжийг төрөөс бүрдүүлэх ёстой байна.

Мөн НҮБ-ын удирдамжийн 2 дахь зарчимд авах боломжтой хууль зүйн туслалцаа болон энэ туслалцааг авах эрхээ хэрхэн эдлэх, мөн холбогдох бусад мэдээллийг гэмт хэрэгт холбогдсон этгээдэд өгөх хэрэгтэй ба ийнхүү мэдээлэл өгөхдөө тухайн хүний онцлогт нийцүүлэн ойлгогдохуйц байдлаар өгөх шаардлагатай болохыг заасан. Мэдээлэл өгөх хэлбэрийг уг баримт бичигт тодорхойлоогүй боловч амаар болон бичгээр аль алианаар нь өгөх сайн туршлага бусад улс оронд хэвшиж тогтжээ. Мөн нийтэд зориулсан самбарт байршуулах, ялангуяа хорих газар, мэдүүлэг авах газар байршуулах нь үр нөлөөтэй байдаг ажээ.

2009 оноос Европын холбооны зөвлөлөөс “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэрэгт сэжиглэгдэж, шалгагдаж байгаа этгээдийн процессын эрхийг баталгаажуулах зураглалыг (Roadmap for strengthening procedural rights of suspected or accused persons in criminal proceedings)”²² батлан хэрэгжүүлж байна. Уг зураглалын дагуу Европын холбооны парламент, Европын холбооны зөвлөлөөс чиглэл (Directives)-ийг баталсан. Энэ хүрээнд 2010 онд хэлмэрчээр үнэ төлбөргүй хангагдах, шаардлагатай

²⁰ НҮБ-ын гарын авлага 49 дэх тал.

²¹ НҮБ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх зарчим, удирдамж”, пара. 29

²² [http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32009G1204\(01\)&from=EN](http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32009G1204(01)&from=EN)

баримт бичгийг өөрийн эх хэлээр орчуулуулан танилцах эрхийг²³, 2012 онд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл болон эдлэх эрхийн талаар мэдээллээр хангуулах эрхийг²⁴, 2013 онд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч авах, өмгөөлөгч болон бусад гуравдагч этгээдэд холбогдох эрхийг²⁵, 2016 онд гэм буруугүйд тооцох²⁶, мөн онд насанд хүрээгүй этгээдийг хамгаалах²⁷, түүнчлэн хууль зүйн туслалцаа үзүүлэх²⁸ чиглэлүүдийг тус тус баталжээ. 2012 онд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл болон эдлэх эрхийн талаар мэдээллээр хангуулах эрхийн чиглэлд хавсралтаар Эрх сануулах бичиг (Letter of rights)-ийн загварыг гарсан. Уг загвар нь:

Эрх сануулах бичиг

- a) Өмгөөлөгчийн туслалцаа авах, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах;
- b) Ямар хэрэгт шалгагдаж буй талаар мэдэх;
- c) Хэлмэрч, орчуулагч авах;
- d) Дуугүй байх;
- e) Шийдвэртэй танилцах;
- f) Баривчлагдсан, хоригдсон тухай өмгөөлөгч болон бусдад, мөн элчин сайдын яамандаа мэдэгдэх эрх;
- g) Эмнэлгийн тусламж яаралтай авах.

²³ <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32010L0064&from=EN>

²⁴ <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32012L0013&from=EN>

²⁵ <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32013L0048&from=EN>

²⁶ <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32016L0343&from=en>

²⁷ <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32016L0800&from=en>

²⁸ <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?Uri=CELEX:32016L1919&from=EN>

1.2.2. Хууль зүйн туслалцаа авах хүсэлтийг хангах

НҮБ-ын удирдамжийн 7 дахь зарчимд “Төр нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд нэн даруй (promptly) үр дүнтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх баталгааг бий болгох ёстой” гэж тусгасан байдаг.²⁹ Хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэхийг хүссэн этгээд нь хууль зүйн туслалцаа үзүүлэх хуульч, өмгөөлөгчтэй холбогдох боломжоор хангагдах, хууль зүйн туслалцааг цаг алдалгүй авах, мөрдөгч болон бусад эрх бүхий албан тушаалтан нь хууль зүйн туслалцаа үзүүлэгч ирэхээс өмнө мэдүүлэг авахгүй байх ёстой³⁰ болохыг дурдсан байна.

Иймд мөрдөгч болон бусад албан тушаалтанд гэмт хэрэгт холбогдсон этгээдийг хууль зүйн туслалцаа үзүүлэгчтэй холбох зохистой арга хэмжээ авахыг үүрэг болгох, мэдүүлэг авах болон бусад мөрдөн шалгах ажиллагааг хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авахаас өмнө явуулахыг хориглох эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай.³¹ Хууль зүйн туслалцааг нэн даруй үзүүлэхийн тулд мөрдөгч болон бусад эрх бүхий албан тушаалтан нь аль болох хурдан хууль зүйн туслалцаа үзүүлэх хуульч, өмгөөлөгчтэй холбогдох, туслалцаа үзүүлэгчид хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авах хүсэлтэд нэн даруй хариу өгөх үүрэг бий болгох нь мөн чухал байдаг.³²

²⁹ НҮБ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх зарчим, удирдамж”, пара. 27

³⁰ НҮБ-ын Мансууруулах бодис ба гэмт хэрэгтэй тэмцэх газраас /UNODC/ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрх: Бодлого боловсруулагч, практик ажиллагсдын гарын авлага”, 56 дахь тал

³¹ Мөн тэнд

³² Мөн тэнд 57 дахь тал

1.2.3. Харьцуулсан судалгаа: ХБНГУ, Япон Улс

ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд гэмт хэрэгт холбогдсон этгээдэд эдэлж болох эрхийнх нь тухай мэдээлэл өгөхийг дараах байдлаар тусгажээ.

ХБНГУ-ын Эрүүгийн процесс хуулийн 136-р зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэг үүсгэсний дараа гэмт хэрэгт холбогдсон этгээдэд ямар хэрэгт холбогдуулан шалгаж байгаа талаар мэдэгдэх, тулгасан хэрэгтэй холбоотой хуулиар олгогдсон эрх, мэдүүлэг өгөхөөс татгалзах, аль ч үе шатанд ялангуяа байцаалт өгөхөөс өмнө өөрийн сонгосон өмгөөлөгчтэйгөө зөвлөлдөх эрхтэй болохыг тайлбарлаж өгөх ёстой. Түүнчлэн өөрийгөө өмгөөлөх нотлох баримт гаргуулах, мөн 140-р зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангасан бол 141-р зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан өмгөөлөгч томилуулах эрхтэй болохыг тайлбарлан өгөх ёстой”³³ гэж заасан байна.

Япон Улсын эрх зүйн тогтолцоонд өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт үеэс оролцон, сэжигтэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх нь дараах ач холбогдолтой гэж үздэг байна. Үүнд:

- Сэжигтэн баривчлагдсан тохиолдолд өмгөөлөгч түүний харилцагч нь болж баривчлагдсанаас үүсэх тайван бус байдлыг арилгана. Гэр бүлийнхээ болон гадаад орчны талаар мэдээлэл авснаар ганцаардсан байдлыг нь арилгах;
- Сэжигтэн өөрийн одоогийн байгаа нөхцөл байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль зүйн мэдээлэл авах, дуугүй байх гэх мэт мөрдөн шалгах ажиллагаанд эдлэх эрхийг заалгаж авах;
- Мөрдөн шалгах байгууллага мөрдөн шалгах ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж буй эсэхийг өмгөөлөгч хянаж, хууль бус үйл ажиллагаа явуулсан бол гомдол гаргах;
- Сэжигтний эрх ашгийг хамгаалах нотлох баримт цуглуулах, түүнийг хэрэгт бэхжүүлэхийг шаардах;
- Холбогдох бусад хуульд заасан арга хэмжээг авах.

³³ https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html#p1160

Ингэснээр өмгөөлөгч нь мэдээллээр хангах (情報提供機能), төлөөлөх (代理的機能), хамгаалах (保護的機能), туслах (援助的機能) чиг үүргийг тус тус гүйцэтгэдэг байна.

Өмгөөлөгч сонгож авах боломжтой үе, өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах тогтолцоо

Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 30-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар сэжигтэн, яллагдагч аль ч үед өмгөөлөгч авах эрх нь нээлттэй.

§30.1 Яллагдагч, сэжигтэн нь аль ч үед өмгөөлөгч сонгон авах эрхтэй.

§30.2 Яллагдагч, сэжигтний хууль ёсны төлөөлөгч, туслагч, эхнэр, нөхөр, шууд холбоотой төрөл, садан болон ах дүү нь тусдаа өмгөөлөгч сонгон авч болно.

§31.1 Өмгөөлөх этгээдийг өмгөөлөгчдийн дундаас сонгон авна.

§31.2 Хялбаршуулсан шүүх, эсвэл орон нутгийн шүүхэд шүүхийн зөвшөөрлөөр өмгөөлөгч бус этгээдийг өмгөөлөх этгээдээр сонгон авч болно. Гэхдээ орон нутгийн шүүхэд тусдаа өмгөөлөгчдийн дундаас сонгон авсан өмгөөлөгч байгаа тохиолдолд л өмгөөлөгч бус этгээдийг өмгөөлөгчөөр оролцуулж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Мөн тэдний хууль ёсны төлөөлөгч, туслагч, эхнэр, нөхөр, шууд холбоотой төрөл, садан болон ах дүү нь тусдаа өмгөөлөгч хөлслөн авах эрхтэй.

Баривчлагдаж хоригдоогүй байхдаа сэжигтэн өмгөөлөгч авах тохиолдолд сэжигтэн болон өмгөөлөгч гарын үсгээ зурсан бичгийг прокурор (検察官), эсвэл мөрдөгч (司法警察員)-д өгснөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөө оролцуулдаг байна.³⁴

³⁴ Япон Улсын Дээд шүүх “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэм” 17 зүйл 第十七条 公訴の提起前にした弁護人の選任は、弁護人と連署した書面を当該被疑事件を取り扱う検察官又は司法警察員に差し出した場合に限り、第一審においてもその効力を有する。 http://www.courts.go.jp/vcms_lf/keijisoshoukisoku281201.pdf

Хэрвээ сэжигтэнд танил өмгөөлөгч байхгүй, эсвэл өмгөөлөгч олдохгүй байх тохиолдолд Өмгөөлөгчдийн холбоонд хүсэлт гаргах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд тусгагдсан байна.

§312.1 Өмгөөлөгч сонгон авах гэж буй сэжигтэн, ялагдагч нь өмгөөлөгчдийн холбоонд хандан өмгөөлөгчийг сонгон авах хүсэлтээ гаргана.

§312.2 Өмгөөлөгчдийн холбоо нь өмнөх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд нэн даруй өмгөөлөгчдийн дундаас өмгөөлөгчийн хувиар оролцохыг хүссэн этгээдийг санал болгоно.

§312.3 Өмгөөлөгчдийн холбоо нь өмнөх хэсэгт зааснаар өмгөөлөгч болохыг хүссэн этгээд байхгүй бол тухайн хүсэлт гаргасан этгээдэд нэн даруй энэ тухай мэдэгдэх үүрэгтэй. Өмнөх хэсгийн заалтын дагуу санал болгосон өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгч сонгон авах саналаас татгалзсан бол нэгэн адил байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

Өмгөөлөгч сонгон авч чадаагүй бол улсаас томилсон өмгөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах хүсэлт гаргаж болно. Харин баривчлагдсан байгаа сэжигтэн нь шүүх, хорих газрын даргад хандан өмгөөлөгч, эсвэл өмгөөлөгчийн холбоог заан өмгөөлөгч авах хүсэлт гаргана. Уг хүсэлтийг хүлээн авсан шүүх, хорих газрын дарга нь нэн даруй үүнийг өмгөөлөгч, эсвэл өмгөөлөгчдийн холбоонд мэдэгдэнэ. Гэхдээ уг тогтолцоо нь өмгөөлөгч сэжигтний хүсэлтийг хүлээн аваагүй буюу өмгөөлөгч өмгөөлөхөөс татгалзсан, өмгөөлөх хүсэлтэй өмгөөлөгч гараагүй бол сэжигтний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж чадахгүй юм.

Үүнээс улбаалан сэжигтэн өмгөөлөгч авах хүсэлт гаргасан бол Өмгөөлөгчдийн холбоо нь тодорхой өмгөөлөгчийг санал болгодог тогтолцоо (刑事弁護士推薦制度), жижүүр өмгөөлөгчийн тогтолцоо (当番弁護士制度³⁵)-г бий болгожээ. Жижүүрийн өмгөөлөгчийн тогтолцоог 1990 оноос бүх улс даяар хэрэгжүүлсэн бөгөөд баривчлагдсан этгээд нь тухайн мөрдөн шалгах байгууллагаараа дамжуулж эсвэл өөрийн гэр бүл, танил нь харьяалах Өмгөөлөгчдийн

³⁵ https://www.nichibenren.or.jp/contact/on-duty_lawyer.html

холбоонд хүсэлт гаргаснаар жижүүр өмгөөлөгч анхны уулзалтаа үнэ төлбөргүй явуулдаг тогтолцоо юм. Дахин тухайн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авахыг хүсвэл үнэ төлбөртэйгөөр авна. Нийт гэмт хэрэгт холбогдон баривчлагдсан этгээдийн 40 хувь нь уг тогтолцоог ашигласан статистик байдаг.

Өмгөөлөгч нь сэжигтэнтэй найз, гэр бүлийн гишүүд нь уулзах боломжгүй (接見禁止) тохиолдолд ч, ганцаарчлан уулзаж болдог. Мөн хэргийн төрөл харгалзахгүй, цаг хугацаа харгалзалгүй холбогдох боломжтой гэдгээрээ онцлог юм. Ингэснээр баривчлагдсан этгээдэд зөвлөгөө авах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хуулиар хамгаалагдсан эрхээ эдлэх боломж олддог. Япон Улсад хүнийг баривчилсан бол 72 цагийн дотор цагдан хорих тухай шийдвэр гаргах шаардлагатай болдог. Шүүхээс цагдан хорих тухай шийдвэр гаргах үед сэжигтнийг оролцуулан тайлбар гаргах эрхийг мөн хуулиар хамгаалжээ. Энэ үед шүүгчийн зүгээс жижүүр өмгөөлөгчийн тогтолцоог танилцуулж, ашиглах хүсэлтэй эсэхийг лавладаг бөгөөд сэжигтэн уг тогтолцоог ашиглах хүсэлтээ зохих өмгөөлөгчдийн холбоонд мэдэгддэг байна. Жижүүр өмгөөлөгчийн өмгөөллийн хөлс болон зардлыг тухайн өмгөөлөгч харьяалагддаг орон нутгийн өмгөөлөгчдийн холбоо хариуцах бөгөөд өмгөөлөгч нь жижүүр өмгөөлөгчөөр ажиллахаар бүртгүүлсэн этгээд байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль- Мөрдөгч сэжигтэнд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах

§203.1 Мөрдөгч нь баривчлах шийдвэрээр сэжигтнийг баривчилсан бол, эсвэл баривчлагдсан сэжигтнийг хүлээн авсан бол нэн даруй ямар гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа тухай болон өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг танилцуулж, тайлбар хэлэх боломж олгон, хорих шаардлагагүй гэж үзсэн бол нэн даруй суллаж, хорих шаардлагатай гэж үзвэл сэжигтний бие махбодын эрх чөлөөг хязгаарласан үеэс 48 цагийн дотор бичиг баримт болон нотлох баримтын хамтаар сэжигтнийг прокурорт хүргүүлэх ажиллагааг явуулна.

§203.2 Өмнөх хэсэгт заасан тохиолдолд сэжигтэнд өмгөөлөгч байгаа эсэхийг асууж, өмгөөлөгч авсан бол өмгөөлөгчөө сонгон авах тухай мэдэгдэхийг шаардахгүй.

§203.3 Мөрдөгч нь 1 дэх хэсгийн заалтын дагуу өмгөөлөгч сонгон авах тухай мэдэгдэхдээ сэжигтэнд хандан өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээд,

эсвэл өмгөөлөгчийн холбоог заан өмгөөлөгч сонгон авах тухай хүсэлт гаргаж болох тухай болон хүсэлт гаргах хаягийг зааж өгнө.

§203.4 Мөрдөгч нь 372-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгт 1 дэх хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгон авах эрхтэйг мэдэгдэхдээ сэжигтэнд хандан цаашлаад цагдан хоригдохоор болсон тохиолдолд ядуу болон бусад шалтгаанаар өөрөө өмгөөлөгч сонгон авах боломжгүй бол шүүгчид хандан өмгөөлөгч томилж өгөхийг шаардах боломжтой тухай, мөн шүүгчид хандан өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргахдаа төлбөрийн чадварын тухай мэдүүлэг гаргах болон тухайн төлбөрийн чадварын хэмжээ нь стандарт хэмжээнээс их бол урьдчилан Өмгөөлөгчдийн холбоо (373.2-т заасны дагуу 312.1-т заасан хүсэлт гаргах Өмгөөлөгчдийн холбоог хэлнэ)-нд өмгөөлөгч сонгон авах хүсэлт гаргах ёстой болох тухай зааж өгнө.

§203.5 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор хүргүүлэх ажиллагааг гүйцэтгээгүй бол нэн даруй сэжигтнийг суллана.

Гэмт хэрэгт холбогдсон этгээдэд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулахад гол анхаарах ёстой асуудал бол түүний агуулга юм. Өмгөөлөгч авах эрхтэй болохыг хэлбэрийн төдий танилцуулаад, өмгөөлөгчтэй байхын ач холбогдол, сонгон авах арга гэх мэтийг сэжигтэнд танилцуулалгүй орхивол өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг танилцуулсан ч эрхийг нь бодитоор эдлүүлсэн гэж үздэггүй байна. Иймд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулаад зогсохгүй уг эрхээ хэрхэн эдлэх талаар хуульд заасан тогтолцооны тухай мөн дэлгэрэнгүй мэдээлэл өгөх эрхтэй болохыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 203, 204-р зүйлүүдээс харж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль- Прокурор сэжигтэнд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах

§204.1 Прокурор нь баривчлах шийдвэрээр сэжигтнийг баривчилсан бол эсвэл баривчлагдсан сэжигтнийг хүлээн авсан бол нэн даруй ямар гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа тухай болон өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг танилцуулж, тайлбар хэлэх боломж олгон, хорих шаардлагагүй гэж үзсэн бол нэн даруй суллаж, хорих шаардлагатай гэж үзвэл сэжигтний бие махбодын эрх чөлөөг хязгаарласан үеэс 48 цагийн дотор шүүгчид сэжигтнийг цагдан хорих санал гаргана. Гэхдээ энэ хугацаанд хэрэг үүсгэх хүсэлт гаргасан бол цагдан хорих санал гаргахыг шаардахгүй.

§204.2 Прокурор нь өмнөх хэсгийн заалтын дагуу өмгөөлөгч сонгон авах тухай мэдэгдэхдээ сэжигтэнд хандан өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээд эсвэл өмгөөлөгчийн холбоог заан өмгөөлөгч сонгон авах тухай хүсэлт гаргаж болох тухай болон хүсэлт гаргах хаягийг зааж өгнө.

§204.3 2 Прокурор нь 372-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгт 1 дэх хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгон авах эрхтэйг мэдэгдэхдээ сэжигтэнд хандан цаашлаад цагдан хоригдохоор болсон тохиолдолд ядуу болон бусад шалтгаанаар өөрөө өмгөөлөгч сонгон авах боломжгүй бол шүүгчид хандан өмгөөлөгч томилж өгөхийг шаардах боломжтой тухай, мөн шүүгчид хандан өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргахдаа төлбөрийн чадварын тухай мэдүүлэг гаргах болон тухайн төлбөрийн чадварын хэмжээ нь стандарт хэмжээнээс их бол урьдчилан Өмгөөлөгчдийн холбоо (373.2-т заасны дагуу 312.1-т заасан хүсэлт гаргах Өмгөөлөгчдийн холбоог хэлнэ)-нд өмгөөлөгч сонгон авах хүсэлт гаргах ёстой болох тухай зааж өгнө.

§204.4 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор цагдан хорих санал гаргах, эсвэл хэрэг үүсгэх хүсэлт гаргаагүй бол нэн даруй сэжигтнийг суллана.

§204.5 Өмнөх зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь 1 дэх хэсгийн тохиолдолд нэгэн адил үйлчилнэ.

§205.5 Өмнөх зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь прокурор 372-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэргээс өөр хэрэгт баривчлагдаж, 203-р зүйлд заасны дагуу 372-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг болж хүргэгдэн ирсэн сэжигтэнд нэгэн адил үйлчилнэ.

Түүнчлэн шүүгчид мөн сэжигтэнд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах үүргийг оногдуулсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль- Шүүгч сэжигтэнд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах

§207.2 Шүүгч нь цагдан хорих санал хаялагдсан сэжигтэнд сэрдэгдэж буй хэргийг танилцуулахдаа сэжигтэнд хандан өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах тухай мэдэгдэх, 372-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгт цагдан хорих санал хаялагдсан сэжигтэнд хандан ядуу болон бусад шалтгааны улмаас өөрөө өмгөөлөгч сонгон авах боломжгүй бол улсаас өмгөөлөгч томилуулахаар хүсэлт гаргаж болох тухай мэдэгдэнэ. Гэхдээ сэжигтэнд өмгөөлөгч байгаа бол энэ нь үйлчлэхгүй.

§207.3 Өмнөх хэсгийн заалтын дагуу өмгөөлөгч сонгон авах тухай мэдэгдэхдээ цагдан хоригдсон сэжигтэнд хандан өмгөөлөгч, өмгөөллийн хуулийн этгээд, эсвэл өмгөөлөгчийн холбоог заан өмгөөлөгч сонгон авах тухай хүсэлт гаргаж болох тухай болон хүсэлт гаргах хаягийг зааж өгнө.

Япон Улсын хувьд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхээ эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатнаас эдлэх нь нээлттэй бөгөөд сэжигтэн, яллагдагч өөрөө өмгөөлөгчөө сонгон аваагүй байгаа бол өмгөөлөгч авахыг сануулах бус хэрхэн өмгөөлөгч авах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөс гадна өмгөөлөгч, өмгөөлөгчдийн холбоотой холбож өгөх үүргийг мөрдөгч, прокурор, шүүгч нарт хуулиар оноосон байна.

1.3. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХЭЭ ЭДЭЛСЭН ЭСЭХИЙГ БАРИМТЖУУЛАХ

НҮБ-ын удирдамжийн 3 дахь зарчимд “Онцгой нөхцөл байдал бий болоогүй бол өмгөөлөгчгүйгээр хүнээс мэдүүлэг авахыг хориглоно. Өмгөөлөгч авах эрхтэйг мэдэгдсэн бөгөөд сайн дураар өмгөөлөгч авахаас татгалзсан бол өмгөөлөгчгүйгээр мэдүүлэг авч болно. Сайн дураар татгалзсан гэдгийг баримтжуулах механизмыг бий болгох шаардлагатай. Хууль зүйн туслалцаа үзүүлэгч ирэхээс нааш мэдүүлэг авах ажиллагааг эхлүүлж болохгүй”³⁶ гэж тусгасан байна.

Хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэхтэй холбоотой авсан арга хэмжээ болон шийдвэрийг тэмдэглэх, баталгаажуулах, хянах талаар мөн зохицуулалт шаардлагатай болдог байна. Энэ нь гэмт хэрэгт холбогдсон этгээдэд хууль зүйн туслалцаа авах эрхээ баттай эдлэх итгэлийг бий болгох бол, мөрдөгч болон бусад холбогдох албан тушаалтнуудыг процессын эрхийг зөрчсөн гэж буруутгагдахаас хамгаалах юм.

Зохистой арга хэмжээ, шийдвэр гаргасан талаар тэмдэглэх, баталгаажуулахдаа дээд албан тушаалтны хяналт байхаас гадна хөндлөнгийн хяналт байх ёстой. Тухайлбал, гэмт хэрэгт холбогдсон этгээдээр өөрөөр нь баримтжуулах, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа этгээдээр, дуу дүрс бичлэгээр баримтжуулах нь үүнд хамаарна. Хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг

³⁶ НҮБ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх зарчим, удирдамж”, пара. 43.b

баталгаажуулах зорилгоор дараах агуулгыг³⁷ баримтжуулах шаардлагатай. Үүнд:

- Мөрдөгч сэжигтэнтэй анх хэзээ холбогдсон тухай;
- Баривчилсан, хорьсон хугацаа, баривчилсан албан тушаалтны нэр болон бусад биеийн байцаалт, баривчлах эрх хэмжээ, баривчилсан, хорьсон шалтгаан үндэслэл;
- Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн нэр, биеийн байцаалт;
- Гэмт хэрэгт холбогдсон этгээдийн насыг тодорхойлох, бусад хуульд заасан нөхцөл байдал (any relevant vulnerability) байгаа эсэхийг тодорхойлох, үр дүн болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;
- Хууль зүйн туслалцаа авах эрх болон бусад процессын эрхийг гэмт хэрэгт холбогдсон этгээдэд мэдэгдсэн хугацаа, эрхийг нь танилцуулсан арга хэлбэр, гэмт хэрэгт холбогдсон этгээд хууль туслалцаа авах эсэхээ хэрхэн шийдвэрлэсэн талаар;
- Хэрвээ гэмт хэрэгт холбогдсон этгээд хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан бол сайн дураар татгалзсан гэдгийг тодорхойлох тэмдэглэл;
- Хэрвээ гэмт хэрэгт холбогдсон этгээд хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэхийг хүсвэл:
 - Хууль зүйн туслалцаа үзүүлэх этгээдтэй холбогдохоор мөрдөгч болон бусад холбогдох албан тушаалтны авсан арга хэмжээ, арга хэмжээ авсан хугацаа, үр дүн;
 - Хууль зүйн туслалцаа үзүүлэх этгээд цагдаагийн хэлтэс, саатуулах байранд хүрэлцэн ирсэн хугацаа болон түүнтэй холбоо барьсан хугацаа, түүний биеийн байцаалт;
 - Гэмт хэрэгт холбогдсон этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлсэн хугацаа;

³⁷ НҮБ-ын Мансууруулах бодис ба гэмт хэрэгтэй тэмцэх газраас /UNODC/ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт үеэс хууль зүйн туслалцаа үзүүлэх: Бодлого боловсруулагч, практик ажиллагсдын гарын авлага”, 60 дахь тал

- Хууль зүйн туслалцаа үзүүлсэн этгээд цагдаагийн хэлтэс, саатуулах байрыг орхин явсан хугацаа.
- Байцаалтын үргэлжилсэн хугацаа, байцаалт явуулахад байсан хүмүүсийн биеийн байцаалт;
- Гэмт хэрэгт холбогдсон этгээд оролцсон бусад процессын ажиллагааны хугацаа, тухайн ажиллагааг явуулсан хүний нэр, биеийн байцаалт, явуулсан ажиллагааны тодорхойлолт, гарсан үр дүн;
- Хорьсон хугацаанд гарсан үр дүн, бусад нөхцөл байдлын талаар.

1.3.1. Хууль зүйн туслалцаа авах эрхийг сэргээх, хамгаалах

НҮБ-ын удирдамжийн 9 дэх зарчимд “Хэрвээ хууль зүйн туслалцаа авах эрхийг дордуулсан, хоцроосон, үзүүлээгүй эсвэл хууль зүйн туслалцаа авах эрхийн талаар хангалттай мэдээлээгүй тохиолдолд төрөөс эрхийг сэргээх, хамгаалах үр нөлөө бүхий тогтолцоог бий болгох шаардлагатай”³⁸ гэж тусгасан бөгөөд 2 дахь удирдамжийн “e”-д “Хууль зүйн туслалцаа авах эрхийн талаар хангалттай (adequately) мэдээлэл олгогдоогүй этгээдийн эрхийг үр нөлөө бүхий байдлаар сэргээнэ” хэмээн заажээ.

Эрх сэргээх арга хэмжээнд:

- Процесс ажиллагаа явуулахыг хориглох;
- Хорьсон бол суллах;
- Нотлох баримтаас хасах;
- Шүүхийн хяналт;
- Нөхөн сэргээх багтаж болно³⁹

³⁸ НҮБ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх зарчим, удирдамж”, пара. 31

³⁹ НҮБ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх зарчим, удирдамж”, пара. 42

1.3.2. Харьцуулсан судалгаа: АНУ

АНУ-ын Үндсэн хуулийн 6 дахь нэмэлт өөрчлөлтөд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүхий л шатанд яллагдагч гэмт хэрэг үйлдсэн газрын Муж улс, дүүргийн Тангарагтны шударга шүүхээр хэргээ нийтийн өмнө ба хойшлуулалгүйгээр хянан шийдвэрлүүлэх эрхтэй. Энэхүү дүүргийн нутаг дэвсгэр нь хуулиар урьд нь тодорхойлогдсон байх ёстой. Ингэхдээ яллагдагч яллаж буй үндэслэл, шинжийн талаар мэдээлэл авах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгч буй гэрчтэй нүүрэлдэх, өөрт ашигтай мэдүүлэг өгөх гэрчийг албадан дуудан ирүүлэх, хамгаалуулахын тулд өмгөөлөгчийн туслалцааг авах эрхтэй”⁴⁰ гэж заасан байдаг билээ.

1958 онд “Крукер болон Калифорни” (Crooker v. California)⁴¹ нарын хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгджээ.

Дээд шүүхэд гомдол гаргасан этгээд нь 31 настай Хуулийн сургуулийн 1-р курсийн оюутан бөгөөд эрүүгийн эрх зүйн талаар суралцаж байжээ. Мужийн шүүх түүнийг хүн амины хэрэг үйлдсэн гэж үзэн цаазаар авах ял оноосон. Мужийн Дээд шүүх мөн үүнийг зөв гэж үзсэн байна. Тэрээр Үндсэн хуулийн 14 дэх нэмэлтэд заасан эрхийг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчсөн гэж үзсэн байна. Тэрээр гэм буруутай гэдгээ өөрөө хүлээн зөвшөөрсөн боловч өөрийгөө илчилсэн явдал нь өмгөөлөгч авах эрхийг эдлүүлээгүйгээс болсон гэж тайлбар гаргажээ. Учир нь тэрээр баривчлагдсанаасаа хойш 14 цагийн дотор хэд хэдэн удаа өмгөөлөгч авахыг хүссэн боловч татгалзсан хариу авсан бөгөөд энэ нь өөрийгөө илчлэх хүртэл үргэлжилжээ. Үүний зэрэгцээ тэрээр худлаа ярьж буй эсэхийг шалгагчид орохоос татгалзсан, мэдүүлэг өгөхөөс татгалзсан гээд дуугүй байх эрх эдлэхээ бүрэн дүүрэн илэрхийлжээ. Мөрдөгчид түүнд хариулахыг хүсэхгүй байгаа бол асуултад хариулахгүй байж болохыг мөн тайлбарлаж өгчээ. Түүний өөрийгөө илчилсэн мэдүүлгийг мөрдөгч богино хугацаанд авсан бөгөөд гомдол гаргасан этгээдэд кофе, сүү, сэндвич өгснөөс гадна тамхи татахыг хүртэл зөвшөөрчээ.

⁴⁰ https://www.law.cornell.edu/constitution/sixth_amendment “In all criminal prosecutions, the accused shall enjoy the right to a speedy and public trial, by an impartial jury of the state and district wherein the crime shall have been committed, which district shall have been previously ascertained by law, and to be informed of the nature and cause of the accusation; to be confronted with the witnesses against him; to have compulsory process for obtaining witnesses in his favor, and to have the assistance of counsel for his defense.”

⁴¹ <https://supreme.justia.com/cases/federal/us/357/433/case.html>

Өөрөөр хэлбэл, хэргээ илчилсэн нь өөрийн сайн дурын үндсэн дээр явагдсан гэж үзэгддэг байна. Уг хэрэг АНУ-ын Дээд шүүхэд хянагдсан бөгөөд 9 шүүгчээс 5 нь хэрэгтний гомдол үндэслэлгүй гэж үзэн мужийн Дээд шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Дээд шүүхийн 9 шүүгчээс 4 нь эсрэг саналтай байсан бөгөөд гомдол үндэслэлтэй гэж үзсэн байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамгийн чухал үе (critical stage in criminal prosecutions) бол сэжигтэн баривчлагдан байцаагдах (custodial interrogation) үе гэж үзэн, баривчлагдсан этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэхүү чухал үед өмгөөлөгч авах эрхээ эдлэх боломжгүй байсаар байх юм бол эрүүдэн шүүх, хүч хэрэглэх явдал гарсаар байх болно⁴² гэж үзжээ. Үүний дараагаар Дээд шүүхийн шүүгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор энэ нь өөрчлөгджээ.

1964 онд “Эскобедо болон Иллинойз”(Escobedo v. Illinois)⁴³ нарын хэрэг мөн Дээд шүүхээр хянагдсан байна.

Гомдол гаргагч нь Мексикээс гаралтай бөгөөд эгчтэйгээ хамт баривчлагдан, 11 хоногийн өмнө хүргэн ахыгаа буудан хороосон хэрэгт холбогдон цагдаагийн төв удирдлагын газар байцаагдахаар хүргэгдсэн байна. Тэрээр буудалцааны дараахан түр зуур баривчлагдаж байсан боловч дуугүй байсан бөгөөд түүний өмгөөлөгч үндэслэлгүй баривчлагдсан гэдэг үндэслэлээр түүнийг шүүхийн захирамжаар суллуулж байжээ. Энэ удаад тэрээр хэд хэдэн удаа өмгөөлөгчтэйгөө уулзах хүсэлт гаргасан бөгөөд түүний өмгөөлөгч нь цагдаагийн газар ирээд үйлчлүүлэгчтэйгээ уулзахыг мөн шургуу хүссэн боловч түүнийг уулзуулаагүй байна. Гомдол гаргагчид мөн дуугүй байх эрхийг нь мөрдөгч тайлбарлаж өгөөгүй бөгөөд шургуу байцаалтын явцад прокурорт өөрт хохиролтой мэдүүлэг (хэргээ хүлээсэн) өгсөн бөгөөд энэ нь шүүхэд хүлээн зөвшөөрөгдөн, хүн амины хэрэгт буруутгагдсан байна. Мужийн дээд шүүх мөн үүнийг зөв гэж үзжээ.

Дээд шүүхийн 9 шүүгчийн 5 нь гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн. Учир нь өмгөөлөгчийн зөвлөгөө авах боломжоор хангагдалгүйгээр гэмт хэргээ илчилсэн тул хэрэгсэхгүй гэж үзжээ.⁴⁴ Шүүхийн гол

⁴² <https://supreme.justia.com/cases/federal/us/357/433/case.html> “The mischief and abuse of the third degree will continue as long as an accused can be denied the right to counsel at this the most critical period of his ordeal”.

⁴³ <https://supreme.justia.com/cases/federal/us/357/433/case.html>

⁴⁴ <https://supreme.justia.com/cases/federal/us/357/433/case.html> “The mischief and abuse of the third degree will continue as long as an accused can be denied the right to counsel at this the most critical period of his ordeal”.

үндэслэлийг авч үзвэл “Цагдаагийн мөрдөн шалгах ажиллагаанд тодорхой этгээдийг сэжиглэсэн үеэс (the accusatory stage) эхлэн эрүүгийн яллах ажиллагаа (criminal prosecution) эхлэх учраас өмгөөлөгч авах эрх үүснэ”⁴⁵ гэжээ.

Мөн 1966 онд АНУ-ын Дээд шүүхээс “Миранда болон Аризона” (Miranda v. Arizona⁴⁶)-гийн хэрэгт баривчлагдсан сэжигтэн этгээдээс мэдүүлэг авахаас өмнө түүнд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг нь мэдэгдэх ёстой гэсэн зарчмыг бий болгожээ.

1963 оны 3 сарын 13-нд Эрнэсто Миранда нь гэртээ байхдаа баривчлагдан, хүүхэд барьцаалсан, хүчиндсэн хэргийн холбогдогчоор цагдаагийн төвд хүргэгдэн, мөрдөгчид түүнийг байцаасан байна. Хоёр цагийн турш байцаасны дараагаар Миранда нь гэмт хэргээ илчилсэн мэдүүлэг өгчээ. Өөрийгөө илчилсэн бичмэл баримтыг өмгөөлөгч нь хэргээс хасуулахыг хүссэн боловч түүний хүсэлтийг хангаагүй бөгөөд шүүхэд нотлох баримтаар хүлээн зөвшөөрөгдсөн байна. Мөн мөрдөгч нар Мирандад байцаалтын үеэр өмгөөлөгчтэй байхыг тайлбарлаж өгөөгүйгээ мөн хүлээн зөвшөөрчээ. Тангарагтны шүүх Мирандаг буруутай гэж үзжээ. Аризонагийн Дээд шүүх мөн Мирандагийн Үндсэн хуульд заасан эрх зөрчигдөөгүй, учир нь тэрээр тусгайлан өмгөөлөгч авахыг хүсээгүй болохоор гэжээ.

АНУ-ын Дээд шүүхийн 9 шүүгчийн 5 нь гомдол гаргагч Мирандагийн гомдлыг үндэслэлтэй гэж үзээд, үндэслэлдээ “Тодорхой процессын эрхийг эдлүүлээгүй, хамгаалалт олгоогүйгээр байцааж олж авсан мэдүүлгийг яллах баримтаар ашиглаж болохгүй. Эдгээр процессын хамгаалалтад дуугүй байх эрхээ мэдэх, аливаа мэдүүлэг нь өөрийнх нь эсрэг ашиглагдаж болох тухай сануулах, өмгөөлөгчтэй байх, төлбөрийн чадваргүй бол томилогдсон өмгөөлөгчтэй байж болох, эдгээр эрхээс татгалзаж болох тухай, мөн ямар ч үед өмгөөлөгч авахыг дахин хүсэж болох бөгөөд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах хүртэл ямар

⁴⁵ <https://supreme.justia.com/cases/federal/us/378/478/case.html>

⁴⁶ Criminal Procedure by Samaha, Joel 8th (eighth) Edition, p.268

нэгэн байцаалт явагдахгүй байх тухай асуудал хамаарна”⁴⁷ гэж дүгнэжээ. Мөн шүүх авч үзэхдээ энэ тохиолдолд байцаах арга техникийг хүч хэрэглэсэн гэж үзэхгүй боловч хариуцагч шийдвэр гаргахдаа өөрийн чөлөөт хүсэл зоригийн үндсэн дээр шийдвэр гаргах боломжийг олгоогүй байна гэж авч үзжээ. Энэхүү түүхэн шийдвэрээс Мирандагийн сануулга (Miranda warning) хэмээх нэршил үүсжээ.

Мирандагийн сануулга

“Та дуугүй байх эрхтэй. Таны хэлсэн бүхэн шүүхэд таны эсрэг ашиглагдах боломжтой. Та өмгөөлөгч авах эрхтэй. Хэрвээ та өмгөөлөгч авах боломжгүй бол танд өмгөөлөгч томилж өгнө.”

Үүнээс хойш гэмт хэрэгт холбогдсон этгээдэд зайлшгүй дараах сануулгыг өгөх ёстой гэсэн соёл АНУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэнт тогтсон байна. Энд мөн хувь өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах боломжгүй бол улсаас өмгөөлөгч томилж өгөх боломжтой болох нь харагдаж байна. Ямар хэрэг тулгаж буй талаар шүүгч танилцуулах үед шүүгчээс өмгөөлөгчөөр төлөөлүүлэх эсэх, өмгөөлөгч байхгүй бол улсаас өмгөөлөгч томилуулж өгөхийг мөн танилцуулах бөгөөд улсаас өмгөөлөгч томилуулан хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжтой байна.

Үүнээс гадна АНУ-д хууль зүйн туслалцаа хэлбэрийн төдий байж болохгүй, үр нөлөө бүхий байх ёстой (Effective Counsel) гэсэн шаардлагыг бий болгосон байна. Дээд шүүх “өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэдэг нь үр дүнтэй хууль зүйн туслалцаа авах эрхтэй гэдгийг бас дотроо агуулсан” хэмээн үзжээ.

⁴⁷ <https://www.oyez.org/cases/1965/759> “Prosecution may not use statements arising from a custodial interrogation of a suspect unless certain procedural safeguards were in place. Such safeguards include proof that the suspect was aware of his right to be silent, that any statement he makes may be used against him, that he has the right to have an attorney present, that he has the right to have an attorney appointed to him, that he may waive these rights if he does so voluntarily, and that if at any points he requests an attorney there will be no further questioning until the attorney arrives.”

1984 онд АНУ-ын Дээд шүүх “Стрикланд болон Вашингтон” (Strickland v. Washington)⁴⁸-ны хэргийг хянахдаа шүүхээс томилогдсон өмгөөлөгч нь үр дүнтэй хууль зүйн туслалцаа үзүүлсэн⁴⁹ эсэхийг тогтоосон байна.

Давид Вашингтон нь Флоридагийн шүүхэд үргэлжилсэн үйлдлээр 3 хүн амины хэрэгт өөрийн буруутайг хүлээн зөвшөөрчээ. Тэрээр өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан бүртгэлгүй бөгөөд гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн гэр бүлийн амьжиргааг залгуулж чадахгүй байна гэх хэт их стрессийн дарамтад байжээ. Шүүх хуралдаанд түүний өмгөөлөгч нь тухайн гэмт хэрэгтний гэмт хэрэг үйлдэхээс өмнөх хувийн түүхийн тухай ярьсан боловч гэрчийг тодорхойлох, сэтгэцийн шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах оролдлого хийгээгүй байна. Ийнхүү тэрээр өмгөөлөгчийн үзүүлсэн хууль зүйн туслалцаа үр дүнгүй байсан нь Үндсэн хуулийн 6-р нэмэлтэд заасан хууль зүйн туслалцаа авах эрхийг зөрчсөн гэж үзжээ.

АНУ-ын 5-р тойргийн давж заалдах шатны шүүх дүгнэхдээ эрүүгийн гэмт хэргийн холбогдогч нь өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авахдаа тухайн нөхцөл байдалд бүрэн тохирсон боломжит хэмжээнд үр дүнтэй хууль зүйн туслалцаа авах эрхтэй (reasonably effective assistance given the totality of the circumstances) гэж үзжээ. АНУ-ын Дээд шүүх дүгнэхдээ “Вашингтоны өмгөөлөгч боломжит хэмжээнд өмгөөлөл үзүүлсэн, үзүүлсэн өмгөөлөл боломжит хэмжээнд нийцэхгүй байлаа ч Вашингтоны шүүхийн шийдвэрт хангалттай нөлөөлөхүйц биш байна гэж дүгнэжээ”. Стрикланд болон Вашингтоны хэргээс⁵⁰ үүдэлтэй шүүхээс томилогдсон өмгөөлөгч үр дүнтэй, зохистой хууль зүйн туслалцаа үзүүлсэн эсэхийг тогтоох арга гарч иржээ.

⁴⁸ <https://www.oyez.org/cases/1983/82-1554>

⁴⁹ https://www.law.cornell.edu/wex/right_to_counsel the Supreme Court has ruled that the right to counsel implies the right to an effective lawyer.

⁵⁰ <https://supreme.justia.com/cases/federal/us/466/668/case.html> The proper standard for judging attorney performance is that of reasonably effective assistance, considering all the circumstances. When a convicted defendant complains of the ineffectiveness of counsel's assistance, the defendant must show that counsel's representation fell below an objective standard of reasonableness.

With regard to the required showing of prejudice, the proper standard requires the defendant to show that there is a reasonable probability that, but for counsel's unprofessional errors, the result of the proceeding would have been different. A reasonable probability is a probability sufficient to undermine confidence in the outcome.

Хоёр шатлалт арга (two-prong test)

1. Алдаа гаргасан эсэх (Error Prong);
 - Өмгөөлөгчийн үзүүлсэн хууль зүйн туслалцаа нь мэргэжлийн өмгөөлөгчдийн дунд тархсан хууль зүйн туслалцааны стандартаар хэмжигдэх бөгөөд хэрвээ тухайн нөхцөл байдалд үзүүлсэн өмгөөллийн үйлчилгээ хангалтгүй (deficient) байгаа эсэх;
 - Энэ нь дийлэнхдээ заншлаас хамаарна;
2. Шийдвэрт нөлөөлөхүйц байсан эсэх (Prejudice Prong)
 - Өмгөөлөгчийн үзүүлсэн хангалтгүй үйлчилгээ нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн байх боломжит магадлал байгаа эсэх;
 - Шууд шалтгаант холбоотой эсэх: Хэрвээ өмгөөлөгч мэргэжлийн алдаа гаргаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дагавар өөр байх байсан эсэх.

Хэрвээ өмгөөллийн үйлчилгээ нь энэ аргаар няцаагдвал хэргээ шүүхээр дахин хянуулах хамгаалалт болдог байна.

1.4. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд хууль зүйн туслалцааг эрт шатнаас авах нь тухайн хүний үндсэн эрх хамгаалагдах хамгийн суурь хүчин зүйл гэж үздэг бөгөөд үүнийг дагаж бусад эрх баталгаажих боломж бүрддэг. Эрүүгийн процессыг удирдаж явуулж буй албан тушаалтнууд хэргийн оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэхтэй холбоотой тодорхой ажиллагаа хэрэгжүүлдэг байвал зүйтэй ажээ. Тухайлбал, хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах, хэрвээ эрүүгийн хэргийн оролцогч эрхээ эдэлж чадахгүй нөхцөлд туслалцаа үзүүлж өмгөөлөгч сонгох боломжоор хангах, хуульд заасан нөхцөл байдал илэрвэл заавал өмгөөлөгч оролцуулах, томилох зэрэг арга хэмжээг авдаг байна. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд томилогдож оролцох өмгөөлөгч нь хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байдаг.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн тунхаглал, гэрээ, конвенцуудад хууль зүйн туслалцаа авах эрх, түүнийг хэрхэн эдлүүлэх талаар тунхагласан. Олон улсын баримт бичгүүдэд тусгагдсан хүний эрхийн зохицуулалтууд нь Монгол Улсын хуулийн нэгэн адил Монгол Улсад үйлчлэх хэм хэмжээ учир хэрэгжүүлэх үүргийг мөн хүлээнэ.

Эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах эрхийг танилцуулах, баталгаажуулах процесс хамгийн чухал гэдгийг НҮБ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх зарчим, удирдамж”-д онцгойлон дурдсан байна. Тухайлбал, Харьцуулсан судалгаагаар АНУ-д “Мирандагийн сануулга”-ыг гэмт хэрэгт холбогдсон этгээдэд сануулдаг бол, Европын холбооны зөвлөлөөс “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэрэгт сэжиглэгдэж, шалгагдаж буй этгээдийн процессын эрхийг баталгаажуулах зураглал”-ыг 2009 онд баталж, амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд 2012 онд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл болон эдлэх эрхийн талаар мэдээллээр хангуулах эрхийн хүрээнд 7 төрлийн эрхийг заавал сануулж байх загварыг хавсралтаар баталсан байна.

Эрүүгийн хэрэгт холбогдсон этгээд хууль зүйн туслалцаа авах эрхээсээ татгалзаж өөрийгөө өмгөөлөх хүсэлт гаргасан нөхцөлд хөндлөнгийн шахалт, дарамтгүйгээр татгалзаж байгаа гэдгийг өөрөөр нь баталгаажуулах, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрт эрхийг нь сануулж, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх эсэхийг тодруулж, үр дагаврыг тайлбарлан баталгаажуулж байх шаардлагатай. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотойгоор баталгаажуулах ажиллагааны жагсаалтыг судалгааны 1.3-т нарийвчлан тусгав.

НҮБ-аас гаргасан жагсаалтаар заавал өмгөөлөгч оролцуулж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах дөрвөн тохиолдлыг дурдсан. Харин харьцуулсан судалгаагаар ХБНГУ, Япон Улс илүү өргөн хүрээтэйгээр зохицуулж байна. Үүнээс Япон Улсын хувьд өмгөөлөгч заавал оролцуулах нөхцөлүүдийг маш нарийвчилсан байдлаар зохицуулжээ. Япон Улсын Өмгөөлөгчдийн холбооноос сэжигтэн, яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад

маш идэвхтэй оролцож байх бөгөөд төрөөс хангаж чадахгүй байгаа хэсэгт хууль зүйн туслалцааг сайн дураар өөрсдийн зардлаар нөхөн хүргэдэг байна.

Өмгөөлөгч нь мэдүүлэг өгөхөд байлцах эрхтэй, сэжигтэн нь өмгөөлөгчөө байлцуулан мэдүүлэг өгөх эрхтэй боловч мөрдөгч, прокурорт уг эрхийг эдлүүлэх талаар арга хэмжээ авах үүрэг болгосон зохицуулалт байхгүй байна.

1960-аад оноос эхлэн АНУ-д Үндсэн хуулиар хамгаалагдаад байсан хууль зүйн туслалцаа авах эрхийг хэлбэрийн төдий бус бодитоор эдлүүлэх талаар АНУ-ын Дээд шүүхээс маш чухал жишгийг тогтоож өгсөн байна. Үүнд:

- Гэмт хэрэгт буруутгагдсан үеэс эхлэн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах тухай;
- Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа аваагүй байхад өгсөн мэдүүлгийг яллах баримтаар ашиглаж болохгүй тухай;
- Гэмт хэрэгт холбогдсон этгээдэд эрхийг сануулахдаа өөрийн сонгосон өмгөөлөгч авахаас гадна өмгөөлөгч авах боломжгүй бол улсаас өмгөөлөгч томилуулах эрхтэй болохыг тайлбарлан өгөх тухай;
- Улсаас томилогдсон өмгөөлөгч нь ердийн боломжит хэмжээнд хууль зүйн туслалцааг чанартай үзүүлэх, хууль зүйн туслалцааг чанаргүй үзүүлсэн бол дахин хэргээ хянуулах эрхээр хамгаалах тухай.

-ХОЁРДУГААР БҮЛЭГ-

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ БОЛОН АЛЬ БОЛОХ ЭРТ ШАТНААС ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ ТУСГАГДСАН НЬ: ЗААВАЛ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ

2.1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт хүний үндсэн эрхийг (хүний амьд явах, халдашгүй, чөлөөтэй байх, эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохгүй байх гэх мэт) тусгайлан бүлэг болгон жагсааж, мөн төрөөс иргэнийхээ эрхийг эдлэх баталгааг хариуцах үүрэгтэй болохыг тусгайлан үүрэгжүүлсэн. Мөн үндсэн эрхээ эдлэх, хамгаалах суурь нөхцөл нь хууль зүйн туслалцаа авах бөгөөд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, “... эрхийг хүн бүр баталгаатай эдлэх”, 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрх”, 2 дахь хэсэгт заасан “шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа авна” хэмээн тус тус баталгаажуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон буюу иргэний хэргийн хариуцагч хэн боловч юуны өмнө өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Гэхдээ тухай этгээд (хүн, хуулийн этгээд) зөвхөн өөрөө өөрийгөө өмгөөлөхөөр хязгаарлагдахгүй, хууль зүйн туслалцаа үзүүлдэг мэргэжлийн өмгөөлөгчтэй байх эрхтэй

юм. Эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдийн өмгөөлөгч авах эрх тухайн этгээдэд холбогдуулан урьдчилан мөрдөх, мөрдөх зэрэг ажиллагааны төгсгөлд биш сэжиглэгдэж эхэлсэн цагаас эхлэн бүхий л шатанд чөлөөтэй хэрэгжих учиртай⁵¹ билээ.

Хэрэв хэргийн оролцогч өөрийгөө өмгөөлөх хүсэлтэй байгаа тохиолдолд Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зургаан тохиолдлоос бусад нөхцөлд өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг ямар нэгэн шахалт, дарамтгүйгээр өөрөө илэрхийлж, бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах боломжтой. Гэхдээ хэргийн оролцогч хүсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломж байх ёстой. Хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх хүсэлтэй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид өмгөөлөгчөө сонгох, хууль зүйн туслалцаа авах боломжийг төрөөс хангах үүрэгтэй.

2.1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцааг заавал эдлүүлэх тохиолдол

Монгол Улсын 2002 болон 2017 оны Эрүүгийн процессын хуулиудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй “субъект”-ийг зохицуулсан байдаг.

Хүснэгт 4. Заавал өмгөөлөгч оролцуулах тохиолдол

№	2002 ОНЫ ЭБШТХ	2017 ОНЫ ЭХХШТХ
1	Хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй	Хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй
2	Насанд хүрээгүй	Өсвөр насны
3	Монгол хэл, бичиг мэддэггүй	Монгол хэл, бичиг мэдэхгүй

⁵¹ Г.Совд “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх: Харьцуулсан судалгаа” 1999 он, 79-80 дахь тал.

4	Цаазаар авах ялаар шийтгэгдэж болох	Бүх насаар хорих ял оногдуулж болох
5	Хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн аль нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч	Хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч
6	Төлбөрийн чадваргүй этгээд өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан	Төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан

Энэхүү судалгааны 1.1.2 хэсэгт тусгагдсан олон улсын стандартын дагуу 4 тохиолдолд зайлшгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчтэй явуулах ёстойг тусгасан байна. Харин Монгол Улсын эрүүгийн процессын хуулиудад “хөгжлийн бэрхшээлтэй өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, Монгол хэл, бичиг мэдэхгүй” гэсэн нэмэлт 2 нөхцөлийг тусгаж өгсөн байна. ЭХХШТХ-ийн 5.3-т заасны дагуу бол дээрх 6 тохиолдол байгаа нөхцөлд өмгөөлөгчгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй. Дээрх нөхцөлд эхлээд өмгөөлөгчөө сонгон авах боломжоор хангана, үүний дараа өөрсдөө өмгөөлөгчөө сонгож чадаагүй, сонгох боломжгүй нөхцөлд шүүх, прокурор нь томилогдсон өмгөөлөгч оролцуулна хэмээн зохицуулсан.

Томилогдсон өмгөөлөгч оролцуулах зохицуулалт

“Томилогдсон өмгөөлөгч” гэдэг нь 2017 оны ЭХХШТХ-д шинээр нэмэгдэж орж ирсэн процессын зохицуулалт юм. ЭХХШТХ-ийн нэр томъёоны тайлбар хэсэгт “томилогдсон өмгөөлөгч” гэж хуульд заасан тодорхой нөхцөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийг ойлгохоор зохицуулсан. Хууль заасан тодорхой нөхцөл гэдэг нь ЭХХШТХ-д заасан дараах 5 нөхцөлд оролцохоор зохицуулагдсан байна.

Хүснэгт 5. ЭХХШтХ-ийн томилогдсон өмгөөлөгч оролцуулах тохиолдол

№	ЗААЛТ	ЗОХИЦУУЛАЛТ
1	5.2.6	Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч тогтоосон хугацаанд өмгөөлөгч сонгож аваагүй бол тухайн ажиллагаанд томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна.
2	5.2.7	Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн сонгосон өмгөөлөгч тухайн ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцох боломжгүй байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахаар бол тухайн мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн байцаалтын явцад хийгдэх шүүхийн хэлэлцүүлэгт шүүх, прокурор, мөрдөгч нь томилогдсон өмгөөлөгчийг оролцуулж болно.
3	5.3.2	Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хүсэлтээр, эсхүл зөвшөөрснөөр энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол шүүх, прокурор нь томилогдсон өмгөөлөгч оролцуулна.
4	14.13.4	Шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагчийн өмгөөлөгч хүрэлцэн ирээгүй бол томилогдсон өмгөөлөгч оролцуулж болно.
5	18.1.4	Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч энэ хуулийн 5.2 дугаар зүйлд заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна.

ЭХХШтХ-ийн 5.2-р зүйлийн 6, 7 дахь хэсэгт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч тогтоосон хугацаанд өмгөөлөгч сонгож аваагүй эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн сонгосон өмгөөлөгч тухайн ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцох боломжгүй байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахаар бол тухайн мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн байцаалтын явцад хийгдэх шүүхийн хэлэлцүүлэгт шүүх, прокурор, мөрдөгч нь томилогдсон өмгөөлөгчийг оролцуулж болно хэмээн маш өргөн хүрээтэй зохицуулалт оруулсан.

Энэ талаар Нээлттэй Нийгэм Форумгаас гаргасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх шүүмжид “томилогдсон өмгөөлөгч гэж хэн болох, хэн томилох нь

зохицуулагдаагүй тул хэлбэрийн төдий зохицуулалт болжээ”⁵² гэж дүгнэжээ. Томилогдсон өмгөөлөгч нь хуульчдын холбооны гишүүн, шүүхэд төлөөлөх эрх бүхий этгээд байх нь тодорхой бөгөөд түүнийг шүүх, прокурор томилдог байхаар хуульчилжээ. Гэхдээ шүүх, прокурор, мөрдөгч нь томилогдсон өмгөөлөгч оролцуулахаар заасан боловч хэн нь аль үе шатанд өмгөөлөгч томилох нь тодорхойгүй, яг хэнд нь үүрэг болгоод байгаа нь мөн тодорхойгүй “гурвын дунд” нь орхисон зохицуулалт болжээ хэмээн шүүмжлэн, саналаа хүргүүлж байсан ч хуульд хэвээр батлагдсан байдаг.

Томилогдсон өмгөөлөгчийн хөлс

ЭХХШТХ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд томилогдож оролцож байгаа өмгөөлөгчийн хөлсийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт байхгүй байна. ЭХХШТХ-ийг дагаж 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37-р зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд мөрдөгч, прокурор, шүүгч нь энэ тухай Хуульчдын холбоонд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авна” гэсэн нэмэлт оруулсан байдаг. Энэ зохицуулалтын дагуу мөрдөн байцаах газар, прокурор, шүүхийн байгууллагаас Монголын Хуульчдын Холбоонд албан ёсоор 16 удаа хандаж, тухай бүрт сайн дураар нийтэд тустай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах өмгөөлөгчийг олж оролцуулсан байна.

⁵² ННФ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх шүүмж”
http://forum.mn/res_mat/2017/OSF_Huullin%20shuumj_14.pdf

Хүснэгт 6. МХХ-ноос өмгөөлөгч томилон оролцуулсан тохиолдол

№	Байгууллага	Нэр	2017	2018	2019	Нийт
1	Цагдаагийн байгууллага	БЗД-ийн цагдаагийн 1-р хэлтэс	1			12
		СХД-ийн цагдаагийн 1-р хэлтэс	2			
		Нийслэлийн цагдаагийн газрын Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс	1	3		
		БГД-ийн цагдаагийн 1-р хэлтэс	1	1		
		БЗД-ийн цагдаагийн 3-р хэлтэс,	1		1	
		Хэнтий аймгийн цагдаагийн хэлтэс		1		
2	Шүүхийн байгууллага	Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1			4
		Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1			
		Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх		1		
		Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх		1		
3	Бусад байгууллага	461-р хорих анги	3		2	18
		Эмэгтэйчүүдийн анги	1			
		Багахангай дүүргийн гэр бүлийн хүүхэд залуучуудын хэлтэс	1			
		Өвөрхангай аймгийн 423-р нээлттэй, хаалттай хорих анги	1			
		409-р хорих анги	1			
		Хүүхдийн эрх хамгаалах төв			1	
		Нийслэлийн хүүхэд, гэр бүл, хөгжлийн газар			1	
		Хууль зүйн туслалцааны төв			1	
		Талита-Ази ТББ			1	
		Замын-Үүд хүүхэд хөгжлийн төв			1	
		Дорноговь аймаг хүүхэд хөгжлийн төв			1	
		Архангай аймаг АТГ			1	
Архангай аймгийн Цагдаагийн газар			2			

Харин ЭХХШТХ-ийн 11.4-р зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч хэлмэрч, өмгөөлөгчид төлөх зардал орохоор тусгасан байдаг. Тус зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална⁵³, ЭХХШТХ-ийн 11.6 дугаар зүйл ЭХХША-ны зардал гаргуулах зохицуулалтын 1 дэх хэсэгт “Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг шүүх тогтоовол түүнээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг холбогдох баримтыг үндэслэн гаргуулна” гэж зааснаар шүүгдэгч гэм буруутай нь тогтоогдвол өмгөөлөгчийн зардлыг өөрөө хариуцахаар байна.

Судалгааны энэхүү хэсэгт ЭХХШТХ-ийн хэд хэдэн логик зөрчил ажиглагдсан тул дурдах нь зүйтэй гэж үзлээ.

- Хамгийн энгийн буюу нэр томъёоны зөрчлийг дурдахад ЭХХШТХ-ийн 5.3-ийн 1.2-т “өсвөр насны” гэсэн нэр томъёо хэрэглэсэн. Гэтэл сүүлд батлагдсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох, санхүүжүүлэх журам”-ын 2.6.6-д “насанд хүрээгүй” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, хуулийг хэрэгжүүлэхээр гарсан журам нэр томъёоны хувьд хуультай зөрчилдөж гарсан байна. Гэхдээ ЭХХШТХ-д хэрэглэсэн “өсвөр нас” гэдэг ойлголт нэг талаараа биологийн шинжлэх ухааны хүүхдийн бие бялдар, сэтгэл санаа, оюун ухааны хөгжлийг илэрхийлсэн ойлголт юм. Хүүхдийн эрхийн Конвенцын үндсэн зарчимд “насанд хүрээгүй хүний” гэсэн агуулгаар тусгагдсан байдаг. Ийм нэр томъёог хууль зүйн нэр томъёо болгон ашиглах нь тохиромжгүй байх талтай, учир нь өсвөр насны гэх ойлголт нь 18 насаар хязгаарлагдахгүй. Магадгүй 16-21 орчим насанд хэлбэлзэх боломжтой. Нөгөө талаас, Монгол Улсын иргэний эрх зүйн чадамжийг зохицуулж өгдөг суурь хууль бол Иргэний хууль байдаг. Иргэний хуулийн

⁵³ Засгийн газраас 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 161 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох, санхүүжүүлэх журам”, 2 дугаар хавсралтаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох маягт”-ыг тус тус баталсан.

16 дугаар зүйлийн Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж гэдгийг 16.1-д “Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна” гэж зохицуулж өгсөн байдаг.

- Дараагийн зөрчилтэй харилцаа бол ЭХХШТХ-ийн 5.3 дугаар зүйлийн 1-д “Дараах сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй” гээд 1.2-т “өсвөр насны”-гээд 2 дахь зүйлд “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хүсэлтээр, эсхүл зөвшөөрснөөр энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол шүүх, прокурор нь томилогдсон өмгөөлөгч оролцуулна” гэж тусгасан. Гэтэл ЭХХШТХ-ийн 18.1-ийн 4 дэх хэсэгт “Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч энэ хуулийн 5.2 дугаар зүйлд заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна”гээд давхцуулан зохицуулжээ.
- Мөн хүснэгт 5-д дурдсан зохицуулалтуудад шүүгч, прокурор, мөрдөгч томилогдсон өмгөөлөгч оролцуулна гэсэн ч ХЭЗБТХ-ийн 37.3-т мөрдөгч, прокурор, шүүгч нь энэ тухай Хуульчдын холбоонд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авна хэмээн зохицуулсан. Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-иар шүүгч, прокурор, мөрдөгч өмгөөлөгч томилох, ХЭЗБТХ-иар МХХ өмгөөлөгч томилох арга хэмжээ авах эрхтэй гэсэн хоорондоо логик зөрчил үүсгэсэн зохицуулалтууд тусгагдсан байна.

2.1.2. Төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.2-ын 5 дахь хэсэгт төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах журмыг хуулиар тогтооно гэж шилжүүлсэн байдаг. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг 2006 онд батлан, 2013 онд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдсан. Тус хуулийн дагуу төлбөрийн чадваргүй

сэжигтэн, яллагдагчид, шүүгдэгчид “улсын өмгөөлөгч” хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх тогтолцоог бий болгосон байдаг. Энэ хуулийн хүрээнд Хууль зүйн дотоод хэргийн яамны харьяанд “Хууль зүйн туслалцааны төв”-ийг байгуулан ажиллуулж, улсын өмгөөлөгчдийг сонгон шалгаруулж, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах боломжоор хангаж байна. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д төлбөрийн чадваргүй гэж үзэх үндэслэлийг заасан. Үүнд:

Хүснэгт 7. Төлбөрийн чадваргүй этгээдийн төрөл

№	ЗААЛТ	ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ЭТГЭЭД
1	§7.1.1.	Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн
2	§7.1.2.	Нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо тодорхойлсон хүн
3	§7.1.3.	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн ⁵⁴ 15 дугаар зүйлд заасан онцгой болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд
4	§7.1.4.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд* *эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг

⁵⁴ Тус хууль 2016 онд хүчингүй болж Хүүхдийн эрхийн тухай хууль батлагдсан байх бөгөөд хуульд тусгасан онцгой болон хүнд нөхцөлд байгаа, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх ойлголт тус хуульд тусгагдаагүй байна.

2014 оноос эхлэн төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч авах боломжгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрхээ хамгаалж чадахгүй байгаа, эрх ашиг нь зөрчигдөх магадлал бүхий иргэдэд “Улсын өмгөөлөгч” гэсэн статусаар хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх болсон. Төлбөрийн чадваргүй гэдгийг тодорхойлоход Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар 2016 онд батлагдсан “Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал”⁵⁵-ыг хэрэглэдэг байна. Уг аргачлалын зорилгыг “өрхийн амьжиргааны түвшнийг шууд илэрхийлэх, орлогын талаарх мэдээлэл, арга, аргачлал байхгүй үед түүнийг орлохуйц үзүүлэлтүүдийг ашиглан өрхийн амьжиргааны түвшний үнэлгээг хийж, түүний үр дүнг үндэслэн төрөөс үзүүлэх аливаа төрлийн нийгмийн тусламж, үйлчилгээнд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлох, өрхийн амьжиргааны түвшнээр эрэмбэлсэн өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэхэд оршино” гэснээс авч үзвэл өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлоход чиглэгдсэн аргачлал байх бөгөөд энэ нь хувь этгээдийн төлбөрийн чадварыг тодорхойлоход нийцэх эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Учир нь хувь этгээдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн тухай яригдаж байхад хувь этгээдийн нийтлэг болон өрхийн амьжиргааны түвшнийг шалгуур болгож буй нь зохисгүй юм. Тухайлбал, тухайн өрхийн амьжиргааны түвшин ядуурлын шугамаас дээгүүр боловч өрхийн гишүүд эсрэг тэсрэг ашиг сонирхолтой нөхцөлд өрхийн гишүүн болох гэмт хэрэгт холбогдсон этгээдийн өмгөөлөгчийн хөлсийг гаргаж өгөхгүй байх боломжтой.

Түүнчлэн, гол шалгуур болгож буй ядуурлын шугамыг тооцоход “Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”⁵⁶-ыг ашиглаж байгаа бөгөөд уг аргачлалд “Ядуурлын шугам нь хүний эрүүл, идэвхтэй амьдралыг хангахуйц илчлэгтэй хоол тэжээлийн хэрэгцээг тусгасан хэрэглээний хамгийн бага зардал болно” гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, ядуурлын шугам тооцож буй

⁵⁵ “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох аргачлал” www.rilsp.gov.mn/index.php?Dispatch=attachments.getfile&attachment_id=59

⁵⁶ “Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал” http://web.nso.mn/AAZMS/assets/uploads/files/88154-23_Yaduural.pdf

зорилго нь хүний хоол тэжээлийн хэрэгцээг тусгасан хэрэглээний зардалтай холбоотой бөгөөд өмгөөлөгчийн хөлс төлөх төлбөрийн чадвартай ямар ч холбоогүй гэж үзэж болно. Уг аргачлалын дагуу тооцоолсон ядуурлын шугам нь 2016 оны байдлаар 146145 төгрөг байна. 146000 төгрөгөөс дээш орлоготой байсан ч мэргэжлийн өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлсний хөлсийг төлж чадах эсэх нь асуудал юм.

Ядуурлын хамралтын хүрээ

Он	2010	2011	2012	2014	2016
Ядуурлын шугам (нэг хүний наад захын хэрэгцээг хангах нэг сарын хэрэглээ, төгрөгөөр)	92 072	99 729	118 490	146 650	146 145

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Дэлхийн Банктай хамтарсан "Ядуурлын дүр төрх-2016" ядуурлын тооцооны үр дүн <http://www.worldbank.org/mn/news/press-release/2017/10/17/2016-poverty-rate-in-mongolia-estimated-at-296-percent>

Иймд гол асуудал бол тухайн этгээд сард хэдэн төгрөгийн орлоготой байж өөрийн өмгөөлөгчийн хөлсийг төлж чадах вэ? гэдэгт анхаарах хэрэгтэй болов уу. Энд ядуурлын шугамаас илүүтэй гэмт хэрэгт холбогдсон этгээдийн сарын орлого, зах зээл дээрх өмгөөллийн дундаж хөлс гол ач холбогдолтой үзүүлэлт болох юм. Судалгааны явцад ч практикт ажиллаж байгаа мөрдөгч, прокуророос авсан социологийн судалгаагаар хэргийн оролцогчдын хууль зүйн туслалцаа авч чадахгүй байгаа хамгийн түгээмэл шалтгаан бол санхүүгийн чадамжгүй, өмгөөлөгч хөлслөн авч чадахгүй нөхцөл байдлаас болдог гэж хариулсан байдаг.⁵⁷ Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй гэдгийг тогтоож буй шалгуур нь бодит нөхцөл байдалд төлбөрийн чадваргүй байдлыг бүрэн тогтоож чадахгүй байна уу? гэсэн эргэлзээг төрүүлж байна.

⁵⁷ Хавсралт график 4-өөс харах боломжтой.

Япон Улсад сэжигтэн яллагдагчийн төлбөрийн чадварыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд зааснаар тухайн этгээдэд байгаа бэлэн мөнгө, хадгаламж болон бусад Засгийн газрын захирамжид заасан болон эдгээртэй адилтгах хөрөнгийн нийлбэр хэмжээгээр төлбөрийн чадварыг тодорхойлдог. Төлбөрийн чадварыг тодорхойлох үндсэн үзүүлэлт нь тухайн этгээдэд байгаа бэлэн мөнгө байна. Бэлэн мөнгөнөөс гадна тухайн этгээдэд байгаа хадгаламж мөн хамаардаг. Өөрөөр хэлбэл, зөвхөн бэлэн мөнгө болон хадгаламж л сэжигтэн, яллагдагчийн төлбөрийн чадварыг тодорхойлох үзүүлэлт болж байгааг харж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль

§362.1 Энэ хуульд заасан өмгөөлөгч шаардлагатайгаас бусад тохиолдолд яллагдагч нь өмнөх зүйлийн хүсэлтийг гаргахдаа төлбөрийн чадварын тухай мэдүүлэг (тухайн этгээдэд байгаа бэлэн мөнгө, хадгаламж болон бусад Засгийн газрын захирамжид заасан эдгээртэй дүйцэх хөрөнгийн нийлбэр хэмжээгээр төлбөрийн чадварыг тодорхойлно) гаргана.

2006 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 362-р зүйлд заасан “хөрөнгө” болон тус хуулийн 363 –р зүйлийн 1 дэх “стандарт хэмжээ”-г Засгийн газрын захирамжаар дараах байдлаар тогтоожээ.

Засгийн газрын захирамж

§1.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 362-д заасан Засгийн газрын захирамжид заасан хөрөнгө нь дор дурдсан зүйлс байна.

§1.1.1 Чекийн хуулийн 6-р зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу санхүүгийн байгууллагаас гаргасан чек

§1.1.2 Хоршоонд хадгалуулсан мөнгөн хөрөнгө

§1.1.3 Хөдөлмөрийн хуулийн 18-р зүйл эсвэл Усан онгоцонд ажиллагсдын хуулийн 34-р зүйлийн заалтын дагуу хадгалуулж буй ажилтны хадгаламжийн мөнгө

§1.1.4 Төрийн албан хаагчийн хамтын үйлдвэрчний эвлэлийн хуулийн 102-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдвэрчний эвлэлийн гишүүн хадгаламж, эсвэл Хувийн сургуулийн багш нарын хамтын сангийн хуулийн 26-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллагад элссэн этгээдийн хадгаламж

§2.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 363 –р зүйлийн 1 дэх хэсэгт заасан Засгийн газрын захирамжид заасан стандарт хэмжээ нь 500000 иен байна.

Япон Улсад төлбөрийн чадваргүй гэж үзэх шугам нь 500000 иенээр тогтоогдож байгаа бөгөөд сэжигтэн, яллагдагчийн зөвхөн бэлэн мөнгө, хадгаламж нь уг дүнг давж буй эсэхийг шалгадаг.

Хууль зүйн туслалцаа үзүүлж буй этгээдийн хараат бус байдлын баталгаа

НҮБ-ын удирдамжийн 2 дахь зарчимд “Төр нь хууль зүйн туслалцаа үзүүлж буй этгээдийн хараат бус байдал, хууль зүйн туслалцаа авч буй этгээдийг өмгөөлөх байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно”⁵⁸, 12 дахь зарчимд “Төр нь хууль зүйн туслалцаа үзүүлж буй этгээд (legal aid provider) хараат бус, чөлөөтэй, үр нөлөөтэй ажиллах байдлыг бүрдүүлэх ёстой” гэж тус тус заажээ.

Манай улсын хувьд, тухайлбал “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийн 11-р зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар “Улсын өмгөөлөгч нь ажил үүргийн болон хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны зарчмаар зохион байгуулагдан ажиллана”, мөн тус хуулийн 15-р зүйлийн 1 дэх хэсэгт “Төвийн захирал болон салбарыг ахлах улсын өмгөөлөгч нь дотоод зохион байгуулалтын шинжтэй үйл ажиллагаанаас бусад асуудлаар улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно” гэж заасан нь улсын өмгөөлөгчийн хараат бус байдлыг хангахыг зорьсон зохицуулалтууд болжээ.

Гэвч тус хуулийн 16-р зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын өмгөөлөгч нь Төвийн салбарт ажиллах хуульч байх бөгөөд төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ” гэж заасны дагуу Хууль зүйн туслалцааны төв гэх төрийн байгууллагад хөдөлмөрийн гэрээний дагуу ажилладаг ажилтан болох нь харагдаж байх бөгөөд улсаас цалинжиж буй юм. Энэ нь өмгөөлөгч мэргэжлийн чөлөөт үйл ажиллагаа эрхлэгч гэсэн шинжийг алдагдуулж өмгөөлөгчийн

⁵⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх зарчим, чиглэл. Пара.16

хараат бус байдал алдагдах эрсдэлтэй. Үүнийг мөн тус хуулийн 17-р зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “ут хуульд зааснаас гадуур бие даан өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон”-оос харж болохоор байна.

Төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцааны зардлын зохицуулалт

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45-р зүйлийн 2 дахь хэсэгт “төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна” хэмээн маш өргөн хүрээтэйгээр хуульчилж өгсөн. Мөн ЭХХШТХ-ийн 11.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Эрүүгийн хэргийг энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, шүүгдэгчийг цагаатгасан, эсхүл ял шийтгүүлсэн хүн, хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон бол түүнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас чөлөөлж, зардлыг төр хариуцна” хэмээн зохицуулсан.

Засгийн газар 2018 оны 161 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох, санхүүжүүлэх журам”-ын 2.6.6-д “насанд хүрээгүй, төлбөрийн чадваргүй хохирогч, гэрчийн өмгөөлөгчийн өмгөөллийн үйлчилгээний хөлсийг хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд заасан хэмжээгээр” хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд тооцож хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа байгууллага болон прокурор, шүүх, шүүхийн шинжилгээний байгууллагын тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр зохицуулсан байна. Тус журмын 5.3-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлөгчийн хөлсийг төрөөс төлсөн тохиолдолд өмгөөлөгчид төлсөн зардлыг нөхөн төлүүлэхгүй” хэмээн зохицуулсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахтай холбоотой зардлыг Төлбөрийн чадваргүй яллагдагчид

үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль (ТЧЯҮХЗТХ), Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (ХЭЗБТХ), Засгийн газрын тогтоолоор нэг мөр биш, өөр өөр агуулгаар зохицуулсан байна. Бодитоор хэрэгжиж байгаа нь ТЧЯҮХЗТХ-иар төлбөрийн чадваргүй яллагдагчид улсын өмгөөлөгч томилж оролцуулах, хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс олгодог тогтолцоо хэрэгжиж байна. Харин МХХ-ноос төлбөрийн чадваргүй иргэнд сайн дураар, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх иргэдийг зуучлах, холбох байдлаар ажиллаж байна.

2.2. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХЭЭ ЭДЛЭХ БОЛОМЖ

ЭХХШТХ-д зааснаар хэргийн оролцогч өмгөөлөгч авах эрх, өөрийгөө гэмт хэрэгт сэжиглэгдэж буйгаа эрх бүхий албан тушаалтнаас мэдсэн үеэс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн өмгөөлөгчийг оролцуулах боломжтой.

Хүснэгт 8. Хууль зүйн туслалцаа авах боломжтой эрцүгийн хэрэг хянан шийдвэрлэх шат

№	2002 ОНЫ ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ	2017 ОНЫ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
1	§10.5. Сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна. §18.1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй.	§31.2.1. Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ. §18.3 Хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулна.

үргэлжлэл ►

§35.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана: уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан; гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан; уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон; уг этгээд хэргээ илчлэн ирсэн; гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

§35.2.7. Өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу өмгөөлөгч авах;

§38.3. Энэ хуулийн 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн, ийм ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй.

§59.3. Тогтоол, захирамжийг сэжигтэнд танилцуулах ба түүнд энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх, түүний дотор өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхтэй болохыг нь тайлбарлаж өгөх ба энэ тухай тэмдэглэлд тусгана.

Сэжигтнээр тооцогдсон, эсвэл баривчлагдсан үеэс эхлэн өмгөөлөгч авах боломжтой байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэгт шалгагдаж байна гэдгээ мэдсэн үеэс эхлэн хууль зүйн туслалцаа авах эрхтэй байна.

§31.6. Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа

1. Мөрдөгч баривчлагдсан сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэр танилцуулахаас өмнө, шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан бол баривчилсан даруй түүнд дараах зүйлийг танилцуулна:

1.1. ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа;

1.2. хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох;

1.3. түүний хийсэн үйлдэл, хэлсэн үг өөрийнх нь эсрэг шүүхэд нотлох баримт болохыг анхааруулах;

1.4. хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол холбогдох хуульд заасны дагуу албадлага хэрэглэхийг сануулах.

§7.1.1. Энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ.

§31.3.3. Сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан яллагдагчийн эрхийг тайлбарлан өгч, тэр тухай тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.

§31.7.3. Баривчлагдаж байгаа сэжигтэнд эрхийг нь танилцуулсан цаг, минутыг тэмдэглэж, гарын үсэг зуруулна. Гарын үсэг зурах боломжгүй, эсхүл гарын үсэг зураагүй бол энэ тухай тэмдэглэлд тусгана.

Баривчлагдсан, эсвэл яллагдагчаар татах тогтоолтой танилцсан үеэс эхлэн өмгөөлөгч авах эрх нээгдэж байна. 2002 оны ЭБШТХ-тай адил буюу гэмт хэрэгт өөрийгөө шалгагдаж байна гэдгээ мэдсэн үеэс эхлэн хууль зүйн туслалцаа авах эрхтэй байна

Гэмт хэрэгт холбогдсон этгээд нь баривчлагдсан, эсвэл яллагдагчаар татах тогтоолтой танилцсан үеэс эхлэн өмгөөлөгч авах эрхтэй. Гэвч уг эрхээ хэрхэн яаж эдлэх тухай зохицуулалт

байхгүй. Ялангуяа баривчлагдсан этгээд өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэхийг хүсвэл мөрдөгч, прокурор, шүүгч нар нь ямар арга хэмжээ авах талаар хуульд тодорхойгүй байна.

Түүнчлэн энэ хэсэгт анхаарах гол зүйл нь зөвхөн өмгөөлөгч авах эрхтэй гэдгийг сануулсан төдий байх бөгөөд хуульд заасан нэмэлт боломжуудын талаар мэдээллийг сэжигтэнд сануулах, танилцуулах үүрэг болгосон зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл, өмгөөлөгч авах эрхтэйгээс гадна өмгөөлөгчөөсөө татгалзах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгчтэй байх хуульд заасан тохиолдлууд тэр дундаа төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө өөрөө сонгож авч чадаагүй бол төрөөс өмгөөлөгч томилж өгдөг талаар, өмгөөлөгчийн үйл ажиллагаа хуулиар хамгаалагдсан байх талаар мэдээллийг өгдөг байх нь чухал юм.

Эндээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч нь хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулаад зогсохгүй уг эрхээ хэрхэн эдлэх, хуульд заасан ямар боломж байгаа талаар тайлбарлах, өмгөөлөгчтэй холбож өгөх бүхий л арга хэмжээ авах үүрэг болгосон зохицуулалт байх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна. Шинэ ЭХХШТХ-д үндсэн санаа туссан хэдий ч тухайн агуулгыг хэрэгжүүлэх журам, механизм тусгагдаагүй хэвээр байна. Тухайлбал, ЭХХШТХ-ийн 7.5-р зүйлийн 1 дэх хэсэгт “Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар шүүх, прокурор, мөрдөгчөөс энэ хуульд заасны дагуу өгөхийг зөвшөөрсөн мэдээллийг авах эрхтэй” гэж мэдээлэл өгөх тухай зохицуулсан боловч хэт ерөнхий, хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрхэн эдэлж болох талаар мэдээлэл энэ зохицуулалтад хамаарах эсэх нь тодорхойгүй. Нөгөө талаас авч үзвэл, яллагдагч эрхтэй хэмээн зохицуулсан тул яллагдагч эрхээ эдлэхийг шаардаагүй нөхцөлд уг заалт хэрэгжих боломжгүй юм. Хууль зүйн туслалцаа авах эрх нь позитив эрх тул төрийн идэвхтэй оролцоо байж бодитоор хэрэгжих боломжтой болдог.

Иймд хууль зүйн туслалцаа авах эрхийг бодитоор эдлүүлэх зорилгоор мөрдөгч, прокурор, шүүгчдээс гэмт хэрэгт холбогдсон этгээдэд түүний эдлэх боломжтой эрхийн талаар дэлгэрэнгүй байдлаар мэдээлэх үүрэгжүүлсэн зохицуулалт бий болгох

шаардлагатай. Мөн сэжигтэн, яллагдагч нь өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэхийг хүсвэл мөрдөгч, прокурор, шүүгч нар нь ямар арга хэмжээ авах талаарх журмыг тодорхой байдлаар хуульчлах шаардлагатай юм.

Шүүгчдээс авсан судалгаагаар шүүхэд шилжин ирсний дараа хэргийн оролцогчдын 43 хувь нь хууль зүйн туслалцаа авах эрхээ эдэлдэг, мөн шүүх хурлын өмнө 28 хувь нь өмгөөлөгчтэй болдог гэсэн хариултыг өгсөн⁵⁹ буюу ерөнхийдөө эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргийн 60-аас дээш хувь нь шүүхийн шатанд шилжин ирсний дараа өмгөөлөгч авдаг нөхцөл байдал ажиглагдаж байна. Хэрэг шүүхийн шатанд шилжих гэдэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах, прокурорын хяналтын шатанд хэрэг хянагдаж хэргийн нөхцөл байдал ерөнхийдөө тодорхой болсон, шүүхийн шатанд оролцож буй өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалан мэтгэлцэх, нотлох баримт нэмж бүрдүүлэх, цуглуулах зэрэг боломж хомс болсон байдаг үе юм.

Мөн ХЭҮК-оос 2016 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийн 2 дугаар бүлгийн “Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт” судалгаанд өмгөөлөгчийг аль үе шатанд авсан талаар судалж үзэхэд нийт 530 цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн 107 буюу 20 хувь нь хэрэгт холбогдсон үеэс, 169 буюу 31 хувь хувь нь сэжигтнээр тооцогдсон үеэс, 93 буюу 17 хувь нь ял сонгож яллагдагчаар татсан үед, 45 буюу 8 хувь нь прокурорт шилжсэн үед, 97 буюу 18 хувь нь шүүхийн шатанд гэж хариулсан байдаг. ХЭҮК-оос хийсэн судалгаа нь цагдан хоригдож байгаа буюу ихэвчлэн хүнд болон онц хүнд гэмт хэрэгт шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэдгийг анхаарах хэрэгтэй. Үүнээс хууль зүйн туслалцаа авч эхлэх үе нээлттэй буюу хэрэгт холбогдсон цагаас эхлэн авах боломжтой гэдэг нь харагдаж байна.


⁵⁹ Хавсралт график 1-ээс харах боломжтой.

2.2.1. Хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэхтэй холбоотой хийгдэж буй ажиллагаа

Аливаа этгээд гэмт хэрэгт холбогдсон гэдгээ мэдэн хууль зүйн туслалцаа авахыг хүсвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй мөрдөгч, прокурор, шүүгч ямар хугацаанд, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой вэ? гэсэн асуулт урган гарч ирнэ. Тухайлбал, төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй мөрдөгч, прокурор, шүүгч улсын өмгөөлөгчтэй хэрхэн холбогдох, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг төлбөрийн чадваргүй гэдгийг тогтоох талаар мөрдөгчийн хэрэгжүүлэх ажиллагааны талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй. Мөн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг хэдий үеэс авах талаар тодорхой зохицуулалт байхгүй. Хэдийгээр төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6-р зүйлийн 2 дахь хэсэгт яллагдагчаас гадна сэжигтэн, шүүгдэгч, ялтан мөн хамаарах талаар зохицуулсан тул сэжигтэн болсон үеэс уг эрхийг эдлэх боломжтой юм.


Хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрхэн сануулж байгаа талаар ХЭҮК-оос хийсэн судалгаанд өмгөөлөгчтэй 529 хэргийн хоригдогчдын 294 буюу 55 хувьд баривчлах үед өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулж, 205 буюу 38 хувьд сануулаагүй байна.

График-1. ХЭҮК-ын судалгаа: Өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулсан эсэх нь



Харин өмгөөлөгчгүй 108 хоригдогчийн 5 хариулаагүй бол 103 нь уг асуултад дараах байдлаар хариулсан байна.

График-2. ХЭҮК-ын судалгаа: Өмгөөлөгчгүй хохирогчдод өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулсан эсэх



Судалгааны хүрээнд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах чиглэлээр мөрдөгчийн зүгээс ямар ажиллагаа хийдэг талаар тодруулахад (хавсралт график-8) 65 хувь нь байцаалт, мэдүүлэг авах авах үед сануулж тэмдэглэлд тусган, гарын үсэг зуруулдаг хэмээн хариулсан бол, 22 хувь нь эрх сануулан баримтад гарын үсэг зуруулдаг, 9 хувь нь хэргийн материалтай танилцах баримтад гарын үсэг зуруулах хэлбэрээр, 4 хувь нь эрх сануулдаг ч, баримт үйлддэггүй хэмээн хариулсан байна. Харин өмгөөлөгчдийн хувьд (хавсралт график-10) 50 хувь нь эрх сануулах баримтад гарын үсэг зуруулдаг, 29 хувь нь байцаалт, мэдүүлгийн тэмдэглэлд тусгадаг, 12 хувь нь хэргийн материалтай танилцсан баримт дээр зуруулах хэлбэрээр явагддаг, 9 хувь ямар нэгэн байдлаар эрх сануулсантай холбоотой баримт үйлддэггүй гэжээ.

Мөн прокурорын хувьд (хавсралт график-6) хууль зүйн туслалцаа авах эрхийг 32 хувь нь байцаалт, мэдүүлэг авах үед, 30 хувь хэрэгт холбогдон шалгагдах үеэс, 19 хувь мөрдөн шалгах үед, 17 хувь нь эрүүгийн хэрэг үүсгэхэд, 2 хувь нь мөрдөх ажиллагаа дуусгавар болох үед хэмээн хариулсан байна. Үүнээс үзэхэд практикт ихэвчлэн мэдүүлэг, байцаалт авах үед хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулдаг, түүнийгээ тэмдэглэлдээ тусгадаг, мөн ЭХХШТХ-д хууль зүйн туслалцаа авах эрхийг хэдийд танилцуулж, ямар ажиллагаа хийж байх ёстой талаар тодорхой зохицуулалт байхгүй, мөн хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой бусад ажиллагааг мөрдөгчийн зүгээс хэрхэн хийх талаар хуулийн зохицуулалт байхгүй, энэ талаар ч тодорхой ажиллагаа хийдэггүй гэж ойлгож болохоор байна.

Харин Прокурорын шатанд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдэлж чадалгүй шилжин ирсэн нөхцөлд Прокурорын зүгээс (хавсралт график-5) 48 хувь хууль зүйн туслалцаа авах эрхийг нь сануулах, 40 хувь хууль зүйн туслалцаа авах боломжоор хангах, 12 хувь нь даалгавар бичин буцаах арга хэмжээ авдаг хэмээн хариулжээ. Хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах ажиллагаанд Прокурор чухал оролцоотой субъект бөгөөд прокурор эрүүгийн хэргийг хянахдаа өмгөөлөгч авсан эсэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахтай холбоотой мөрдөгчийн зүгээс тодорхой хяналт тавьж, эрхийг хангах чиглэлд илүү анхаарвал үр дүнтэй

гэж харагдаж байна. Энэ талаар мөн ХЭҮК-ын 2016 оны 15 дахь илтгэлд прокурорын байгууллага нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрхэн хангаж байгаад тавих хяналтаа илүү сайжруулах шаардлагатай талаар дурдсан байдаг⁶⁰.

2.2.2. Өмгөөлөгч сонгохтой холбоотой хийгддэг ажиллагаа

Судалгааны явцад прокуроруудаас авсан судалгаанд (хавсралт график-7) өмгөөлөгч авах хүсэлтэй иргэнд ямар арга хэмжээ авдаг талаар тодруулахад 54 хувь нь өмгөөлөгч сонгох хугацаа тогтоож өгдөг бол, 18 хувь нь МХХ-ны өмгөөлөгчдийн жагсаалтыг санал болгодог, 14 хувь нь өмгөөлөгч авах эрхийг тайлбарлаж өгдөг, 7 хувь нь мэргэшсэн өмгөөлөгчийн мэдээлэл өгөх, 7 хувь нь өмгөөлөгч санал болгодог хэмээн хариулсан байдаг.

Хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахтай холбоотойгоор мөрдөгч, прокурор зэрэг оролцогч субъектүүдийн зүгээс таньдаг, мэддэг өмгөөлөгч нараа санал болгох, авахыг шаардах, албадах зэрэг үйлдэл гардаг байж болзошгүй байна. Тухайлбал, ХЭҮК-ын 15 дахь тайланд санал асуулгад оролцсон цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч шүүгдэгчийн 43 буюу 8 хувь нь мөрдөгчийн санал болгосноор, 20 буюу 4 хувь нь шүүгчийн санал болгосноор өмгөөлөгчөө сонгосон хэмээн хариулжээ. Хэдийгээр мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс эрүүгийн хэргийн оролцогчид хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэхтэй холбоотой ажиллагаа хийж болох ч тухайлсан өмгөөлөгчийг нэр заан тулгах, санал болгох нь хуульчийн болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болоод ЭХХШТХ-ийг зөрчсөн үйлдэл юм.

ХЭЗБТХ-д мэргэшсэн өмгөөлөгч байж болох талаар зохицуулалт байдаг ч, ямар өмгөөлөгчийг тухайн салбарын эрх зүйн харилцаанд мэргэшсэн өмгөөлөгч гэж үзэх талаар нарийвчилсан зохицуулалт, журмыг одоог хүртэл батлаагүй байгаа. Мөн МХХ-ны цахим

⁶⁰ ХЭҮК “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл” 2016 он, УБ хот, 66 дахь тал.

хуудсанд нийт өмгөөлөгчдийн нэрийн жагсаалтыг нийтэлсэн байх бөгөөд түүнээс тухайн орон нутаг, газарт, эрүүгийн эрх зүй, түүнээс нарийвчилсан хэргийн төрөлд дагнан ажилладаг өмгөөлөгч нарын мэдээлэл одоог хүртэл хангалттай байхгүй зэргээс үүдэн мөрдөгч, прокурорын зүгээс ажиллагаа хийхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэдэг байна.

Гэхдээ хууль зүйн туслалцаа авах эрх сануулах, эдлүүлэхтэй холбоотой ажиллагаа нь зөвхөн өмгөөлөгч авах уу, эсхүл үгүй юу гэсэн асуултаар хязгаарлагдахгүй, түүнийг дагаад гарах хууль зүйн үр дагавар, боломжийг танилцуулах, хэрхэн эрхээ хэрэгжүүлэх талаар арга замыг зааж өгөх гэх мэт өргөн хүрээний ойлголт юм.

2.3. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙН БАТАЛГАА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгч оролцуулах шаардлагатай гэж хуульд зааснаас бусад тохиолдолд ЭХХШТХ-ийн 5.3-р зүйлийн 3 дахь хэсэгт “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болно” гэж хуульчилсны дагуу сэжигтэн, яллагдагч нь өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргаснаар өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах шаардлагагүй болдог. Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авахаас татгалзсан гэдгийг бичгээр баталгаажуулж буй нь ач холбогдолтой зохицуулалт боловч, судалгааны 1.3 дугаар хэсэгт дурдсанчлан хөндлөнгийн шахалт, дарамтгүйгээр хууль зүйн туслалцаа авах эрхээс татгалзсан эсэхэд хяналт тавьж, дараа дараагийн шат бүрт хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулах, эдлэх хүсэлтэй эсэхийг тодруулж, баталгаажуулж байх зохицуулалт мөн шаардлагатай байна.

Өмгөөлөгчийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо эдлэх эрх 2002 оны болон 2017 оны эрүүгийн процессын хуулиудыг харьцуулан Хсүнэгт 9-д харуулав.

Хүснэгт 9. Өмгөөлөгчийн эрх

№	2002 ОНЫ ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ	2017 ОНЫ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
1	41.3.1. хэрэгт оролцох үеэс эхлэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчтой ганцаарчлан уулзах, тэдгээрийг байцаахад байлцах, асуулт тавих	5.1.2.1. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих
2	41.3.2. энэ хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт тавих, гаргаж өгөх, түүнийгээ шалгуулан хавтаст хэрэгт тусгуулах	5.1.2.2. хохирогч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авхуулахаар хүсэлт гаргах
3	41.3.3. хохирогч, гэрч, шинжээчийг байцаахад байлцаж, тэдгээрт асуулт тавих	5.1.2.3. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шинжээчийн дүгнэлттэй танилцах, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах
4	41.3.4. өмгөөлж байгаа этгээдийнхээ болон өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байлцаж тухайн ажиллагаанд оролцож байгаа гэрч, шинжээч, бусад этгээдэд аль ч үед асуулт тавих	5.1.2.4. хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох
5	41.3.5. өөрийн байлцсан байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай саналаа бичгээр гаргах	5.1.2.5. өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах
6	41.3.6. өөрсдийнх нь зөвшөөрснөөр иргэн, хуулийн этгээдээс тайлбар, баримт бичиг, тодорхойлолт гаргуулж авах	5.1.2.6. өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах
7	41.3.7. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах	5.1.2.7. өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, тодорхойлолт гаргуулж авах;

үргэлжлэл ►

8	41.3.8. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардлаар хувилах, хуулбарлан авах	5.1.2.8. мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлт гаргах
9	41.3.9. шүүх хуралдаанд оролцох	5.1.2.9. хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах
10	41.3.10. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах	5.1.2.10. шүүхийн хэлэлцүүлэгт оролцох
11	41.3.11. өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих асуудлыг шүүхэд шийдвэрлэхэд хүсэлтээрээ байлцаж, шүүхэд санал гаргах	5.1.2.11. мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах
12	41.3.12. давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд хүсэлтээрээ оролцох	5.1.2.12. сэжигтнийг баривчлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох
13		5.1.2.13. анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох
14		5.1.2.14. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж оролцогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх санал гаргах
15		5.1.2.15. энэ хуульд заасан бусад эрх.

ЭХХШТХ-ийн 5.1-р зүйлийн 2.1 дэх хэсэгт “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих” гэж хуульчилсан байх боловч өмгөөлөгчид уг ажиллагааны тухай хэрхэн мэдэгдэх, мэдүүлэг авахаар бол заавал өмгөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй эсэх зохицуулалт байхгүй

байна. Иймд мөрдөн шалгах ажиллагаа, тодруулбал мэдүүлэг авах ажиллагаанд өмгөөлөгчтэйгөө хамт мэдүүлэг өгөх эрхийг хэрхэн хангах нь сонирхол татсан асуудал юм. Мэдүүлэг авахтай холбоотой ЭХХШтХ-ийн зохицуулалтыг харвал:

§12.1.2 Мөрдөгч нь яллагдагчаас мэдүүлэг авах зайлшгүй шаардлагатай бол прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ.

§12.1.5 Цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих байранд нь, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах байгууллагад дуудан ирүүлж мэдүүлэг авна.

§16.1.2 Баримтат мэдээлэл нь яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгээр тогтоогдоно.

§16.3.2 Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцох боловч уг мэдүүлэг дангаараа түүнийг яллах үндэслэл болохгүй.

§16.11.1.3 Өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхийг зөрчиж мэдүүлэг авсан тохиолдолд өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгсөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байх.

§25.1.6 Мөрдөгч мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна.

§28.3.1 Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлийг тухайн ажиллагаа дуусмагц ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд даруй танилцуулж, гарын үсэг зуруулна.

§28.3.5 Тэмдэглэлийн маягтад мэдүүлэг өгсөн хүний санал, хүсэлтийн тэмдэглэх хэсгийг оруулна.

§31.3.4 Мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг 6 цагийн дотор явуулна.

§31.6.4 Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор түүний хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагааг явуулна.

ЭХХШтХ-ийн 31.11-р зүйлд сэжигтнээс мэдүүлэг авах харилцааг зохицуулсан байх бөгөөд мөрдөгч нь мэдүүлэг авахдаа өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, өмгөөлөгч байлцуулан мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах гэх мэт эрхүүдийг тайлбарлаж өгөн мэдүүлэг авахаар хуульчилсан байна. Гол асуудал нь эдгээр эрхээ хэрэгжүүлэх эсэхээ өмгөөлөгчтэй зөвлөлдөж амжилгүйгээр гэмт хэрэгт холбогдсон этгээд өөрөө бие даан гаргахад хүрч байна.

Үүнээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль нь гэмт хэрэгт холбогдсон этгээд эхлээд өмгөөлөгчтэйгөө харилцаж байж мэдүүлэг өгөх эсэхээ шийдэх зохицуулалтыг урьтал болголгүй эсрэгээр нь сэжигтний эрхийг хоёрт тавьж гэмт хэргийн мэдээллийг олж авахыг урьтал болгосон гэдэг нь харагдаж байна. Тухайлбал, ЭХХШтХ-ийн 31.3-р зүйлийн 4 хэсэгт “Мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг 6 цагийн дотор явуулна”, 31.11-р зүйлийн 3 дахь хэсэгт “Сэжигтний сонгон авсан өмгөөлөгч 2 цагийн дотор хүрэлцэн ирээгүй, эсхүл өмгөөлөгч авахаас татгалзсан бол энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч оролцуулна” гэж заасан нь дээрх дүгнэлтийг баталгаажуулж байна.

Эрүүгийн хэрэгт холбогдсон этгээд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдэлж байж өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн хэмжээнд хамгаалах чадамжтай болох учиртай тул сэжигтэн, яллагдагчид хууль зүйн үр дагавар, учир холбогдлыг ойлгуулж байж хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх эсэх шийдвэрийг гаргуулах учиртай.

2.4. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хууль зүйн туслалцаа авах эрхийн талаар хөндөхөд Үндсэн хуульд тусгасны дагуу хэргийн оролцогч өөрөө хүсвэл өөрийгөө өмгөөлөх эрхтэй байхаар тусгасан. Хэдийгээр өөрийгөө өмгөөлөх эрхтэй ч хэрэг хянан шийдвэрлэх аль ч үе шатанд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх хүсэлт гаргах боломжтой. Гэвч дээрх судалгаанаас үзэхэд, Монгол Улсын ЭХХШТХ-д зохицуулалтын хувьд хэт ерөнхий, эрхийг хэрхэн эдлүүлэх талаар уг хуульд нарийвчилсан зохицуулалт хомс байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гардан хэрэгжүүлдэг мөрдөгч, прокурорууд дотооддоо хэрэглэдэг тусгай заавар, зөвлөгөөгөөр нарийвчлан зохицуулдаг хэмээн ярьдаг ч олон нийтэд ил биш, бид эдгээр заавар, зөвлөмжийг судалгаанд оруулахыг хүссэн ч олдоогүй болно.

2017 оны ЭХХШТХ-д шинээр хуульчлагдсан “томилогдсон өмгөөлөгч” оролцуулах тухай зохицуулалт нь хууль зүйн туслалцааг төрөөс хангаж байгаа хэлбэр мөн үү, эсхүл процесс ажиллагааг хурдасгах гэсэн арга уу? гэдэг нь одоогоор хуулийн хэрэгжилтээс тодорхой харагдахгүй байна. ЭХХШТХ-д томилогдсон өмгөөлөгч оролцуулах 5 өөр зүйл, заалт байгаа боловч МХХ-нд хандаж өмгөөлөгч томилуулж байгаа тохиолдол ихэвчлэн насанд хүрээгүй, төлбөрийн чадваргүй хохирогчдын хувьд байна. Харин бусад хуульд заасан нөхцөлд өмгөөлөгч томилон оролцуулахад хүндрэлтэй, сайн дураараа ажиллах өмгөөлөгч олоход ч төвөгтэй байна.

2013 онд Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль баталж, 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн ч төлбөрийн чадваргүй гэдгийг тогтоох, яллагдагчаас бусад хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч гэх мэт оролцогч төлбөрийн чадваргүй нөхцөлд хууль зүйн туслалцаа авах талаар хуулийн тодорхой зохицуулалт байхгүй байна. Дээр дурдсаны дагуу зарим тохиолдолд МХХ-оос өмгөөлөгч томилуулах байдлаар шийдвэрлэж байна. Мөн мөрдөгч, прокурор, шүүгчид төлбөрийн чадваргүй бусад оролцогчдын хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрхэн эдлэх тал дээр мэдээлэл өгөх, танилцуулах зохицуулалт, мөн практик туршлага ч бага байгаа нь ажиглагдав.

I	II	
ӨӨРИЙГӨӨ ӨМГӨӨЛӨХ	ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ	
Өөрийн сонгосон өмгөөлөгч	Томилогдсон өмгөөлөгч	Улсын өмгөөлөгч *хувийн өмгөөлөгч
Өмгөөлөгчөө өөрөө сонгож авах	Тогтоосон хугацаанд өмгөөлөгч сонгож аваагүй, сонгосон өмгөөлөгч тухайн ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцох боломжгүй байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахаар бол	Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх
ЭХШХШТХ-ийн §5.3.3	ЭХШХШТХ-ийн §5.2.6, §5.2.7	ЭХШХШТХ-ийн §5.2.5
Хууль зүйн үндэслэл	ЭХШХШТХ-ийн §5.2.1, §5.2.2	ЭХШХШТХ-ийн §5.3.2
Гол асуудал	Томилогдсон өмгөөлөгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оролцуулах талаар тодорхой журам байхгүй.	Төлбөрийн чадваргүй болохыг тогтоох аргачлал бодит байдалтай нийцэхгүй буюу өмгөөлөгч хөлслөх төлбөрийн чадвартай уялдаагүй

Дээрх хүснэгтэд дурдсан тодорхойгүй асуудлууд нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч эрт үеэс оролцоход саад болж байна.

Япон Улсын хувьд улсаас томилогдох өмгөөлөгчийг шүүгч томилно. Хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хууль зүйн туслалцааны төвийг байгуулж, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг тус төв хариуцаж байна. Уг төв нь улсаас томилогдсон өмгөөлөгчөөр ажиллах сонирхолтой өмгөөлөгч нартай гэрээ байгуулж, хөлсийг тогтоосон журмын дагуу төлдөг. Япон Улсад хууль зүйн туслалцаа авах эрхийг маш цогц байдлаар хамгаалсан байна. Тухайлбал сэжигтэн, яллагдагч өмгөөлөгч сонгож авах эрхтэй ч өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй бол улсаас өмгөөлөгч томилон өгөх заалтыг оруулж өгсөн.

Харин манай улсын тухайд ЭХХШТХ-ийн Шүүхийн эрх хэмжээг зохицуулсан 3-р бүлэг, Прокурорын бүрэн эрхийг зохицуулсан 4-р бүлэг, Мөрдөгчийн эрх хэмжээг зохицуулсан 6-р бүлэгт зөвхөн эрүүгийн хэргийг шийдвэрлэх, мөрдөн шалгах ажиллагааны чиг үүргийг л тусгасан байх бөгөөд сэжигтэн, яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах арга хэмжээний талаар огт дурдаагүй байна. ЭХХШТХ-ийн 35.6-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Шүүгч хуралдаанд оролцогчид түүний эрх, үүргийг тайлбарлах үеэр шүүгдэгчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх хангагдсан эсэхийг тодруулдаг байна. Энэ нь хамгийн эхний үе шатнаас эхлэн зөв мэдээллээр хангах тухай асуудал юм. Гэтэл Монгол Улсын хувьд мэдээлэл өгөхтэй холбоотой ерөнхий зохицуулалт байгаа ч, хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх чиглэлд хангалттай хэмжээний мэдээлэл, чиглүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байгаа гэдэг нь шүүгч нараас авсан судалгаа болон ХЭҮК-ын 15 дахь илтгэлд дурдсан судалгаа зэргээс харагдаж байна.

	I	II	III
	Өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг сануулах тухай	Хууль зүйн туслалцаа авахтай холбоотой бусад мэдээллийг өгөх тухай	Өмгөөлөгч авахыг хүссэн бол мөрдөгч, прокурор, шүүгч өмгөөлөгчтэй холбож өгөх тодорхой арга хэмжээ авах тухай
Эрх зүйн зохицуулалт	ЭХХШТХ-ийн 31.6-р зүйлийн 1. Мөрдөгч баривчлагдсан сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэр танилцуулахаас өмнө, шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан бол баривчилсан даруй түүнд дараах зүйлийг танилцуулна: 1.2. хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох	ЭХХШТХ-ийн 7.5-р зүйлийн 1 дэх хэсэгт “Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар шүүх, прокурор, мөрдөгчөөс энэ хуульд заасны дагуу өгөхийг зөвшөөрсөн мэдээллийг авах эрхтэй”	ЭХХШТХ-ийн 31.3-р зүйлийн 3 дахь хэсэгт “Сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан яллагдагчийн эрхийг тайлбарлан өгч, тэр тухай тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна” гэж хуульчилжээ. ЭХХШТХ-ийн 7.6-р зүйлийн 3 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгч нь яллагдагч өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжоор хангана”
Асуудал		Энэ зохицуулалтын зорилго зөв боловч нарийвчилсан, тодорхой зохицуулалт бас байхгүй юм. Уг зохицуулалт хууль зүйн үр дагавар бүхий зохицуулалт болж чадаагүй буюу яаж хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах нь тодорхойгүй.	Уг эрхийг эдлүүлэх талаар ямар арга хэмжээ авах нь мөн л тодорхойгүй байна.

Өмгөөлөгч нь мэдүүлэг өгөхөд байлцах эрхтэй, сэжигтэн нь өмгөөлөгчөө байлцуулан мэдүүлэг өгөх эрхтэй боловч мөрдөгч, прокурорт уг эрхийг эдлүүлэх талаар арга хэмжээ авах үүрэг болгосон зохицуулалт байхгүй байна.

	I	II	III
	Хууль зүйн туслалцаа авахаас өмнө мэдүүлэг авахыг хориглох	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг баримтжуулах	Хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэхтэй холбоотой хууль зүйн хамгаалалт
Эрх зүйн зохицуулалт	5.1-р зүйл 2.1. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих	31.7-р зүйл 1. Мөрдөгч сэжигтнийг баривчлахдаа тэмдэглэл үйлдэж бэхжүүлнэ. Тэмдэглэлийг баривчлах ажиллагааны үед үйлдэх боломжгүй байсан бол тухайн ажиллагааг дууссанаас хойш даруй нөхөн үйлдэнэ.	16.11 дүгээр зүйл. Нотлох баримтаар тооцохгүй байх 1.2. энэ хуулийн 5.3 дугаар зүйлд заасныг (заавал өмгөөлөгч оролцуулах тохиолдол) зөрчсөн; 1.3. өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхийг зөрчиж мэдүүлэг авсан.
Асуудал	Өмгөөлөгчид уг ажиллагааны тухай хэрхэн мэдэгдэх, мэдүүлэг авахаар бол заавал өмгөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй эсэх зохицуулалт байхгүй байна.		

ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

3.1. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогч нь хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрхэн эдэлж байгаа талаар нэлээд өргөн хүрээтэй судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Судалгааны явцад судалгаанд хөндөгдөж буй асуудал нэлээд олон агуулгаар задарч судлах шаардлагатай нь ажиглагдав.

А. Нэр томъёо

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт заасан “хууль зүйн туслалцаа авах” гэдгийг өөрөө өмгөөлөгчөө сонгох эрх болон төрөөс хууль зүйн туслалцаа авах эрхийн аль алиныг багтаасан ойлголт уу, эсвэл зөвхөн төрөөс хууль зүйн туслалцаа авахыг хамааруулж авч үзэж байна уу? гэсэн асуулт гарч ирлээ. Шинэ ЭХХШтХ-ийн 1.14-р зүйлийн 1 дэх хэсэгт “өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх” гэж хуульчлан эдгээр ойлголтыг ялгасан мэт харагдах боловч тус хуулийн бусад заалтад ялгалгүй голчлон “хууль зүйн туслалцаа авах” гэсэн ойлголтыг хэрэглэжээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын заалтыг мөн авч үзвэл уг хоёр ойлголт агуулгын хувьд ялгаа байхгүй, ердийн тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийг өөрөө сонгон авна, өөрөө хөлслөх боломжгүй бол төрөөс зардлыг хариуцан өмгөөлөгч оролцуулна гэж ойлгогдож байна. Иймд “хууль зүйн туслалцаа авах” гэдэгт хувь өмгөөлөгчийг хөлслөн хууль зүйн туслалцаа авах, төрөөс өмгөөлөгч томилон оролцуулах аль аль нь хамаарна гэж үзлээ.

Б. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах эрх

Манай улсад уг эрхийн тухай ойлголт байхгүй. Хууль зүйн туслалцаа авах эрхийг өмгөөлөгчөө сонгон авах эрх болон төрөөс хууль зүйн туслалцаа авах эрхээр л ойлгож байх бөгөөд 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хүрээнд л манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалт хязгаарлагдаж байна. Гэтэл 1966 оноос хойш хагас зуун жил өнгөрсөн өнөө үед хууль зүйн туслалцаа авах эрх өөрийн агуулгаа өргөтгөн, улам бүр хүрээгээ тэлж байна.

Эрүүгийн процессын эрх зүйн түүх бол хууль зүйн туслалцаа авах эрхийн агуулгыг өргөтгөх түүх юм гэж хэлсэн нь үүнтэй холбоотой биз ээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд хууль зүйн туслалцаа авах тухай олон улсын баримт бичиг болон бусад улсын хууль тогтоомжид тусгагдах болж эндээс “эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрх” үүсэж бий болон хууль зүйн туслалцаа авах эрхийн нэг бүрдэл болжээ. Учир нь гэмт хэрэгт холбогдсон этгээдийн эрх зөрчигдөх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хамгийн эрсдэлтэй үе бол түүний эхэн үе шат гэж үздэг байна. Тухайлбал баривчлах, мэдүүлэг авах ажиллагаа үүнд хамаардаг.

В Эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой тулгамдаж буй асуудал

- Төлбөрийн чадваргүй гэдгийг тодорхойлох арга хэт явцуу учир бодит байдалд төлбөрийн чадваргүйгээсээ болоод хууль зүйн туслалцааг эрт авч чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй гэдгийг тодорхойлж буй журам, стандарт нь нийгмийн халамж олгох тогтолцоонд суурилсан байна. Энэ нь гэр бүлийн орлогод суурилдаг бөгөөд тухайн хувь хүний төлбөрийн чадамжийг тодорхойлоход ашиглах нь өрөөсгөл байж болох талтай.
- Томилогдсон өмгөөлөгч оролцуулах тогтолцоог бий болгосон боловч хэн нь, хэзээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд томилогдсон өмгөөлөгч оролцуулах тухай тодорхой

механизм байхгүй байна. Мөн хуулийн зохицуулалтын зорилго анхнаасаа хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулахад чиглэгдсэн механизм болов уу гэж таамаглаж байна.

- Баривчилсны дараа хийгдэх ажиллагааны хүрээнд “хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох (§31.6-1.2)”, сэжигтнээс мэдүүлэг авахдаа “өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах (§31.11-1.2)” гэсэн эрхүүдийг танилцуулж байх боловч энэ нь хангалтгүй байх бөгөөд хуульд заасан бусад хууль зүйн зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой боломжийг ялангуяа төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийн тухай тайлбарлах үүрэг хуульчлагдаагүй байна. Хэдийгээр хууль зүйн туслалцааг хувь хүн гэмт хэрэг сэжиглэгдэж эхэлсэн гэдгээ мэдсэн цагаас эхлэн авах эрхтэй бөгөөд үүнийг Монгол Улсын хууль тогтоомжоор хязгаарлаагүй байна. Гэхдээ эрх үүссэн ч гэмт хэрэгт холбогдсон хүн өөрөө хэрхэн яаж эдлэх, арга замаа ойлгож, хэрэгжүүлж чаддаггүй гэдгийг олон улсын зөвлөмж, баримт бичгүүдэд онцгойлон анхааруулж, Эрүүгийн процессын хуульд нарийвчилсан ажиллагаа хийх талаар зохицуулалтыг оруулж, эрүүгийн процессыг удирдан явуулж буй хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгч нь хууль зүйн туслалцаа авах эрхийг эрт шатнаас авах талаар тодорхой үүрэг хүлээж байх шаардлагатай талаар зөвлөсөн байдаг. Харин Монгол Улсын хувьд ихэнх хэрэг прокурор болон шүүхийн шатанд шилжсэний дараа өмгөөлөгч авч, хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлдэг. Энэ нь мөрдөн шалгах тогтолцоо бүхий эрүүгийн процесстой орны хувьд өмгөөлөгчийн хэлбэрийн төдий оролцоо буюу асуудал нэгэнт тодорхой болсны дараа оролцдог сөрөг практик тогтсоныг илтгэж байна. Хэдийгээр 2017 оны ЭХХШТХ-ийг боловсруулах үзэл баримтлалд хуучин тогтсон сөрөг практикийг халах зорилт тавьсан ч бодит байдалд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах чиглэлд өмнөх хуулийн агуулга, үзэл баримтлалаас тийм ч ахиц гараагүй байна гэж харж болохоор байна.
- Баривчлагдсан этгээд өөрийн гэсэн танил өмгөөлөгчгүй бол хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчтэй хэрхэн холбогдох,

хэн, хэзээ яаж холбож өгөх талаар тодорхой механизм, тодорхой субъектэд үүрэгжүүлсэн зохицуулалт байхгүй байна. Энэ нь эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрхийн тухай ойлголтгүй байгааг харуулж буй хамгийн гол үзүүлэлт бөгөөд ЭХХШТХ-ийн 35.6-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар шүүгч дөнгөж шүүх хуралдаан дээр шүүгдэгч, хууль зүйн туслалцаа авах эрх хангагдсан эсэхийг тодруулж буйгаас харагдана. Одоогийн практикт хууль зүйн туслалцаа авах эрхийг хэргийн оролцогчийн сайн дураар хэрэгжүүлэх эрх гэж харж байгаа хандлага нь буруу юм. Учир нь хэргийн оролцогчийн хувийн нөхцөл байдал, боловсрол зэрэг хүчин зүйлээс хамаарч үнэндээ өөрийгөө ямар эрхтэй, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх талаар нийгмийн дийлэнх хэсэгт тодорхой ойлголт, ухамсар бүрэн төлөвшөөгүй гэдгийг ойлгох шаардлагатай. Иймээс хэргийг мөрдөж буй мөрдөгч, прокурор нь хүний эрхийг дээдэлсэн хандлагаар хэргийн оролцогчийн эрхийг хангуулахад заавал анхаарч байх зайлшгүй шаардлагатай байна.

- Өмгөөлөгч нь мэдүүлэг өгөхөд байлцах эрхтэй, сэжигтэн нь өмгөөлөгчөө байлцуулан мэдүүлэг өгөх эрхтэй боловч мөрдөгч, прокурор нь өмгөөлөгчид уг ажиллагааны тухай хэрхэн мэдэгдэх, мэдүүлэг авахаар бол заавал өмгөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй эсэх зохицуулалт байхгүй байна.

3.2. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт
 - Эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгаж эхэлсэн үеэс эхлэн сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулах арга хэмжээ авч байх.
 - Хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулсан тохиолдолд тусгай баримтад гарын үсэг зуруулж, тухайн иргэний хууль зүйн туслалцаа авах хүсэлтэй байгаа эсэхийг тодорхой тусгах.
 - Хууль зүйн туслалцаа авах хүсэлтэй байгаа тохиолдолд нэн тэргүүнд эрхийг нь эдлүүлэх ажиллагааг хийх.

- Хууль зүйн туслалцаа авах хүсэлтэй байхад нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлдэг явдлыг таслан зогсоох.
- ЭХХШТХ-ийн томилогдсон өмгөөлөгчтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох, практикт хэрэгжүүлж эхлэх, томилогдсон өмгөөлөгч оролцож байгаа нөхцөлд төлбөрийг хэрхэн хуваарилах талаар тодорхой зохицуулах.
- Томилогдсон өмгөөлөгч оролцуулах эрхийг ямар субъект эдлэх, ямар өмгөөлөгчдөөс томилж байх зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулах. Прокурор, шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих үндсэн шалгуурт “хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлсэн эсэх, эдлүүлээгүй бол эрхийг эдлүүлэх чиглэлээр ямар ажиллагаа хийсэн гэдгийг хянаж” байх талаар хуульд нарийвчлан тусгах.

2. Бусад хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлт

- Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх хуулийн хэрэгжилт үр нөлөөг судалж зорилтот бүлгийг бүрэн хамруулж чадаж байгаа эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай. Учир нь энэхүү судалгааны үндсэн зорилт төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа авч чадаж байгаа эсэх асуудалд чиглээгүй тул зөвхөн мета-анализ хийж, өмнө хийгдсэн судалгааны баримтад тулгуурлан хөндөж үзэхэд зорилтот бүлэгт бүрэн хүрч чадахгүй байна гэсэн дүгнэлт гарч байх тул үүнийг нарийвчлан авч үзэх шаардлагатай байна.
- Хэргийн бусад оролцогч болох хохирогч, иргэний хариуцагч, нэхэмжлэгч зэрэг оролцогчид төлбөрийн чадваргүй нөхцөлд хууль зүйн үйлчилгээ авч чадахгүй бол хэрхэх талаар тодорхой зохицуулалт байхгүй, хязгаарлалтын гадна үлдэж байна. Хэрвээ энэ хэсгийг МХХ-ны дэргэдэх Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хороогоор дамжуулан шийдвэрлэх бол зохицуулалтыг илүү тодорхой болгох шаардлагатай.

- Төлбөрийн чадваргүй болохыг тогтоох шалгуур үзүүлэлтийн үндсэн аргачлалыг дахин анхаарах, учир нь өрх, гэр бүлийн нөхцөлд үнэлгээ хийж байгаа нь хувь этгээдийн төлбөрийн чадамжийг тодорхойлж чадах уу? гэдгийг дахин нягтлах шаардлагатай.
3. Мөрдөгч, прокурор, шүүгчид хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх, шинэ ЭХХШТХ-ийн үзэл баримтлалыг танилцуулах, хандлага тогтоох чиглэлээр анхаарах зүйл
- Хэдийгээр шинэ хууль батлагдан хэрэгжиж эхлээд байгаа ч хууль зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой эрхийн зохицуулалт өмнөх хуулийн зохицуулалттай дийлэнх хэсэг нь төстэй байгаагаас мөрдөгч, прокурор, шүүгчдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хандлага хэвээр үргэлжлээд байгаа нь ажиглагдсан. Иймд 2017 оны ЭХХШТХ-ийн үндсэн үзэл баримтлал мэтгэлцэх, талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхолд суурилсан тул нэн түрүүнд “хууль зүйн туслалцаа авах” эрхийг эдлүүлэх явдал гэдгийг ойлгуулах, нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна. Учир нь боловсон хүчний шинэчлэл огт хийгдэхгүй байгаа нь хуучин тогтолцоо, практик хэвээр үргэлжлэх суурь шалтгаан болж байна.
4. Бусад байгууллагад чиглэсэн арга хэмжээ
- Хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад өмгөөлөгчийг сонгох асуудал байгаа ч өнөөгийн нөхцөлд тухайн орон нутагт ямар өмгөөлөгч үйл ажиллагаа явуулж байгаа, тухайн өмгөөлөгч нь практикт хэрхэн мэргэшин ажилладаг талаарх мэдээлэл хэргийн оролцогч, мөрдөгч, прокуроруудад огт очихгүй байгаагийн зэрэгцээ мэдээллээр хангах чиглэлд бодитой ажил зохион байгуулагдахгүй байна. Ерөнхийдөө ХЭЗБТХ-иар МХХ нь өмгөөлөгчдийн талаарх лавлагаа, мэдээллийг гаргах үүрэгтэй тул одоогийн цахим мэдээлэлд суурилан хэргийн оролцогчийн байрлаж буй газарт ажиллаж буй өмгөөлөгч, тэдний ямар салбараар мэргэшин өмгөөлөл үзүүлдэг талаар тодорхой харах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

- Өмгөөлөгчдийн лавлагаа илүү нарийвчлагдсан тохиолдолд мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлүүлэх ажиллагаанд ашиглаж хэвших шаардлагатай.

5. Тодорхой санал

№	Одоо хэрэгжиж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт	Эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрхийн үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулбал:	Тайлбар
	§1.14-1. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.	§1.14-1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хүн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.	Гэмт хэрэгт сэжиглэгдэж буйгаа мэдсэн үеэс хууль зүйн туслалцаа авах эрх хэрэгжүүлэхийг шаардах үндэслэл болно.
1	§5.2 дугаар зүйл. Өмгөөлөгчийг сонгох	*Нэмэлт. §5.2 дугаар зүйл. Өмгөөлөгчийг сонгох 8. Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангахад үндэслэх төлбөрийн чадварын доод хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн тогтооно. 9. Төлбөрийн чадваргүйг тодорхойлох хөрөнгө нь мөнгөн хөрөнгө болох цалин түүнтэй адилтгах орлого, мөнгөн хадгаламж түүнтэй адилтгах бусад мөнгөн хөрөнгөд хурдан хугацаанд шилжих шаардах эрх байна.	Зах зээл дээрх бодит хөлстэй уялдуулан хурдан хугацаанд өмгөөлөгчийн зах зээл дээр тогтсон доод хөлсийг төлөхөд хүрэлцэхгүй хэмжээнд төлбөрийн чадварын шугамыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Төлбөрийн чадвартай эсэхийг тодорхойлохдоо бэлэн мөнгө, цалин хөлс, хадгаламж гэх мэт хурдан хугацаанд санхүүгийн эргэлтэд оруулах боломжтой хөрөнгөөр тодорхойлох хэрэгтэй.

үргэлжлэл ►

<p>2 §5.2 дугаар зүйл. Өмгөөлөгчийг сонгох 6. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч тогтоосон хугацаанд өмгөөлөгч сонгож аваагүй бол тухайн ажиллагаанд томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна.</p>	<p>§5.2 дугаар зүйл. Өмгөөлөгчийг сонгох 6. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч сэжигтнийг баривчилсан, яллагдагчаар татах тогтоолтой танилцуулах үед сонгон авсан өмгөөлөгчөө оролцуулах, төлбөрийн чадваргүй бол улсаас өмгөөлөгч томилуулах боломжтой тухай тайлбарлах бөгөөд өмгөөлөгч сонгон авах, улсаас өмгөөлөгч оролцуулах хүртэл тухайн ажиллагаанд томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна.</p>	<p>Өмгөөлөгч сонгон авах, улсын өмгөөлөгчийг оролцуулах хүртэл тухайн ажиллагаанд томилогдсон өмгөөлөгчийг (Embedded schemes) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь эрт үеэс хууль зүйн туслалцаа авах орчныг баттай бүрдүүлэх үндэс болно. Хуульчдын холбооноос хүртэл “Call-in and duty lawyer schemes” эсвэл “Visiting schemes” тогтоолцоог бий болгож нийгэмдээ үйлчлэх шаардлагатай юм.</p>
<p>4 §7.6-3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгч нь яллагдагч өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжоор хангана.</p>	<p>§7.6-3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгч нь яллагдагч өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэхийг хүссэн этгээдийн хүсэлтийг нэн даруй Хуульчдын холбоонд мэдэгдэн өмгөөлөх хүсэлтэй байгаа өмгөөлөгч байгаа эсхийг тодруулна. Өмгөөлөх өмгөөлөгч олдохгүй бол томилогдсон өмгөөлөгчийг нэн даруй оролцуулна. Өмгөөлөгч оролцуулахаас өмнө мэдүүлэг, байцаалт авахыг хориглоно.</p>	<p>Япон Улсын Эрүүгийн процесс хуулийн 203, 204, 207-р зүйлээс санаа авч болно. Мөн Япон Улсын Өмгөөлөгчдийн холбооноос бий болгосон жижүүрийн өмгөөлөгчийн тогтолцоо нь уг эрхийг бодитоор эдлүүлэхэд мэргэжлийн хуульчдын холбооны чиг үүрэг ямар чухал болох сайн туршлага юм. Мөн ХБНГУ-ын Эрүүгийн процесс хуулийн 137, 140, 141-р зүйлээс үүнийг харж болно. Цаашид ЭХХШТХ-д томилогдсон өмгөөлөгчтэй холбоотой шинэ бүлэг бий болгох шаардлагатай.</p>

үргэлжлэл ►

5	§12.2-3. Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагч, шүүгдэгч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас зайлсхийсэн бол түүний өмгөөлөгч, эсхүл гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүнд хүргүүлнэ.	§12.2-3. Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагч, шүүгдэгч мэдэгдэх хуудсыг түүний өмгөөлөгч, эсхүл гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүнд хүргүүлнэ.	Мэдүүлэг авах тухай өмгөөлөгчид мэдэгдэх нь өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хамгийн чухал алхам болно.
6	12.3 дугаар зүйл. Албадан ирүүлэх	*Нэмэлт. §12.3-8. Яллагдагч, шүүгдэгчийг прокурор, шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэхдээ өмгөөлөгчид заавал мэдэгдэнэ.	Мөн дээрхтэй адил.
7	31.6 дугаар зүйл. Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа 1.2. хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох	31.6 дугаар зүйл. Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа 1.2. Хууль зүйн туслалцаа авах эрхтэй. Хэрвээ өмгөөлөгч авах боломжгүй бол өмгөөлөгч томилж өгнө.	АНУ-ын Мирандагийн сануулгаас, мөн Япон Улсын Эрүүгийн процесс хуулийн 203, 204, 207-р зүйлээс харагдана. Мөн ХБНГУ-ын Эрүүгийн процесс хуулийн 137, 140, 141-р зүйлээс үүнийг харж болно
8	31.11 дүгээр зүйл. Сэжигтнээс мэдүүлэг авах 1. Мөрдөгч баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараах эрхийг тайлбарлана: 1.2. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах	31.11 дүгээр зүйл. Сэжигтнээс мэдүүлэг авах 1. Мөрдөгч баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараах эрхийг тайлбарлана: 1.2. өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах, хэрвээ өмгөөлөгч авах боломжгүй бол өмгөөлөгч улсаас томилж өгнө.	Мөн дээрхтэй адил.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, тогтоомж

1. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 он
2. Өмгөөллийн тухай хууль, 2002 он
3. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012 он
4. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, 2013 он
5. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

Өгүүлэл, судалгааны тайлан, ном

6. Ханнс Зайделийн сан “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинжлэх ухааны тайлбар” УБ, 2003 он
7. ННФ “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох нь” Үндэсний бага хурал хурлын эмхэтгэл, УБ, 2003 он
8. ХЗҮТ “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар” УБ, 2003 он
9. Б.Бат-Эрдэнэ “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” УБ, 2004 он
10. ННФ “Хууль зүйн туслалцаа хэрхэн авах вэ?” УБ, 2006 он
11. Б.Амарбаясгалан нар “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” УБ, 2007 он
12. Ц.Бүжинлхам “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” УБ, 2007 он
13. Ж.Бямбаа “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд” УБ, 2008 он
14. Ханнс-Зайделийн сан “Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль. Хялбаршуулсан тайлбар” УБ, 2010 он
15. У.Эрдэнэтуяа “Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа ба хүний эрх” Хүний эрх сэтгүүл, УБ, 2016/02
16. Хууль зүйн туслалцааны төв “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмж” судалгааны тайлан, УБ, 2016 он
17. Шударгаар шүүлгэх эрх гарын авлага (2 дахь хэвлэл) Эмнести Интернэшнл
18. НФФ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх шүүмж”, УБ, 2017 он

19. ХЗҮХ “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”, УБ, 2017 он

Гадаад хэл дээрх эх сурвалж

20. United Nations Principles and Guidelines on Access to Legal Aid in Criminal Justice Systems
21. United Nations Office on Drugs and Crime (2014), Early access to legal aid in criminal justice processes: a handbook for policymakers and practitioners
22. United Nations Office on Drugs and Crime (2017) Model Law on Legal Aid in Criminal Justice Systems with Commentaries
23. Criminal Procedure by Samaha, Joel 8th (eighth) Edition
24. Mark S. Brodin and Robert M. Bloom. Criminal Procedure: The Constitution and the Police (Seventh Edition). 7th New York, NY (2012)
25. Open Society Foundations “Legal aid in Europe: minimum requirements under international law” 2015
26. The council of the European Union “Roadmap for strengthening procedural rights of suspected or accused persons in criminal proceedings” (2009/C 295/01)/[http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32009G1204\(01\)&from=EN/](http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32009G1204(01)&from=EN/)
27. EU of the European Parliament and of the Council “the right to interpretation and translation in criminal proceedings” DIRECTIVE 2010/64/ [/http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32010L0064&from=EN/](http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32010L0064&from=EN/)
28. EU of the European Parliament and of the Council “the right to information in criminal proceedings” DIRECTIVE 2012/13/ [/http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32012L0013&from=EN/](http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32012L0013&from=EN/)
29. EU of the European Parliament and of the Council “the right of access to a lawyer in criminal proceedings and in European arrest warrant proceedings, and on the right to have a third party informed upon deprivation of liberty and to communicate with third persons and with consular authorities while deprived of liberty” DIRECTIVE 2013/48/ [/http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32013L0048&from=EN/](http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32013L0048&from=EN/)
30. EU of the European Parliament and of the Council “the strengthening of certain aspects of the presumption of innocence and of the right to be present at the trial in criminal proceedings” DIRECTIVE 2016/343 [/http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32016L0343&from=en/](http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32016L0343&from=en/)
31. EU of the European Parliament and of the Council “procedural safeguards for children who are suspects or accused persons in

criminal proceeding” DIRECTIVE 2016/800 /<http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32016L0800&from=en>

32. EU of the european parliament and of the council “legal aid for suspects and accused persons in criminal proceedings and for requested persons in European arrest warrant proceedings” DIRECTIVE 2016/1919 <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32016L1919&from=EN>
33. THE GERMAN CODE OF CRIMINAL PROCEDURE stop
34. 刑事訴訟法
35. 総合法律支援法

ХАВСРАЛТ-1

ЭХХША-д ӨМГӨӨЛӨГЧ, ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧДИЙН ОРОЛЦОО

НҮБ-ын дэргэдэх хар тамхи, гэмт хэргийн асуудал хариуцсан хэлтсээс гаргасан “Хууль зүйн туслалцааг эрт шатанд авах асуудал дээр оролцогч хуульч, өмгөөлөгч, цагдаа, прокурор, шүүгч”-ийн үүрэг, оролцоо, хариуцлагын талаарх зөвлөмж

Хууль зүйн туслалцааг эрт шатанд авах асуудал дээр оролцогч талууд буюу хуульч, өмгөөлөгч, цагдаа, прокурор, шүүгч зэрэг субъектийн үүрэг оролцоо, хариуцлага ямар байх ёстой, тэдгээрийн эрх үүрэг, оролцоог үндэсний хууль тогтоомж, процесс ажиллагаанд хэрхэн тодорхойлж өгвөл үр дүнтэй, хууль зүйн туслалцааг эрт шатанд эдлэх, тус эрхийг хэрэгжүүлэх, хангах тал дээр үндэсний хууль тогтоомж ямар хэм хэмжээ, чиг хандлагаар зохицуулагдсан байх ёстой, ямар стратегийн дагуу тус эрхийг хамгаалах ёстой талаар “зөвлөмж” өгсөн олон улсын стандарт (цаашид “зөвлөмж” гэх)-ыг⁶¹ НҮБ-ын дэргэдэх хар тамхи, гэмт хэргийн асуудал хариуцсан хэлтсээс гаргасан байдаг.

НҮБ-аас гаргасан дээрх зөвлөмжид эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, баталгаажуулах асуудал дээр хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудын үүрэг оролцоо, хариуцлагыг өндрөөр тогтоожээ. Өөрөөр хэлбэл, (1)“Өмгөөлөгч”, (2)“Цагдаагийн байгууллагын ажилтан-мөрдөгч”, (3)“Прокурор”, (4)“Шүүгч” гэсэн субъектүүдийн үүрэг оролцоо, хариуцлагаар дамжуулан сэжигтэн, яллагдагч зэрэг хэргийн оролцогчийн аль болох эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, баталгаажуулах стандартыг тогтоож өгсөн. Доорх хэсгүүдэд 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд

⁶¹ United Nations Office on Drugs and Crime “Early access to legal aid in criminal justice processes: a handbook for policymakers and practitioners” Criminal justice handbook series, United Nations, New York, 2014 http://www.unodc.org/documents/justice-and-prison-reform/ebook-early_access_to_legal_aid.pdf

зөвлөмжөөр тавьж буй шаардлага, хэм хэмжээ, аргачлал буюу олон улсын хүний эрхийг хангах стандарт туссан эсэх, хэрэв туссан бол ямар утга агуулга, хэлбэрээр хуульчлагдсан эсэх, тэдгээр нь хэрэгжих боломжтой эсэх, цаашид ямар асуудал дээр анхаарах ёстой талаар авч үзье.

1.1. Өмгөөлөгчийн үүрэг оролцоо, хариуцлага

Өмгөөлөгчөөс эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх, хангах асуудал дээр гүйцэтгэх үндсэн үүрэг бол тус эрхийг хамгаалах, тус эрхийг идэвхтэй ашиглах явдал юм. Өөрөөр хэлбэл, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн кодекс, дүрэм, журам, эрт шатанд хууль зүйн туслалцаа авах асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелүүлэх, тэдгээрийн дагуу ажиллах, бусад этгээдийг ажиллахыг шаардах нь хууль зүйн туслалцаа үзүүлж буй өмгөөлөгчийн үндсэн үүрэг, оролцоо юм. Үүний тулд, өмгөөлөгч нь дараах үүрэг, хариуцлагыг ухамсарлаж ажиллах хэрэгтэй ба тэдгээр нь үндэсний хууль тогтоомжоор баталгаажсан байх ёстой.

1. Хууль зүйн туслалцаа авахыг хүссэн хүсэлтэд маш шуурхай, зохистой, хангалттай байдлаар хариу үзүүлэх.
2. Цагдаа болон өөрийн үйлчлүүлэгч, бусад холбогдох эх сурвалжаас хэрэгт хамааралтай мэдээлэл цуглуулах.
3. Үйлчлүүлэгчийнхээ тусгай хэрэгцээ, шаардлага, аливаа эмзэг байдлыг тодорхойлох. Ингэхдээ үйлчлүүлэгч нь насанд хүрээгүй хүүхэд эсэх, процесс ажиллагаанд ашиглагдаж буй хэлийг ойлгож байгаа эсэх, тус хэлээр ярьж чадах эсэх, хэрэгт хамааралтай баримт, материал, нотлох баримтыг уншиж, ойлгож чадах эсэх, үйлчлүүлэгчид өөр ямар нэгэн эмзэг байдал байгаа эсэхийг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээг авах.
4. Цагдаа болон холбогдох бусад эрх бүхий этгээдээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хууль ёсны дагуу явагдсан эсэхийг шалгах, ямарваа нэгэн зөрчил илэрсэн бол зөрчлийг хэрхэн арилгах талаар шаардлагатай арга хэмжээг авах.

5. Байцаалт, мэдүүлгийн өмнө, дараа нь, эсвэл тухайн ажиллагаа үргэлжлэх үед үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх.
6. Цагдаагийн байгууллагын ажилтан, бусад эрх бүхий албан тушаалтантай харилцах асуудал дээр үйлчлүүлэгчийг төлөөлөх, түүний эрх ашгийг цагдаа, бусад этгээдүүдийн өмнө хамгаалах.
7. Үйлчлүүлэгчийн хүсэлт, зөвшөөрлийн дагуу түүнийг гэр бүл болон бусад гуравдагч этгээдтэй холбож өгөх, уулзуулах ажлыг зохион байгуулах.
8. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон бусад хэлэлцүүлгийн үед үйлчлүүлэгчийг төлөөлөх.
9. Холбогдох бүх мэдээ, мэдээллийг бүртгэх.

2017 оны ЭХХШТХ-ийн Тавдугаар бүлэгт өмгөөлөгчид хамаарах эрх үүрэг, үйл ажиллагаа, баталгаа, хариуцлагын талаарх зохицуулалтууд тусгагджээ. ЭХХШТХ-ийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулах тухай үндсэн ойлголт хуульчлагдсан. ЭХХШТХ-ийн 5.1 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсгүүдэд өмгөөлөгчийн эрх, үүргийн талаар тусгасан байдаг.

ЭХХШТХ-ийн 5.1 дүгээр зүйлд “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих”, “хохирогч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авхуулахаар хүсэлт гаргах”, “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шинжээчийн дүгнэлттэй танилцах, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах”, “хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурорт гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох”, “өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө

хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах”, “өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах тухай хүсэлт гаргах”, “өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, тодорхойлолт гаргуулж авах”, “мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах”, “сэжигтнийг баривчлах, ялладагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох”, “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж оролцогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх санал гаргах” гэх зэргээр хууль зүйн туслалцаа үзүүлэгч буюу өмгөөлөгчийн эдлэх эрхийг эрүүгийн процессын хуульд тусгаж өгсөн нь НҮБ-ын зөвлөмжид тодорхой хэмжээгээр нийцсэн гэж үзэж болохоор байна. Мөн 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41 дүгээр зүйлд шинэ хуулийн өмгөөлөгчийн эдлэх эрхтэй бараг ижил байдлаар өмгөөлөгчийн эрх хуульд баталгаажсан байдаг гэдгийг дурдах хэрэгтэй.

Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нарын хууль зүйн туслалцаа эрт шатанд хангалттай сайн авч чадахгүй байгаа асуудлын суурь шалтгаан нь материаллаг болон процессын хууль тогтоомжид заасан зохицуулалт тодорхой түвшинд байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэх арга механизм тодорхойгүй, хуулийн хэм хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан дүрэм, журам, процесс хангалтгүй байдагтай холбоотой гэж үзэж байна. Угтаа бол дээр дурдсаны дагуу хууль зүйн туслалцаа авч буй үйлчлүүлэгч өөрийн эрхийн талаар ойлгож, мэдэж байгаа эсэхийг баталгаажуулах, үйлчлүүлэгчийн үндсэн эрх, эрх чөлөө, хууль тогтоомжоор баталгаажсан эрх, түүний нэр төр хуулийн дагуу хамгаалагдсан эсэх, зөрчигдсөн эсэх дээр хяналт тавьж ажиллах, үйлчлүүлэгчид шаардлагатай, зохистой хууль зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, үйлчлүүлэгчийг төлөөлөх, ялангуяа үйлчлүүлэгчийн эмзэг байдал, тусгай хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулах буюу үйлчлүүлэгчийн хууль

ёсны эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн эрхийг хэрэгжүүлэх, хангах тал дээр шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой ба ялангуяа, үйлчлүүлэгчдийн нас, хүйс, үндэс угсаа, сэтгэцийн болон бие махбодын нөхцөл, бэлгийн чиг хандлага зэрэг шалтгаан, нөхцөлийг харгалзан үзэх, үйлчлүүлэгчийн эрхээ хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авхуулах талаар гаргасан шийдвэр нь хэрэгжсэн эсэхийг хянаж байх, үйлчлүүлэгчийн эсрэг хийгдсэн хууль бус, шударга бус арга хэмжээ, ажиллагаатай зохистой байдлаар хуульд заасны дагуу тэмцэх, асуудлыг гаргаж тавих, үйлчлүүлэгч өөрийн холбогдсон хэрэг эцсийн байдлаар шийдэгдэж дуусах хүртэл хууль зүйн туслалцаа авах, хууль зүйн зөвлөгөө авах, хуулийн төлөөлөл авч чадаж байгаа эсэхийг хянаж, анхаарал хандуулах, баталгаажуулах талаарх үндсэн эрх хэмжээ, үүрэг хариуцлага материаллаг хууль тогтоомжид байгаа боловч эдгээрийг хэрэгжүүлэх механизм, процесс тодорхойгүй байна.

Нөгөө талаас, хууль зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг гүйцэтгэх, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, эрхийг эдлүүлэх тал дээр хууль сахиулах байгууллагын ажилтан буюу цагдаа, мөрдөгч, прокурор, шүүгчийн оролцоо, туслалцаа, хамтын ажиллагаа маш чухал нөлөөтэй гэдгийг НҮБ-ын зөвлөмжид дурдагдсан боловч манай орны эрх зүйн тогтолцоо нь үүний эсрэг буюу өмгөөлөх болон яллах талуудын хамтын ажиллагаа гэсэн ойлголт туйлын дутмаг байдаг.

1.2. Цагдаа, прокурор болон шүүгч нарын үүрэг оролцоо, хариуцлага

НҮБ-ын зөвлөмжид дурдсанаар хууль зүйн туслалцааг аль болох эрт шатанд авах эрхийг хангах, хэрэгжүүлэхэд дан ганц нэг субъектийн, цагдаагийн байгууллагын үүрэг гүйцэтгэж буй нэг мөрдөгчийн оролцоо хангалтгүй, үр дүнгүй байдаг. Энд хууль сахиулж буй байгууллага бүтцээрээ, тогтолцоогоороо нэгдсэн нэг ойлголт, хандлагыг бий болгож байж сэжигтэн, яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг эрт шатанд хангах боломжтой болно.

Эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрх бүрэн хэрэгжих үндэс нь сэжигтэн, яллагдагчидтай шууд харилцаж буй хэрэг хариуцсан цагдаагийн байгууллагын ажилтныг маш тодорхой заавраар хангах явдал юм. Өөрөөр хэлбэл, эрхийг эдлүүлэх процессыг хэрхэн явуулах нь маш тодорхой байх ёстой ба тухайн процесс, арга механизм нь эрхийг хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байхаар тогтоогдсон байх хэрэгтэй. Сэжигтэн, яллагдагчид түүний хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрхийг нь эдлүүлэхийн тулд дараах асуудлууд тодорхой, нэгдсэн байдлаар хуульчлагдсан, журамлагдсан байх ёстой. Үүнд:

1. Сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрхийг нь сануулах, мэдэгдэх талаар тодорхой, нэгдсэн стандарттай аргачлал өөрөөр хэлбэл, нарийн хэллэг, үг, өгүүлбэрийг бий болгох;
2. Сэжигтэн, яллагдагчид эрхийг нь хэрхэн, яаж сануулах, мэдэгдэх талаар маш тодорхой процедуртай байх ёстой ба эрхийг нь сануулж, мэдэгдсэний дараагаар эрхээ хэрхэн эдлэх буюу өөрийгөө өмгөөлөх, эсвэл өмгөөлөгч сонгох зэрэг сэжигтэн, яллагдагч яг ямар шийдвэр гаргасан тухай тэмдэглэл үйлдэж байх;
3. Хууль зүйн туслалцаа үзүүлэх этгээд, өмгөөлөгчтэй холбоо тогтоох, холбогдох процессыг бий болгох. Тус процесс нь тодорхой, ойлгомжтой, хамгийн чухал үзүүлэлт нь хэрэгжих боломжтой байх;
4. Хууль зүйн туслалцаа, хууль зүйн зөвлөгөө авч амжаагүй, аваагүй байх үед сэжигтэнтэй ярилцах, тайлбар, мэдүүлэг авах гэх мэт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэмжээ хязгаар, аль хүртэл ямар хэмжээний мөрдөн шалгах арга хэмжээ авч болох талаар зохицуулсан дүрэм, журамтай байх хэрэгтэй;
5. Хууль сахиулах, мөрдөн шалгах байгууллагын хяналт, сайн дурын санаачилга өөрөөр хэлбэл, хууль сахиулах цагдаагийн байгууллагын зүгээс сэжигтэн, яллагдагчийн эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх, хүндлэх талаар мөрдөн шалгах чиг үүрэг бүхий ажилтан,

албан хаагчдадаа сануулдаг, тэдгээрийг урамшуулж, сайшаадаг эсэхийг баталгаажуулах нь зүйтэй;

6. Хууль зүйн туслалцааг эрт шатанд хэрэгжүүлэх тал дээр аливаа асуудал, алдаа дутагдал гарвал түүний шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, зохистой хариу арга хэмжээ, засан сайжруулах ажлыг зохион байгуулах арга механизмтай болох мөн түүнийг хянадаг, мониторинг хийдэг болох.

Зөвлөмжид тусгагдсан дээрх 6 стандартын шаардлага 2017 оны ЭХХШТХ-д хэрхэн хуульчлагдсан талаар авч үзвэл дараах дүгнэлтүүдийг хийх боломжтой.

Нэг. 2017 оны ЭХХШТХ болон 2002 оны ЭВШТХ-ийн аль алинд нь тодруулбал, 2017 оны хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулна”, 31.6 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт мөрдөгч баривчлагдсан сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэр танилцуулахаас өмнө, шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан бол баривчилсан даруй түүнд “хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох”-ыг танилцуулна, 31.3 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан яллагдагчийн эрхийг тайлбарлан өгч, тэр тухай тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна” гэж, 2002 оны хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт “Сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна” гэж зөвлөмжийн үндсэн шаардлагыг хангах хэмжээний хуулийн зохицуулалт хийгдэж байсан болон хийгдсэн байгаа юм.

Гэвч мөрдөгч, прокурор зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын дунд явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд тэр бүр эрх сануулах ажиллагаа хийгддэггүй, хийгдсэн байлаа гэхэд яг ямар аргачлал, хэлбэр, агуулгаар хийгддэг эсэх нь тодорхойгүй буюу ямар баримт бичиг үйлддэг эсэх, ямар тэмдэглэлд эрх

сануулсан талаар дурдаж гарын үсэн зуруулдаг эсэх нь тодорхойгүй байдалтай байна. Өөрөөр хэлбэл, сэжигтэн, яллагдагчид тэдгээрийн хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхийг нь сануулах, мэдэгдэх талаар тодорхой, нэгдсэн стандарттай аргачлал, нарийн хэллэг, үг, өгүүлбэр тогтоогүй байна.

Хоёр. Зөвлөмжийн дагуу сэжигтэн, яллагдагчид эрхийг нь хэрхэн, яаж сануулах, мэдэгдэх талаар маш тодорхой процедуртай байх ёстой ба эрхийг нь сануулж, мэдэгдсэний дараагаар эрхээ хэрхэн эдлэх буюу өөрийгөө өмгөөлөх, эсвэл өмгөөлөгч сонгох зэрэг сэжигтэн, яллагдагч яг ямар шийдвэр гаргасан тухай тэмдэглэл үйлдэж байх ёстой. Одоогийн мөрдөж буй 2017 оны ЭХХШТХ-ийн 31.7 дугаар зүйлийг харвал, мөрдөгч сэжигтнийг баривчлахдаа тэмдэглэл үйлдэж бэхжүүлэх ба тус тэмдэглэлд баривчлах ажиллагааны үйл явцаас гадна “баривчилсан мөрдөгчийн овог, нэр, албан тушаал”, “баривчлах ажиллагаа эхэлсэн огноо, газар”, “баривчлагдаж байгаа сэжигтэнд эрхийг нь танилцуулсан цаг, минут”, “баривчлах газарт хүргэсэн цаг, минут”, “баривчлагдсан сэжигтний гаргасан санал хүсэлт, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн”, “хуулийн 31.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу сэжигтнийг баривчилсныг хаана, хэнд мэдэгдсэн тухай болон мэдэгдсэн цаг, минут”-ын талаар тусгахыг хуульчилсан ба мөн “баривчлагдаж байгаа сэжигтэнд эрхийг нь танилцуулсан цаг, минутыг тэмдэглэж, гарын үсэг зуруулах, гарын үсэг зурах боломжгүй, эсхүл гарын үсэг зураагүй бол энэ тухай тэмдэглэлд тусгана” гэж, мөн хуулийн 31.8 дугаар зүйлд баривчлагдсан сэжигтэн эрхийн талаар “баривчилсан үндэслэлтэй танилцах”, “шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас бусад тохиолдолд баривчлах тухай шүүхийн зөвшөөрөлтэй хуульд заасан хугацаанд танилцах, хуулбарыг авах”, “өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, өмгөөлөгч, гэр бүлийн гишүүнтэй холбогдох боломжоор хангагдах”, “баривчлах шийдвэр, ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах”, “өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх”, “эмнэлгийн тусламж авах”, “хууль бусаар баривчилсны улмаас учирсан хохирлоо арилгуулахаар гомдол гаргах”, “хууль зөрчсөн эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, прокурорын үйл ажиллагаанд гомдол гаргах”, мөн “баривчлагдсан сэжигтэн түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах

тогтоолтой танилцаж, хуулбарлаж авах, баривчилсан үндэслэлийн талаар мөрдөгчөөр тайлбарлуулах эрхтэй” гэж, мөн хуулийн 31.11 дүгээр зүйлд мөрдөгч баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулсны үндсэн дээр “өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх”, “өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах”, “өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, өмгөөлөгч байлцуулан мэдүүлэг өгөх”, “эх хэлээрээ, эсхүл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх”, “орчуулагч, хэлмэрчийн туслалцааг авах”, “мэдүүлэг өгөхөөс татгалзах”, “мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрчээс татгалзах”, “хуулийн Долдугаар бүлэгт заасан бусад эрх”-тэй талаар тайлбарлах гэж нарийн процесс ажиллагаа, эрх үүргийн талаар тодорхой хэмжээнд дэлгэрүүлэн хуульчилж өгсөн нь 2002 оны ЭБШТХ-ийн 59 дүгээр зүйлд заагдсан байсан “Сэжигтнийг баривчлах журам”-д холбогдох зохицуулалтаас илүү дэвшилттэй буюу НҮБ-ын зөвлөмжид нийцсэн байдлаар хуульчлагдсан гэж үзэж болохоор байна.

Хэдийгээр хууль тогтоомжид холбогдох журам, процесс, эрх үүргийн зохицуулалтууд олон улсын хүний эрхийн хэм хэмжээний шаардлагын дагуу хуульчлагдсан гэж үзэх үндэстэй боловч мөрдөгч, прокурор нарын дунд явуулсан судалгааны үр дүнгээс харахад дээрх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлдэггүй байдал харагдаж байна. Түүний шалтгаан нь шинэ тутам хэрэгжиж буй хууль учир практик орчинд хараахан хэвшээгүй гэж дүгнэх боломжтой боловч нөгөө талаас 2002 оны ЭБШТХ-д энэ талаарх зохицуулалт тодорхой хэмжээнд байсан гэж үзэж болно.

Гурав. Зөвлөмжийн дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх этгээд, өмгөөлөгчтэй холбоо тогтоох, холбогдох процессыг бий болгох, тус процесс нь тодорхой, ойлгомжтой, хамгийн чухал үзүүлэлт нь хэрэгжих боломжтой байх шаардлага тавигддаг. 2017 оны ЭХХШТХ-ийн 31.6 дугаар зүйлийн 5 дах хэсэгт “Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ”, мөн хуулийн 31.8 дугаар зүйлийн 1.3 дах хэсэгт “өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх,

өмгөөлөгч, гэр бүлийн гишүүнтэй холбогдох боломжоор хангагдах” гэж тусгагдсан байна.

Гэвч 2017 оны ЭХХШтХ-ийн 31.11 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт “Сэжигтний сонгон авсан өмгөөлөгч 2 цагийн дотор хүрэлцэн ирээгүй, эсхүл өмгөөлөгч авахаас татгалзсан бол энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч оролцуулна” гэж заасан байгаа нь сэжигтэн, яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг зарим талаар хязгаарласан шинжтэй зохицуулалтууд буюу зөвлөмжийн дагуу тухайн мэдэгдэх ажиллагаа хэрэгжих боломжтой байх нь хамгийн чухал үзүүлэлт боловч дээрх зохицуулалтаас харахад 2 цагийн хязгаар тавьж байгаа нь зөвлөмжтэй зөрчилдөх байдлыг үүсгэж байна. Харин 2002 оны ЭБШтХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг баривчилсан болон хаана байгааг 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садны хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг баривчлагдсан этгээдэд олгоно” хэмээн зохицуулсан байсан нь сэжигтэн, яллагдагчийн хүссэн өмгөөлөгчөө авах эрхийг хязгаарлаагүй гэдэг талаасаа шинэ хуулийн зохицуулалтаас илүүтэйгээр хууль зүйн туслалцаа авах эрхийг хангахад чиглэсэн байгаа боловч нөгөө талаар 24 цаг хэмээн мэдэгдэх хугацаа урт байгаа нь сэжигтэн, яллагдагчид ашиггүй хувилбар байсан гэж үзэж болно.

Дөрөв. Зөвлөмжийн дагуу хууль зүйн туслалцаа, хууль зүйн зөвлөгөө авч амжаагүй, аваагүй байх үед сэжигтэнтэй ярилцах, тайлбар, мэдүүлэг авах гэх мэт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэмжээ хязгаар, лимит, аль хүртэл ямар хэмжээний мөрдөн шалгах арга хэмжээ авч болох талаар зохицуулсан дүрэм, журамтай байх хэрэгтэй талаар дурдсан байдаг. 2017 оны ЭХХШтХ болон 2002 оны ЭБШтХ-ийн аль алинд өмгөөлөгч байлцуулан мэдүүлэг өгөх буюу хууль зүй туслалцаа үзүүлэх этгээдтэй холбогдсоны үндсэн дээр мэдүүлэг өгөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх, эсвэл мэдүүлэг өгөхөөс татгалзах зэрэг эрхийг зохицуулж өгсөн байдаг. Нарийвчилж зохицуулсан дүрэм, журам байхгүй. Гэхдээ эрүүгийн процессын хуулиудад тусгагдсан хууль зүйн туслалцаа, хууль зүйн зөвлөгөө авч амжаагүй, аваагүй байх үед сэжигтэнтэй ярилцах, тайлбар, мэдүүлэг авах гэх мэт мөрдөн

шалгах ажиллагаа явуулах хэмжээ хязгаар, лимит, аль хүртэл ямар хэмжээний мөрдөн шалгах арга хэмжээ авч болох талаар эдлэх сэжигтэн, яллагдагчийн эрхийн зохицуулалтууд боломжийн төвшинд хуульчлагдсан байдаг боловч хэрэгт холбогдогч этгээдүүд энэ талаарх эрхээ эдэлдэггүй, энэ талаарх мэдлэг мэдээлэл бага, мэргэжлийн өмгөөлөгчийн туслалцаа анхнаасаа авдаггүй зэрэг шалтгааны улмаас дээрх агуулгын зохицуулалт хэрэгждэггүй байж болох талтай.

Тав. Зөвлөмжид хууль сахиулах, мөрдөн шалгах байгууллагын хяналт, сайн дурын санаачилга, өөрөөр хэлбэл хууль сахиулах цагдаагийн байгууллагын зүгээс сэжигтэн, яллагдагчийн эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэх, хүндлэх талаар мөрдөн шалгах чиг үүрэг бүхий ажилтан, албан хаагчдадаа сануулдаг, тэдгээрийг урамшуулж, сайшаадаг эсэхийг баталгаажуулах, хууль зүйн туслалцааг эрт шатанд хэрэгжүүлэх тал дээр аливаа асуудал, алдаа дутагдал гарвал түүний шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, зохистой хариу арга хэмжээ, засан сайжруулах ажлыг зохион байгуулах арга механизмтай болох мөн түүнийг хянадаг, мониторинг хийдэг байх ёстой талаар шаарддаг. 2017 оны ЭХХШТХ болон 2002 оны ЭБШТХ-д энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй, тодорхойгүй байна.

Дээрхийг дүгнэвэл, сэжигтэн, яллагдагч зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нарын эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийн талаарх хуулийн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа үндсэн шалтгаануудын тухайд 1-рт материаллаг хэмжээний зохицуулалт байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэх механизм тодорхойгүй, журам хангалтгүй, 2-рт хууль сахиулах байгууллагын ажилтнуудын зүгээс хуульчлагдсан хэм хэмжээг зохистой байдлаар хэрэгжүүлдэггүй, 3-рт нөгөө талаас сэжигтэн, яллагдагч нарын зүгээс хуульд заасан эрх, боломжийг ашиглаж чаддаггүй, энэ талаарх мэдлэг, мэдээлэл байдаггүйтэй холбоотой гэж дүгнэж байна.

Хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрх практикт бодитоор хэрэгжих эсэх нь цагдаагийн байгууллагын ажилтан, мөрдөгч нартай шууд хамааралтай ба энэ утгаараа цагдаа, мөрдөгч нарын үүрэг, оролцоо маш өндөр.

Зөвлөмжид дурдсанаар цагдаагийн байгууллагын ажилтан, мөрдөгч нарын үүрэг, оролцоо нь сэжигтэн, яллагдагч нар / ялангуяа, эмзэг бүлгийн хүмүүс болон насанд хүрээгүй хүүхдүүд/ ойлгогдохуйц агуулга бүхий форм, загварын дагуу хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхээ сануулах, мэдэгдэх ажиллагаа хийлгүүлсэн эсэхийг баталгаажуулах, сэжигтэн, яллагдагч хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх, хэрхэн эдлэх талаар өөрийн сайн дурын үндсэн дээр, аливаа дарамт, шахалт, нөлөөлөл байхгүйгээр шийдвэр гаргасан эсэхийг баталгаажуулах, сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлэх этгээд, өмгөөлөгчид нэн даруй, хоцролт, хугацаа алдалгүйгээр мэдэгдэх /сэжигтэн, яллагдагч хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэхээр хүссэн үед/, Хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэхийг хүссэн сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх бүх нөөц бололцоо, нөхцөл байдлыг хангаж, дэмжиж өгөх байдлаар илэрнэ.

Дээр дурдсан цагдаагийн байгууллагын ажилтан, мөрдөгчийн үүрэг, оролцоог бодит болгон хэрэгжүүлэх, хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрхийг бүрэн хангахын тулд цагдаагийн байгууллагын ажилтан, алба хаагчид, мөрдөгч болон бусад холбогдох эрх бүхий субъектүүд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

1. Сэжигтэн эсвэл яллагдагч нь насанд хүрээгүй этгээд / хүүхэд/ үү, бусад эмзэг бүлгийн хүн үү гэдгийг тодорхойлох.
2. Сэжигтэн, яллагдагч нарт хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхтэй талаар мэдэгдэх, сануулах.

1.2.1. Сэжигтэн, яллагдагч нарт хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхтэй талаар мэдэгдэх, сануулах хүрээнд

Сэжигтэн, яллагдагч нарт хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхтэй талаар мэдэгдэх, сануулах процесс нь дараах байдлаар хийгдэх хэрэгтэй. Үүнд:

- a) Хэзээ эрхийг сануулах, мэдэгдэх вэ?
- b) Хэн эрхийг сануулж, мэдэгдэх вэ?

- c) Хэнд хандаж эрхийг сануулж, мэдэгдэх вэ?
- d) Хэрхэн, яаж эрхийг сануулж, мэдэгдэх вэ?
- e) Эрхийн сануулалт, мэдэгдлийн үг үсэг ямар байх?
- f) Ямар агуулга, ямар утга эрх сануулсан бичиг, мэдэгдэлд агуулагдсан байх ёстой вэ?

(А)-ын тухайд зарчмын хувьд сэжигтнийг баривчилсны дараа нэн даруй, эсвэл цагдаагийн хэлтэс, саатуулах байранд сэжигтнийг авчирсны дараа тэр даруй. Мөн сэжигтэнтэй холбогдуулан аливаа хэлбэрээр мөрдөн шалгах ажиллагааг эхлэх буюу тухайлбал мэдүүлэг, тайлбар авахаас өмнө. (В)-ын тухайд хэрэг хариуцсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хэрэгтнийг баривчилж, саатуулсан, эрх бүхий албан тушаалтан, цагдаагийн байгууллагын албан хаагч. (С)-ын тухайд эрхийн талаарх сануулалт, мэдэгдэл нь үргэлж сэжигтэн, яллагдагч тухайн этгээдэд хандсан байна. Зарим тохиолдолд, насанд хүрээгүй хүүхэд болон бусад эмзэг бүлгийн субъектийн төлөөлөл рүү хандаж, чиглэсэн байж болно. (D)-ын тухайд амаар болон бичгээр гэсэн 2 хэлбэрээр хоёулангаар нь. (E)-ын тухайд ерөнхийдөө энгийн, ойлгомжтой агуулга бүхий байх хэрэгтэй. Мэдэгдэл, эрхийн сануулсан бичиг бичигдсэн хэлийг ойлгодоггүй, уншиж чаддаггүй, ярьж чаддаггүй этгээдэд зориулж тусгай нөхцөл, хэлбэрээр мэдэгдэл, эрх сануулсан бичгийг үйлдэнэ. (F)-ын тухайд тухайн улсын онцлог, хууль, эрх зүйн тогтолцоо, зохицуулалтаас шалтгаалаад эрх сануулсан бичиг, мэдэгдлийн агуулга өөр өөр байж болно. Дундаж стандарт агуулгын хувьд, хууль зүйн зөвлөгөө, туслалцаа авах эрхийн талаарх мэдээлэл, мөн тус зөвлөгөө, туслалцаа нь нууцлалаар баталгаажсан, хараат бус нөхцөл байдалд олж авах боломжтой, хууль зүйн туслалцаа авах үндсэн суурь эрх, яг ямар субъект хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тухайн туслалцаа, зөвлөгөө нь хэрхэн, яаж өгөгдөх гэх зэрэг асуудлууд тусгагдсан байх хэрэгтэй. Хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрх сануулсан бичиг, мэдэгдэл нь өөр бусад эрхүүд /тухайлбал, дуугүй байх гэх мэт/-ийн талаар хамтад нь сануулсан, мэдэгдсэн байж болно.

2017 оны ЭХХШтХ-ын холбогдох заалтуудыг үзвэл дээрх (А), (В), (С), (D)-ын тухайд тодорхой хэмжээнд хуульчлагдсан, шаардлагыг хангах боломжтой гэж үзэх боломжтой. Мөн, (Е) болон (F)-ийн тухайд ЭХХШтХ-ийн 31.7 дугаар зүйлд мөрдөгч сэжигтнийг баривчлахдаа ямар агуулгаар тэмдэглэл үйлдэж бэхжүүлэх талаар тусгасан байгаа ба энэ нь зөвлөмжид заасан тэмдэглэл, бүртгэл нь дараах асуудлуудыг зайлшгүй тусгасан байх шаардлагыг хангасан гэж үзэж болно. Зөвлөмжид дурдсанаар сэжигтнийг баривчлах үйлдэх тэмдэглэл, бүртгэл нь дараах асуудлуудыг тусгасан байх ёстой. Үүнд:

- I. Баривчилгаа хийсэн цаг хугацаа, газар байршил, баривчлах үндэслэл, шалтгаан
- II. Саатуулсан, хорьсон цаг хугацаа, газар байршил, баривчлах үндэслэл, шалтгаан
- III. Сэжигтэн, яллагдагч нь насанд хүрээгүй этгээд, бусад эмзэг бүлгийн хүн аль нь болох, өөр тусгай ямар хэрэгцээ, шаардлага, асуудал байгааг тогтоохын тулд авагдсан арга хэмжээний талаарх цаг хугацаа, өдөр, орон байршил, мөн тухайн тогтоосон үр дүн, авагдсан арга хэмжээний үр дүн
- IV. Сэжигтэн, яллагдагчид түүний эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг нь сануулсан, мэдэгдсэн цаг хугацаа, газар байршил, мөн хамтад нь сануулсан, мэдэгдсэн бусад мэдээлэл
- V. Хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхээ эдлэх эсэх, хэрхэн эдлэх, хэрэгжүүлэх талаар гаргасан сэжигтэн, яллагдагч нарын шийдвэр, тухайн шийдвэр гарсан өдөр, цаг, байршил
- VI. Хэрэв сэжигтэн, яллагдагч өөрийн хууль зүйн туслалцаа авах эрхээ эрт шатанд эдлэх талаар шийдвэр гаргасан бол тус шийдвэрийг хэрэгжүүлэх, бодит болгох талаар авсан арга хэмжээ, түүнд хамаарах цаг хугацаа, өдөр хоногийн талаар
- VII. Сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх субъекттэй анхлан холбоо барьсан,

холбогдсон цаг хугацаа болон тус хууль зүйн туслалцаа үзүүлэгч хэргийн газар, цагдаагийн хэлтэс, баривчлах, саатуулах байранд хүрэлцэн ирсэн цаг хугацааны талаарх мэдээлэл

- VIII. Хууль зүйн туслалцаа үзүүлэгч болон сэжигтэн, яллагдагч хоёрын бүх уулзалт хийсэн цаг хугацааны талаарх мэдээлэл
- IX. Хууль зүйн туслалцаа үзүүлэгч өмгөөлөгч, хуульч нарыг байлцуулан хийсэн бүх тайлбар, мэдүүлэг авах мөрдөн шалгах ажиллагааны өдөр цаг, үргэлжилсэн хугацаа
- X. Хуульч, өмгөөлөгч зэрэг хууль зүйн туслалцаа үзүүлэх хүн байхгүй үед хийсэн байцаалтын үндэслэл, шалтгаан, тухайн байцаалтыг хийхийг хүлээн зөвшөөрсөн сэжигтэн, яллагдагчийн зөвшөөрөл, мөн цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл

Гэвч, өмгөөлөгч, прокурор, мөрдөгч нарын дунд явуулсан судалгааны үр дүнгээс харахад тодорхой, нэгдсэн нэг стандарт, утга агуулгын үг хэллэг, формат, хэлбэр тодорхойгүй байдалтай байгаа буюу зарим тохиолдолд амаар сануулаад өнгөрдөг, зарим тохиолдолд огт сануулдаггүй, эрх сануулах ажиллагаа хийгдсэн байлаа гэхэд тэдгээрийг тэмдэглэж, бүртгэлжүүлэх асуудал янз бүр буюу хуульд заасан ажиллагаа бүрэн хийгддэггүй гэсэн дүгнэлтийг хийж болно /Хавсралт графикуудыг үзнэ үү/.

- Мөн, зөвлөмжид дараах асуудлуудыг цагдаагийн байгууллагын ажилтан, мөрдөгч нарт үүрэг болгосон байдаг.
- Сэжигтэн, яллагдагч хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар сайн дураараа, өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр, аливаа дарамт, шахалтгүйгээр шийдвэр гаргах боломжийг бий болгож өгөх.
- Хууль зүйн туслалцаа үзүүлэх субъект, өмгөөлөгч, хуульч нартай холбогдох, холбоо тогтоох: Цагдаагийн байгууллагын зүгээс хууль зүйн туслалцаа үзүүлэх хүнтэй хэрхэн холбогдох, холбоо тогтоох, мэдээлэл өгөх талаар

маш тодорхой журам, процедуртай байх ёстой. Тус журам, процедур нь цагдаагаас хууль зүйн туслалцаа үзүүлэгчтэй цаг алдалгүй, түргэн шуурхай холбогдох үүргийг тодорхой тусгасан байх нь чухал. Хууль зүйн туслалцаа үзүүлэгчтэй холбогдох, холбоо тогтоох журам, процессыг хууль зүйн туслалцаа үзүүлэгч этгээдүүд, энэ чиглэлийн байгууллагууд, өмгөөлөгч, хуульч нартай зөвлөлдсөний үндсэн дээр тогтоох нь үр дүнтэй.

- Хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор мөрдөн шалгах ажиллагаанд тавигдах зарим нэгэн хязгаарлалт: Сэжигтэн, яллагдагч нь эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх талаар байр сууриа илэрхийлж, энэ эрхийг эдлүүлэх ажиллагаа нэгэнт эхэлсэн бол хууль зүйн туслалцаа үзүүлэх хүн, өмгөөлөгч хуульч хараахан хүрэлцэн ирж амжаагүй, байхгүй тохиолдолд тайлбар, мэдүүлэг авах зэрэг мөрдөн шалгах ажиллагааг явуулж болохгүй. Гэхдээ, хуульд заасан үндэслэлээр, шаардлагатай тохиолдолд өмгөөлөгч, хуульч гэх мэт хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх этгээд байхгүй байсан ч мөрдөн шалгах ажиллагааг эхэлж болно.
- Хууль зүйн туслалцаа үзүүлэгчийг холбогдох мэдээллээр хангах: Цагдаагийн байгууллагын зүгээс сэжигтэн, яллагдагчийг баривчлах, саатуулах болсон шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаарх мэдээллийг хуульч, өмгөөлөгч бусад хууль зүйн туслалцаа үзүүлж буй этгээдэд өгнө. Мөн хуульд заасан, хуулиар шаардсан бол холбогдох мэдээллийг мөн өгөх үүрэгтэй.
- Цагдаагийн байгууллагын зүгээс хууль зүйн туслалцаа үзүүлэгч сэжигтэн, яллагдагч буюу өөрийн үйлчлүүлэгчтэй ганцаарчлан, нууцын дор, хараат бусаар уулзах, зөвлөлдөх боломжийг хангах ёстой.
- Цагдаагийн байгууллага, ажилтан, албан хаагч нарын зүгээс сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлж буй хуульч, өмгөөлөгч нарт дарамт, шахалт, хуульд харшлах шаардлагыг тавихыг хориглоно.

1.3 Прокурорын оролцоо

Зөвлөмжид зааснаар прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, мөрдөгч, цагдаагийн ажилтны үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх дээр хяналт тавих үүрэгтэй ба энэ утгаараа хэрэг үдэгдээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас прокурор дээр ирэх, шүүх хуралдаан эхлэх хүртэл сэжигтэн, яллагдагчид хууль зүйн туслалцаа авах эрхийг эрт шатанд бүрэн эдлүүлэх тал дээр прокурорын оролцоо хязгаарлагдмал. Прокурорын үндсэн оролцоо гэвэл сэжигтэн яллагдагч нарын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хууль зүйн туслалцаа авах эрх цагдаагийн байгууллагын ажилтан, мөрдөгч нараар хангагдсан эсэхийг хянаж, баталгаажуулах явдал юм. Үүний тулд, прокурор нь дараах арга хэмжээг авах ёстой.

Үүнд:

1. Сэжигтэн, яллагдагчийн хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой цагдаагийн байгууллага, мөрдөгч нарын зүгээс яг ямар ямар арга хэмжээ авагдсан, ямар ямар үйл ажиллагаа хийгдсэн эсэх дээр анхаарлаа хандуулах.
2. Сэжигтэн, яллагдагч болон тэдгээрийн өмгөөлөгч, хууль зүйн туслалцаа үзүүлэгч субъектүүдийн зүгээс хууль зүйн туслалцаа авах эрх хэрэгжиж чадсангүй, бүрэн биелэгдсэнгүй гэж гомдол, санал хүсэлт гарсан тохиолдолд энэ талаар хянах, шалгах.
3. Сэжигтэн, яллагдагчийн эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрх хэрэгжээгүй, хэрэгжихгүй байсаар байгаа бол тэнд шаардлагатай, зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ингэхдээ тухайн сэжигтэн, яллагдагч өөрийн эрхийн талаар мэдэгдэл, санамж, сануулга авсан эсэх, тус эрхийг нь цаг алдалгүйгээр хэрэгжүүлэхэд нь туслалцаа, дэмжлэг үзүүлсэн эсэхийг баталгаажуулж, хянах.

Дээр дурдсан оролцоог бодит болгон хэрэгжүүлэх, хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрхийг бүрэн хангахын тулд прокурорууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрх хэрэгжсэн эсэхийг шалгах

Прокурор нь эхний шүүх хуралдаанаас өмнө урьдчилж, өөрийн хүлээн авсан хэрэг дээр, өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагын ажилтан, мөрдөгч нарын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг дээр дараах асуудлуудыг хянаж, шалгах хэрэгтэй.

- a) Сэжигтэн, яллагдагчид түүний хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхийг цагдаа, мөрдөгч нар хангалттай сануулсан, мэдэгдсэн эсэх
 - b) Сэжигтэн, яллагдагч өөрийн эрхээ хэрэгжүүлэх эсэх дээр шийдвэр гаргасан эсэх
 - c) Сэжигтэн, яллагдагчийг хууль зүйн туслалцаа үзүүлэх этгээдтэй холбох, холбоо тогтооход яг ямар ямар ажиллагаа хийгдсэн эсэх, хууль зүйн туслалцаа үзүүлэгч этгээдтэй ер нь холбож, холбоо тогтоож өгсөн эсэх
- Сэжигтэн, яллагдагчийн хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхийн зөрчил байсан буюу хэрэгжиж чадаагүй, хангалттай хэрэгжиж чадалгүй зөрчигдсөн гэдгийг олж тогтоосон нотолгоо, нотлох баримт байгаа эсэхийг анхаарч үзэх
 - Сэжигтэн, яллагдагч өөрийн хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхээ хэрэгжүүлэх эсэх дээр ямар нэгэн дүгнэлт, шийдвэр гаргах ёсгүй буюу түүнд саад, шахалт үзүүлж болохгүй
 - Тогтолцооны эсвэл байнгын шинжтэй, тогтмол гардаг алдаа дутагдлыг засах, залруулах: Прокурорын зүгээс цагдаагийн байгууллагын ажилтан, албан хаагч, мөрдөгч, хорих, саатуулах эрх бүхий этгээдүүд сэжигтэн, яллагдагч нарын хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхийг хэрэгжүүлээгүй, хангалттай хэрэгжүүлэлгүй зөрчсөн гэдгийг мэдсэн тохиолдолд, тус зөрчлийг тухайн цагдаа, мөрдөгч, бусад хууль сахиулах албан хаагч нарын шууд удирдлага буюу ахлах, тэргүүлэх үүрэгтэй эрх бүхий

субъектүүд /тухайлбал, цагдаагийн ахлах офицер, хууль сахиулах төрийн захиргааны төв байгууллага гэх мэт/-д мэдэгдэж, зохих арга хэмжээг авах ёстой.

2017 оны ЭХХШТХ-ийн Дөрөвдүгээр зүйлд прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан энэ хуулийг хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, хууль зөрчсөн шийдвэрийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгож, хариуцлага тооцуулах талаар ерөнхий хүрээнд эрх мэдлийг олгосон боловч, сэжигтэн, яллагдагч эрт шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангуулах чиглэлээр нарийвчилсан зохицуулалт байхгүй. Зөвлөмжийн хүрээнд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангуулах ажиллагааг шууд гардан гүйцэтгэх мөрдөгч, цагдаагийн байгууллагын ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих, баталгаажуулах гэдгийг шаардах боловч шинэ процессын хуулиар прокурорын ерөнхий эрх, үүргийг зааж өгөхдөө энэ талаар тухайлан зохицуулж чадаагүй нь дутагдалтай тал болж байна.

1.4. Шүүгч, шүүх байгууллагын оролцоо

Хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрхийг хангах асуудал дээр шүүгчийн гүйцэтгэх үндсэн үүрэг, оролцоо нь цагдаагийн байгууллага, мөрдөгч нар /шаардлагатай тохиолдолд, улсын яллагч, прокурорууд/ тус эрхийг хэрэгжүүлсэн үү, хэрэв хэрэгжээгүй буюу эрх нь зөрчигдсөн бол тэнд ямар арга хэмжээ, засан залруулах ажил хийгдсэн бэ гэдгийг хянах, баталгаажуулах явдал гэж ойлгож болно. Хууль зүйн туслалцаа үзүүлэх субъект, түүний төлөөлөгч, өмгөөлөгчгүйгээр сэжигтэн, яллагдагчийг баривчлах, бусад таслан сэргийлэх арга хэмжээ авах талаарх шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хэрэгтнийг авчирсан тохиолдолд, шүүгч тус этгээд өөрийн хууль зүйн туслалцаа авах эрхийн талаар мэдэж, ойлгож байгаа эсэх, энэ талаар нь сануулсан эсэхийг асууж тодруулах, шалгах хэрэгтэй ба хэрэв тус этгээд өөрийн эрхээ хэрэгжүүлэх, эдлэхийг хүсвэл нэн даруй хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчтэй холбож, холбогдох ажиллагааг авч хэрэгжүүлэх ёстой.

Үүний тулд шүүгч нар дараах үүрэг, хариуцлагыг ухамсарлаж ажиллах хэрэгтэй. Үүнд:

- Сэжигтэн, яллагдагчийг саатуулах, хорих талаар таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдэх шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр хэрэгжүүлэх Шүүгчийн үүрэг: Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт яллагдагч өөрт нь хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх, хуулийн үйлчилгээ авах субъекттэй хамт байх ёстой ба үүнийг нь шүүгч хангаж өгөх, баталгаажуулах, хэрэгжүүлэх талаар үүрэг хүлээнэ. Хэрэв яллагдагч өөрийг нь хорих, саатуулах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шийдэх шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгч, хуульч болон бусад этгээдгүй ирвэл, Шүүгч яллагдагч, сэжигтэнд түүний хууль зүйн туслалцаа авах эрхийг сануулах ёстой ба сэжигтэн, яллагдагчийг өөрийн эрхээ эдлэх эсэх талаар сайн дурын үндсэн дээр шийдвэр гаргах бололцоогоор хангах үүрэгтэй. Яллагдагч, сэжигтэн этгээд өөрийн эрхээ эдлэх талаар шийдвэр гаргавал Шүүгч нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулна.
- Сэжигтэн, яллагдагч нь хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхээ эдэлсэн эсэх, тус эрхийг хууль сахиулах байгууллагын зүгээс хангаж өгсөн, хэрэгжүүлсэн эсэхийг хянаж шалгах: Хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт, мэдээлэл, цагдаа, мөрдөн шалгах эрх бүхий этгээдүүдийн байцаалт зэргийг үндэслэн Шүүгч нь сэжигтэн, яллагдагчид тэдгээрийн хууль зүйн туслалцааг эрт шатанд авах эрхийг хангалттай сануулсан, мэдэгдсэн эсэх, сэжигтэн, яллагдагч эрхээ эдлэхээр шийдсэн тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгч, хуульчтай холбож өгсөн эсэх, эрхээ эдлэх тал дээр туслалцаа, дэмжлэг үзүүлсэн эсэхийг олж тогтоох хэрэгтэй. Мөн нөгөө талаас Шүүгч нар цагдаа, мөрдөгч, мөрдөн шалгах эрх бүхий ажилтнууд сэжигтэн, яллагдагч нарын хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхийг санаатайгаар эдлүүлэхгүйн тулд авч хэрэгжүүлсэн арга ажиллагаа /угаас эрхийг хэрэгжүүлэх боломжгүй процедур, захиргааны ажиллагааны дор баривчлах, мөрдөн

шалгах ажиллагаа явуулж байна гэж хандах, албан бус буюу хэлбэр төдий баривчилгаа, саатуулалт гэж сэжигтэн, яллагдагчид ойлгуулах гэх мэт/ байсан зэргийг олж мэдэх нь чухал ба түүнд тохирсон, алдааг засах хариу арга хэмжээг авах ёстой.

- Шүүгчийн зүгээс сэжигтэн, яллагдагч өөрийн хууль зүйн туслалцаа эрт шатанд авах үндсэн эрхээ эдлэх, энэ талаар шийдвэр гаргахад ямар нэгэн байдлаар шахалт үзүүлэх, нөлөөлөх гэж оролдох, эрхээ эдлэх тал дээр ямар нэгэн дүгнэлт, шийдвэр гаргаж болохгүй.
- Хэрэв хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхээ Яллагдагч эдэлж чадаагүй, хангалттай эдлээгүй, хууль сахиулах байгууллага буюу цагдаа, мөрдөгч, прокурорын зүгээс эрхийг хэрэгжүүлээгүй, хангаж өгөөгүйн улмаас тус эрх зөрчигдсөн тохиолдолд, тухайн зөрчлийг арилгах, нөхөн залруулах зохистой арга хэмжээ авах асуудлыг тогтоож, шийдвэрлэх: Хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрх зөрчигдсөн тохиолдолд яригдах шүүгчийн хариу үйлдэл, авах арга хэмжээ нь бодит практикт тус эрх тогтмол хэрэгжих эсэх дээр маш чухал нөлөөтэй юм.
- Тогтолцооны болон байнгын шинжтэй алдаа, дутагдал, зөрчлүүдийг засах, зохицуулах: Шүүгчийн зүгээс цагдаагийн байгууллагын ажилтан, албан хаагч, мөрдөгч, хорих, саатуулах эрх бүхий этгээдүүд, мөн прокурор нар нь сэжигтэн, яллагдагч нарын хууль зүйн туслалцаа эрт шатанд авах эрхийг хэрэгжүүлээгүй, хангалттай хэрэгжүүлэлгүй зөрчсөн гэдгийг мэдсэн тохиолдолд, тус зөрчлийг тухайн прокурор, цагдаа, мөрдөгч, бусад хууль сахиулах албан хаагч нарын шууд удирдлага буюу ахлах, тэргүүлэх үүрэгтэй эрх бүхий субъектүүд /тухайлбал, ахлах прокурор, цагдаагийн ахлах офицер, хууль сахиулах төрийн захиргааны төв байгууллага гэх мэт/-д мэдэгдэж, зохих арга хэмжээг авах ёстой.

2017 оны ЭХХШТХ-ийн 35.6 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “Шүүгдэгч, хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх хангагдсан эсэхийг тодруулна” хэмээн тодорхой хуульчилж өгсөн нь 2002 оны ЭБШТХ-ийн 260 дугаар зүйлийн 260.1 дэх хэсэгт “Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, шинжээч нарт энэ хуулийн 36, 42-44, 46-д заасан эрх, үүргийг тайлбарлаж өгнө” гэсэн зохицуулалтаас нэг алхам урагшилсан буюу хууль зүйн туслалцаа авах эрх хэмээн тодотгон өгч, хууль зүйн техник, бүтцийн хувьд хэрэгжих үр дагавар өндөртэй зохицуулалт болсон байна.

ХАВСРАЛТ-2

СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

График-1. Шүүгч нараас авсан судалгаа

Аль үеэс эхлэн хууль зүйн туслалцаа авдаг талаар




График-2. Шүүгч нараас авсан судалгаа

Эрүүгийн процессын хууль дахь ХЗТ авах эрхийн зохицуулалт хангалттай эсэх




График-3. Шүүгч нараас авсан судалгаа

ХЗТ авах эрхийг эрт шатнаас авах боломжоор хангаж байгаа эсэх




График-4. Прокурорундаас авсан судалгаа

Эрт шатнаас ХЗТ авах эрх хангагдахгүй байгаа шалтгаан




График-5. Прокуроруудаас авсан судалгаа

ХЗТ аваггүй тохиолдолд хийдэг прокурорын ажиллагаа




График-6. Прокуроруудаас авсан судалгаа

ХЗТ авах эрхийг аль шатнаас эдлүүлэх ёстой гэж үздэг вэ?




График-7. Прокуроруудаас авсан судалгаа

Өмгөөлөгч авах хүсэлтэй хэргийн оролцогчид ямар арга хэмжээ авдаг талаар




График-8. Мөрдөгч нараас авсан судалгаа

ХЗТ авах эрхийг сануулах ажиллагаа аль үе шатанд хийгддэг талаар




График-9. Өмгөөлөгч нараас авсан судалгаа

ХЗТ авах эрхээр хангаж буй байдал




График-10. Өмгөөлөгч нараас авсан судалгаа

ХЗТ авах эрхийг сануулж ямар ажиллагаа хийдэг талаар

